Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар

ОРХОН АЙМАГ, ЭРДЭНЭТ ХОТЫН 2023 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2023 он

№	Бодлогын үндэслэл	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		Зарцуулсан хөрөнгийн хэмжээсая.төг	Хөрөнгийн эх үүсвэр	Үндсэн хариуцагч	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
				Суурь түвшин	Зорилтот түвшин					
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
НЭГ.ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ										
Зорилт 1.1. Эх хэл, уламжлалт зан заншил, түүхээ дээдэлсэн, хотын соёлыг тээгч, зөв хүн болгон төлөвших үйл ажиллагааг иргэдийн дунд олон талт хэлбэрээр зохион байгуулна:										
1.	ТЖҮЧ 1.1.1 ЗДҮАХ 3.2.2	Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг гэрээгээр хамгаалах өрхийн тоог нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн хяналт оролцоог сайжруулах	Түүх соёлын үл хөдлөх дурсгалын хяналт оролцоог сайжруулна.	20 өрх гэрээгээр хамгаалж байгаа.	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хамгаалалт тогтмолжино.	4.0	Орон нутгийн төсөв	НБХ	Түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг гэрээгээр хамгаалж буй 12 айл өрхтэй гэрээг шинэчлэн байгуулж, гэрээгээр хамгаалах бүсчлэлийг шинэчилсэн. 2022 оноос гэрээгээр хамгаалах өрхүүдийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр 20 өрхтэй гэрээ байгуулж нийт 343 түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулсан. 2023 онд дээрх өрхүүдтэй гэрээг сунгаж, харьяалах нутаг дэвсгэрт орших түүх, соёлын үл хөдлөх 28 дурсгалт газрын 343 булш, оршуулгын дурсгалын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг үргэлжлүүлж байна.	100
2.	ТЖҮЧ 1.1.2 ЗДҮАХ. 3.1.3	ЕБ-ын сургуулиудад эх орон, эв нэгдэл, үнэт зүйл, хотын соёл, зөв зан үйл, дадал хэвшлийг эзэмшүүлэх агуулга бүхий орон нутгийн онцлогтой сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хөтөлбөр хэрэгжсэн байна.	Орон нутгийн онцлогтой сургалтын хөтөлбөр боловсруулсан.	Хөтөлбөр хэрэгжүүлнэ.	-	-	НБХ БШУГ	"Түүхэн тэмдэглэлт өдрүүд" сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжилтийг хангаж байна. Уг хөтөлбөр нь "Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр", "Монгол бахархлын өдөр", "Эрдэнэт хотын өдөр", "Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр" гэсэн 4 дэд хэсгээс бүрдсэн бөгөөд 2023-2024 оны хичээлийн жилд үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн. Мөн сурагчдыг байгаль орчноо хамгаалах, багаар ажиллах чадварт сургаж, тогтвортой хөгжлийн боловсрол олгох, хүүхдийн сонирхол, авьяасыг нээн илрүүлэх зорилготой "Би Монгол хүн" хөтөлбөрийг боловсруулж 5-р ангид "Миний Эрдэнэт хот", 6-р ангид "Миний хот - Бидний түүх", 7-р ангид "Бидний өв соёл- Миний хот", 8-р ангид "Эко аялал - Интеграци хичээл", 9-р ангид "Бидний өв соёл - Би монгол хүн", 10-р ангид "Мэргэжил сонголт", 11-р ангид "Эх оронч аялал-Орон нутаг судлал" гэсэн 7 агуулгын хүрээнд хэрэгжүүлж байна.	100
3.	ТЖҮЧ 1.1.2 ЗДҮАХ 3.1.3	Түүхэн тэмдэглэлт өдрүүд болон Эрдэнэт хотын өдрөөр ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад тусгай хөтөлбөрөөр хичээл заах	Түүхэн тэмдэглэлт өдрүүдээр тусгай хөтөлбөрүүдээр хичээл заасан байна.	3 хөтөлбөр хэрэгжсэн.	3 хөтөлбөр хэрэгжинэ.	-	-	НБХ БШУГ	ЕБС-ийн суралцагчдад эх орон, эв нэгдэл, үнэт зүйлээрээ бахархах үзэл төлөвшүүлэх, амьдран суугаа орон нутгаараа бахархах, хотын соёл, зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэх зорилго бүхий "Түүхэн тэмдэглэлт өдрүүд" сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжилтийг хангаж байна. Уг хөтөлбөр нь "Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр", "Монгол бахархлын өдөр", "Эрдэнэт хотын өдөр", "Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр" гэсэн 4 дэд хэсгээс бүрдсэн бөгөөд 2023-2024 оны хичээлийн жилд үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.	100
Зорилт 1.2. Байгууллага, иргэдийн дунд үндэсний монгол хэл, бичгээ эзэмших, ашиглах, сурталчлах ажлыг хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулна.										
4.	ТЖҮЧ 1.2.2 ЗДҮАХ 3.1.3 ЗДҮАХ 3.2	“Эх хэл-Эрдэнэт” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг зохион байгуулж,	Хөтөлбөрийн хүрээнд тухайн жилд төлөвлөсөн үйл ажиллагаан	Хөтөлбөрийн хүрээнд тухайн жилд төлөвлөсөн үйл ажиллагаан	23.0	Орон нутгийн төсөв	НБХ БШУГ	“Эх хэл-Эрдэнэт” хөтөлбөрийг 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 28 үйл ажиллагаатайгаар батлуулж хэрэгжилтийг хангаж ажилласан. Хөтөлбөрийн хүрээнд “Үндэсний бичиг үсгийн баяр -2023” арга хэмжээ, 9 дүгээр ангийн Монгол хэлний хичээлийн анги нийтийн уралдаан, “Амьд бичиг” уран бичлэгийн уралдаан, ЕБС-ийн 12 дугаар ангийн сурагчдын дунд “Үндэсний бичгийн үсэглэлийн аварга шалгаруулах	90

			хэрэгжүүлсэн байна.	ы хэрэгжилт 100 хувь	ы хэрэгжилт 100 хувь				уралдаан", Монгол бичгийн захиалгат сургалтууд зэрэг арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан.	
Зорилт 1.3. Иргэд, хүүхэд, залуучуудыг нийгмийн ёс зүйг дээдэлсэн, өөрийн хотын үнэт зүйлсээр бахархдаг, эерэг харилцаа, хандлага бүхий ухамсарт зан үйлд суралцуулна.										
5.	ТЖҮЧ 1.3.1 ЗДҮАХ 3.2.1	Соёл, урлагийн байгууллагуудын ажилтан, уран бүтээлчдийн төсөл боловсруулж, хэрэгжүүлэх	Соёл, урлагийн салбарын ажилтан албан хаагчдыг чадавхжуулах, санал санаачилгыг дэмжсэн байна.	-	Хөтөлбөр боловсруулагдаж, хэрэгжүүлнэ.	23.5	Орон нутгийн төсөв	СУГ НБХ	Тайлант хугацаанд аймгийн Хүүхэд залуучуудын театрт "Хүүхэлдэйн урлагийн их наадам"-д 2.5 сая, мэргэжлийн нүүр хувиргалтын сургалтын зардалд 2.0 сая, Өмнөговь аймагт хийсэн аялан тоглолтын зардалд 3.2 сая, Дундговь аймгийн Их газрын чулуунд тоглосон тоглолтод 4.0 сая, аймгийн Нийтийн номын сангийн албан хаагчдыг Сүхбаатар аймагт ажил мэргэжлийн болон спортын уралдаанд оролцоход 2.5 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн. Соёлын салбарын албан хаагчдын дунд зохион байгуулагдсан "Соёлынхон" спортын тэмцээнд 1.5 сая, "Бэсрэг наадам"-ын арга хэмжээнд 5.0 сая, "Соёлын ажилтны өдөр"-ийн арга хэмжээнд 1.9 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн байна. Соёл, урлагийн салбарын ажилтан албан хаагчдыг чадавхжуулах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр 2023 оны орон нутгийн төсөвт 20.0 сая төгрөг батлагдсан бөгөөд батлагдсан төсвийн хүрээнд сургалт, бусад үйл ажиллагаануудыг зохион байгуулагдаж байна. Соёл, урлагийн салбарын ажилтан албан хаагчдыг чадавхжуулах, гаргасан санал, санаачилгыг дэмжиж тодорхой асуудлуудыг шийдвэрлэж байгаа тул соёл, урлагийн салбарт чиглэсэн хөтөлбөр боловсруулах шаардлагагүй гэж үзсэн.	70
6.	ТЖҮЧ 1.3.1 ЗДҮАХ 3.2 ЗДҮАХ 3.1.2	Наран багийн соёлын төвийн барилгын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн үргэлжлүүлэх	Барилгын ажилд ахиц гарсан байна.	Барилгын ажил зогссон.	Барилгын ажлыг үргэлжлүүлнэ.	-	Улсын төсөв	БШУГ	Улсын төсвийн 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдаж байсан Наран багийн соёлын төвийн барилгын ажил 82%-ийн гүйцэтгэлтэй зогссон бөгөөд 2023 оны төсөвт суулгуулахаар саналаа өгсөн боловч шийдэгдээгүй, 2024 оны төсөвт тусгуулахаар ажиллаж байна. Барилгын хөгжлийн төвд магадлал хийлгэхээр өгсөн.	50
7.	ТЖҮЧ 1.1.3 ЗДҮАХ 3.2.1	Улсын хэмжээний шилдэг уран бүтээлийг орон нутгийн иргэдийн хүртээл болгоход дэмжлэг үзүүлэх	Шилдэг уран бүтээлийг иргэдийн хүртээл болгосон байна.	-	1 уран бүтээлд дэмжлэг үзүүлнэ.	20.0	Орон нутгийн төсөв	НБХ	2023 онд "Соёлыг түгээе" аяны хүрээнд Монгол улсын филармонийн тоглолтыг орон нутгийн иргэдийн хүртээл болгосон.	100
8.	ТЖҮЧ 1.1.1 ЗДҮАХ 3.2.2	Айргийн гозгорын археологийн малтлагыг үргэлжлүүлэн хийж аймгийн Музейн үзмэрийн сан хөмрөгийг баяжуулах	Музейн үзмэр нэмэгдсэн байна.	-	Археологийн олдвороор аймгийн Музейн үзмэр нэмэгдсэн байна.	-	Улсын төсөв	НБХ	Соёлын яамнаас олгосон зөвшөөрлийн дагуу Монгол Үндэсний Музей, БНХАУ-ын Ардын Их сургуультай хамтран Жаргалант сумын айргийн гозгорын дурсгалт газар 2023 оны 06 дугаар сарын 18-наас 07 дугаар сарын 11-нийг дуустал 3 дурсгалд малтлага судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг малтлагаас гарсан 2 ширхэг вааранд судалгаа, шинжилгээний ажил хийж, бүртгэлжүүлсэн.	70
ХОЁР. ЭРҮҮЛ, БҮТЭЭЛЧ, ХӨГЖИХ ТЭМҮҮЛЭЛТЭЙ-ЭРДЭНЭТ ХҮН **Зорилт 2.1.** Боловсролын үйлчилгээг тэгш, чанартай зохион байгуулан, хүртээмжийг нэмэгдүүлнэ:										
9.	ТЖҮЧ 2.1.3 ЗДҮАХ 3.1	Боловсролын салбарын он дамжин хийгдэж буй барилгын ажлуудын гүйцэтгэлийг нэмэгдүүлэх, хүүхдэд ээлтэй орчин бий болгох	Барилгын ажлуудын гүйцэтгэлийг нэмэгдүүлсэн байна.	3 барилгын ажил зогссон.	Зогссон 3 барилгын ажлыг үргэлжлүүлэх	-	Улсын төсөв	ХБТХОХ НБХ	Говил, Рашаант багийн 250 хүүхдийн сургууль, 16-р сургуулийн спорт заалны барилгын ажлууд 70-85 хувийн гүйцэтгэлтэй байгаа ба тодорхой шалтгаанаар барилгын ажил түр зогссон байна. Үүнд: ●Говил багийн 250 хүүхдийн суудалтай сургуулийн барилга улсын төсвөөс 2.0 тэрбум төгрөгийн санхүүжилттэй баригдаж эхэлсэн боловч барилгын материалын үнийн огцом өсөлт, санхүүжилт хүрэлцэхгүй шалтгаанаар зогссон. Тус барилгын үлдэгдэл	50

									санхүүжилт 1.4 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусгахад шаардлагатай нэмэлт баримт, материалуудыг жагсаалтын дагуу гаргаж Үндэсний Аудитын газар, Боловсролын ерөнхий газарт хүргүүлсэн. (гүйцэтгэл 50%) ●Рашаант багийн 250 хүүхдийн суудалтай барилга нь 2.5 тэрбум төгрөгийн өртөгтэй баригдаж эхэлсэн боловч барилгын материалын үнийн огцом өсөлт, санхүүжилт хүрэлцэхгүй шалтгаанаар зогссон. Барилгын газар шороо, суурийн ажил гүйцэтгэсэн, 1-2 дугаар давхрын дам нуруу, хучилтын цутгалтын ажил гүйцэтгэж дуусан. Хана, хамар ханын өрлөгийн ажил, А блокийн гадна пасадны дулаалга хийгдэж шавардлага хийгдсэн. Дээврийн ажил, гадна инженерийн шугам сүлжээний ажил гүйцэтгэгдээгүй үнийн өсөлттэй холбоотой барилгын ажил зогссон байна. Тус барилгын үлдэгдэл санхүүжилт 1.3 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусгахад шаардлагатай нэмэлт баримт, материалуудыг жагсаалтын дагуу гаргаж Үндэсний Аудитын газар, Боловсролын ерөнхий газарт хүргүүлсэн. ●16-р сургуулийн спорт заалны барилга 798.6 сая төгрөгийн гэрээ байгуулж, 519.6 сая төгрөгөөр барилга баригдаж эхэлсэн боловч ажил зогссон. Гүйцэтгэгч компанитай гэрээ цуцалсан. Барилгын ажлыг дуусгахад шаардлагатай 879.0 сая төгрөгийн нэмэлт төсвөөс 2024 оны улсын төсвийн төсөлд 277.0 сая төгрөг тусгагдсан байна.	
10.	ТЖҮЧ 2.1 ЗДҮАХ 3.1	Сургууль болон ашиглалтын насжилт өндөртэй зарим цэцэрлэгүүдийн барилгад засвар хийж, сургалтын орчныг сайжруулах	Засвар хийж, сургалтын орчныг сайжруулсан байна.	7 барилга, байгууламж ид засвар хийсэн	Нэмж 11 барилгад засвар хийнэ.	2,600.0	Орон нутгийн төсөв	НБХ БШУГ	2023 онд орон нутгийн төсвөөс дараах 10 сургалтын байгууллагад 2676.0 сая төгрөгийн засвар үйлчилгээ хийгдсэн. Үүнд: ●Уран эгшиг урлагийн төрөлжсөн сургуульд их засвар хийх 586.7 сая төгрөг ●1-р цэцэрлэгийн цонх засварлах 73.2 сая төгрөг ●15-р цэцэрлэгийн цонх засварлах 174.3 сая төгрөг ●Эрх бүжинхэн цэцэрлэгийн радиатор солих 79.9 сая төгрөг; ●Ирээдүйн одод сургуулийн спорт заалны өргөтгөл, үндсэн заалыг модон шалтай болгох 950.0 сая төгрөг; ●5-р цэцэрлэгийн фасад засварлах 157.2 сая төгрөг; ●21-р цэцэрлэгийн фасад засварлах 173.8 сая төгрөг; ●Бялзуухай цэцэрлэгийн фасад засварлах 98.0 сая төгрөг. ●"Унага" цэцэрлэгийн гадна ханын дулаалга хийх 176.8 сая төгрөг ●5-р сургуулийн гадна биеийн тамирын тохижилт хийх 206.1 сая төгрөг	90.9
11.	ТЖҮЧ 2.1.4 ЗДҮАХ 3.1.1	ЕБ-ын сургуулиудын ахлах ангийн суралцагчдад инженерийн боловсрол, ажил мэргэжлийн баримжаа олгох сургалтыг орон нутгийн их, дээд сургуулиудыг түшиглэн зохион байгуулах	Ахлах ангийн суралцагчдад инженерийн боловсрол, ажил мэргэжлийн баримжаа олгосон байна.	2 сургалт зохион байгуулсан.	Сургалт, үйл ажиллагаа зохион байгуулна.	-	-	НБХ БШУГ	БШУГ, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль“ мэргэжил сурталчлах аяллыг 2 дахь жилдээ зохион байгуулж байна. Инженерийн болон нийгмийн ухааны чиглэлээр мэргэжил сонгосон нийт 876 суралцагч хамрагдахаас 769 суралцагч буюу 87.8 хувь оролцсон. Сурагчид Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ил уурхай, “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийн хичээлийн анги танхим, лаборатори, номын сантай танилцаж мэргэжлийн ур чадвар, ажил мэргэжлийн чиг баримжааны талаар танилцуулга зөвлөгөө авсан. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаарх 23 цагийн сургалтыг БШУГ-аас зохион байгуулж 978 багш, 111 удирдах ажилтан хамрагдсан. Мөн ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн 421 анги удирдсан багш сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох талаарх сургалтыг аймгийн Насан туршийн боловсролын төвтэй	100

									хамтран зохион байгуулсан байна. 2023-2024 оны хичээлийн жилийн эхэнд ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн 3972 сурагчдаас мэргэжил сонголтын судалгааг авч нэгтгэсэн.	
12.	ТЖҮЧ 2.1.4 ЗДҮАХ 3.1.1	ЕБ-ын сургуулиудын ахлах ангиудад байгалийн ухаан, математик, гадаад хэл, техник технологи, спорт, эрүүл мэнд, ёс зүй, урлагийн боловсрол олгох төслүүдийг хэрэгжүүлэх	Төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн байна.	4 төсөл	4 төсөл хэрэгжсэн байна.	591.0	Орон нутгийн төсөв	НБХ БШУГ	Сурагчдад эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр "Эрүүл хүүхэд", спорт, техник технологи, урлагийн боловсрол олгох чиглэлээр "Хүүхдийн хөгжил", хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах чиглэлээр "Тэгш боломж" төслүүдийг 2022 оноос хэрэгжүүлж, төслүүдийн хүрээнд багш хичээл заах, дугуйлан секц, клуб хичээллүүлэх багш нарыг Улаанбаатар хотод туршлага судлах үйл ажиллагаа, сургалтуудад үе шаттайгаар хамруулсан. Мөн “Тэгш боломж” төслийн хүрээнд 1, 7, 20 дугаар сургуулиудад “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих төв”, 4 дүгээр сургуульд “Эрүүл мэндийг дэмжих төв” байгуулагдаж, ерөнхий боловсролын 7 сургуульд “Хүүхдийн хөгжил” төслийн хүрээнд хөгжим, техник хэрэгсэл, хэрэглэгдэхүүнүүд нийлүүлэгдсэн. Дээрх 3 төслийг 2023 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. "Тэгш боломж" төслийн хүрээнд 2, 4, 13 дугаар сургуульд "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих төв", “Эрүүл хүүхэд” төслийн хүрээнд 15 дугаар сургуульд "Эрүүл мэндийн жишиг кабинет" байгуулагдаж, "Хүүхдийн хөгжил" төслийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулиудад хөгжим, техник хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүнүүд нийлүүлсэн байна. Төслийн хүрээнд багш, сурагчдад чиглэсэн сургалт үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан.	100
13.	ТЖҮЧ 2.1 ЗДҮАХ 3.1	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, МСҮТ-үүдэд дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах	Хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлсэн байна.	2 сургуульд дэмжлэг үзүүлж, хамтарч ажилласан.	2 байгууллагад дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллана.	15.0	Орон нутгийн төсөв	НБХ БШУГ	2023 онд БШУГ, “Эрдэнэт” цогцолбор дээд сургуультай хамтран Эрдэнэт хотын тулгамдсан асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлж, орон нутгийн нөөц бололцоонд түшиглэсэн гарц шийдлийг эрэлхийлэх, шинэ санал санаачилга дэвшүүлэх, харилцан туршлага солилцох, бүс нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах, эрдэмтэн судлаачдын судалгааны ажлын үр дүнг сурталчлах зорилгоор “Эрдэнэт хотын тулгамдсан асуудал, гарц шийдэл” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан. Мөн БШУГ, “Эрдэнэт” цогцолбор дээд сургуулийн багш, ажилтнуудыг ӨМӨЗО-ны Бугат хотын Төмөрлөгийн үйлдвэр, тус үйлдвэрийн харьяа ШУТИС-тай танилцуулж, туршлага судлуулсан байна.	100
14.	ТЖҮЧ 2.1.3 ЗДҮАХ 3.1.2	НҮБ-ын хөгжлийн хөтөлбөртэй хамтран “Тогтвортой боловсрол төсөл”-ийг хэрэгжүүлэх	“Тогтвортой боловсрол төсөл”-ийг хэрэгжүүлсэн байгууллагын тоог нэмэгдүүлсэн байна.	3 цэцэрлэг, 4 сургууль, 1 МСҮТ	4 сургууль нэмэгдүүлнэ	-	-	НБХ НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр	БОАЖЯ, БШУЯ, Швейцарын хөгжлийн агентлаг, Байгаль орчин сургалт мэдээллийн төвтэй хамтран хэрэгжүүлсэн “Тогтвортой хөгжлийн боловсрол- II” төсөл аймгийн хэмжээнд 4 сургуульд амжилттай хэрэгжсэн. Үүнд : •4-р сургууль “Ардын ёс заншил” төсөл; •5-р сургууль “Дотоод агаарын чанар” төсөл; •14-р сургууль “Цахилгааны хэмнэлт” төсөл; •15-р сургууль “Байгалийн ухаан” төсөл. Дээрх 4 сургуулиас олон улсын “Эко сургууль”-ийн алтан гэрэгэ, ногоон тугийн болзлыг 14, 15-р сургуулиуд, хүрэл гэрэгэний болзлыг 4, 5-р сургуулиуд тус тус хангасан. Дээрх сургуулиуд төслийн үр дүнгээ улсын хэмжээнд тайлагнасан. Мөн олон улсын	100

									“Эко сургууль, цэцэрлэг”-хөтөлбөрт 4, 15, 26-р цэцэрлэг, Орхон МСҮТ хамрагдаж, болзлоо хангаж, батламж авсан. “Тогтвортой хөгжлийн боловсрол-II“ төсөлд хамрагдсан сургуулиуд байгаль, нийгэмд ээлтэй сургуулийн орчныг бүрдүүлж, суралцагчдад экологийн боловсрол олгох жишиг сургалтын хөтөлбөртэй болж хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж байна.	
15.	ТЖҮЧ 2.1.6 ЗДҮАХ 3.1.2	ЕБ-ын сургуулиудад сэтгэл зүйчийн өрөөг засварлах, шаардлагатай техник хэрэгслээр хангах	Сургуулийн сэтгэл зүйчдийн өрөөг засварлаж, тохижуулсан байна.	-	2-3 өрөө тохижуулсан байна.	105.0	Орон нутгийн төсөв	БШУГ	Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд 17 хүүхдийн хөгжил төлөвшлийн ажилтан, 18 сэтгэл зүйч ажиллаж байна. Нийт 11 сэтгэл зүйч БШУЯ-ны мэргэшүүлэх сургалтад хамрагдаж "Боловсролын сэтгэл зүйч" мэргэжил эзэмшсэн байна. ЕБС-ийн сэтгэл зүйчид сэтгэл зүйн гарааны үнэлгээг 2601 сурагч, 170 эцэг эх, асран хамгаалагч, 306 багш, 21 удирдах ажилтанд, сэтгэл зүйн бүлгийн зөвлөгөөг 1421 сурагч, сэтгэл зүйн бүлгийн сургалтыг 17000 гаруй сурагч, 1334 багш, 68 удирдах ажилтанд явуулж сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлсэн. 848 сурагчид хувийн хэрэг нээж ажилласан. Мөн ЕБС-ийн сэтгэл зүйчид "Сонсъё, Хайрлая, Мэдэрье" сэтгэл зүйн өдөрлөгийг цувралаар зохион байгуулж, иргэд олон нийтэд сэтгэл зүйн боловсрол олгох, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг зохион байгуулсан. "Нийгэм сэтгэл зүйн алба"-ыг байгуулан ажилласнаар хүүхэд хамгааллын бодлогыг амжилттай хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн. Сургуулиудад ажиллаж буй сэтгэл зүйчдийн 84.2 хувь нь "Боловсролын сэтгэл зүйч" байгаа нь улсын дундажтай харьцуулахад өндөр үзүүлэлт юм. ЕБС-ийн сэтгэл зүйчид ажлын өрөө тасалгаа, шаардлагатай техник хэрэгслээр бүрэн хангагдсан бөгөөд 4, 5, 14, 15 сургуулийн сэтгэл зүйчдийн өрөөг "Тогтвортой хөгжлийн боловсрол -II" төслийн хүрээнд бүрэн засварлаж тохижуулсан.	100
16.	ТЖҮЧ 2.1.5 ЗДҮАХ 3.1.3	Хүүхдийн “Хөдөлмөр зуслан” байгуулах ажлыг санаачлан хэрэгжүүлж буй төрийн болон ТББ, ААН, иргэнийг дэмжин хамтран ажиллах	Хөдөлмөр зуслан ажиллуулж байгаа төрийн болон ТББ, аж ахуйн нэгж, иргэнийг дэмжсэн байна.	1-2 байгууллагыг дэмжиж хамтран ажилласан.	Санаачилгыг дэмжинэ.	35.0	Орон нутгийн төсөв	НБХ БШУГ	Эрдэнэ багт байрлах "Ёс заншлын өргөө"-ний дэргэдэх хөдөлмөр зуслан зуны турш 8 ээлжээр 400 гаруй хүүхэд хүлээн авч "Би монгол хүн" хөтөлбөрийг хэрэгжүүлж, ногоо тарих арчлах, мал маллах арга ухаанд сургах, үндэсний ёс заншил зан үйлд сурах, эх оронч үзэл төлөвшүүлэх, малын түүхий эд боловсруулах зэрэг 5 чиглэлээр сургалтуудыг зохион байгуулсан. Булган аймгийн Бугат сумын нутагт баригдаж буй "Эрдмийн сан" сургуулийн дэргэдэх хөдөлмөр зуслангийн бүтээн байгуулалтын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Тус зуслан ашиглалтад орсноор 1 ээлжинд 120-160 хүүхэд амарч амьдрах арга ухаан, хөдөлмөр, ёс заншил, өв уламжлалаасаа суралцах боломж бүрдэнэ. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын "Энэрэл" зуслан”-гийн үйл ажиллагаа хэвийн явагдсан.	100
17.	ТЖҮЧ 1.3.1 ЗДҮАХ 3.1.3	Олон улс, улсын түвшинд зохион байгуулагдаж буй олимпиад, уралдаан тэмцээнд оролцох, амжилт гаргасан багш, сурагчдыг урамшуулах	Олимпиад, уралдаан тэмцээнд оролцож, амжилт гаргасан багш, сурагчдыг урамшуулсан байна.	4 сурагч, 1 багшийг урамшуулсан.	Амжилт гаргасан багш сурагчдыг урамшуулсан байна.	6.3	Орон нутгийн төсөв	НБХ	2022 онд улсын олимпиадад оролцож медаль хүртсэн 9 сурагч, 5 багш, сурагчдыг бэлтгэсэн багш нарт 4.0 сая төгрөгийн, 2023 онд улсын олимпиадад оролцож медаль хүртсэн 7 сурагч, 2 багш, сурагчдаа бэлтгэсэн багш нарт 2.3 сая төгрөгийн урамшуулал тус олгосон байна.	100

18.	ТЖҮЧ 1.3.1 ЗДҮАХ 3.1.3	Боловсролын чиглэлээр улс, бүсийн чанартай 1-ээс доошгүй арга хэмжээг орон нутагтаа зохион байгуулах	Улс, бүсийн чанартай олимпиад, уралдааныг зохион байгуулсан байна.	Нийгмийн ухааны улсын олимпиадыг орон нутагтаа зохион байгуулсан.	1 арга хэмжээ зохион байгуулсан байна.	39.9	Орон нутгийн төсөв	НБХ	2023 онд Улсын биологийн 33 дугаар олимпиадыг зохион байгуулж, 21 аймаг, 9 дүүргийн, нийт 60 сурагч, 31 багш оролцож орон нутгийн төсвөөс 39.9 сая төгрөг зарцуулсан байна. Олимпиадын хүрээнд аймаг, орон нутгаа улсын хэмжээнд сурталчилж, орон нутгийн аж ахуй нэгж байгууллагуудыг дэмжиж хамтарч ажилласан. Мөн биологийн шинжлэх ухааныг орон нутгийн хэмжээнд сурталчилж, энэ чиглэлийн мэргэжлийн багш нарыг чадавхжуулах үйл ажиллагааг МУИС-тай хамтран зохион байгуулсан.	100
19.	ТЖҮЧ 1.3.1 ЗДҮАХ 3.1.3	Хүүхдийг цахим халдлагаас урьдчилан сэргийлэх, цахим хэрэглээний зохист байдлыг бий болгох сургалтуудыг ЕБС-ийн хэмжээнд зохион байгуулах	Цахим халдлагаас урьдчилан сэргийлэх, цахим хэрэглээний талаарх сургалтуудыг зохион байгуулсан байна.	3 удаа зохион байгуулсан.	ЕБ-ын сургуулиудад 3 удаа зохион байгуулна.	-	-	Аймгийн ГХУСАЗ салбар зөвлөл,	2023 онд аймгийн Цагдаагийн газартай хамтран 6-12-ангийн "Иргэний ёс зүйн боловсрол" хичээлийн цагаар цахим халдлагаас урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалтыг 2 удаа зохион байгуулсан. Энэхүү сургалтад өмчийн бүх хэлбэрийн 25 сургуулийн 283 бүлгийн 9905 хүүхэд хамрагдсан. Сургууль тус бүр ГБХЗХГ болон Цагдаагийн газартай хамтран "Цахим орчны зохистой хэрэглээ-донтолт болох нь" уулзалтуудыг зохион байгуулж, ахлах ангийн сурагчид эцэг, эх, асран хамгаалагчийн төлөөллийг оролцуулсан. Мөн энэ чиглэлээр сургуулиудын "Хүүхэд хамгааллын баг" нийт 57 зурагт хуудсыг цахим орчинд байршуулж, олон нийтэд хүргэсэн байна.	100
20.	ТЖҮЧ 2.1.2 ЗДҮАХ 3.1.4	“Багш” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн байна.	Хөтөлбөрийн хэрэгжилт 50 хувь	Хөтөлбөрийн хэрэгжилт 75 хувьд хүрнэ.	180.0	Орон нутгийн төсөв	НБХ	"Багш" хөтөлбөрийг 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 28-ны А/306 дугаар захирамжаар 3 зорилтын хүрээнд 21 үйл ажиллагаа төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг хангасан. Хөтөлбөрийн хүрээнд ЭЕШ-ын чанарыг сайжруулах чиглэлээр төгсөх ангийн сурагчдын ЭЕШ-ын урьдчилсан 2 удаагийн сорил, аймгийн мэргэжлийн зэрэгтэй багш нарыг түшиглэн залуу багш нарын арга зүй, ур чадварыг нэмэгдүүлэх, багшийн тасралтгүй хөгжлийг хангах "Ментор багш" төсөл, 2, 3, 4 болон 6, 7, 8, 9 дэх жилдээ ажиллаж байгаа багш нарт зориулсан модуль сургалт, аймгийн "Зөвлөх баг"-тай хамтарсан багшийн арга зүйг оношлох, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа, "Боловсролын шинэ сэргэлт-Сургуулийн менежмент " сэдэвт багш удирдах ажилтны сургалт, хэлэлцүүлэг, багш нарын "Мэргэжлийн хөгжлийн бүлэг"-ийг дэмжсэн үйл ажиллагаа, "Ур чадварын уралдаан", "Чадварлаг багш" үзэсгэлэн зэрэг арга хэмжээнүүдийг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан. 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт 90%-тай байна.	100
21.	ТЖҮЧ 2.1.7 ЗДҮАХ 3.1.2	Согоот багийн сургуулийн өргөтгөлийн суурийг буулгах	Өргөтгөлийн суурийг буулгасан байна.	-	Суурийг буулгасан байна.	-	-	НБХ БШУГ	2024 оны орон нутгийн төсөвт Согоот багийн 14 дүгээр сургуулийн өргөтгөлийг буулгахад 300.0 сая төгрөг батлагдсан байна.	30
22.	ТЖҮЧ 2.1.9 ЗДҮАХ 3.1.5	Шаардлагатай цэцэрлэгүүдэд багш нарыг 2 ээлжээр ажиллах нөхцөлийг бүрдүүлэх	Цэцэрлэгийн багш нарыг 2 ээлжээр ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна.	10 цэцэрлэгт 2 ээлжийн багш ажиллуулж эхэлсэн.	Шинээр 8 цэцэрлэг хамруулна.	763.6	Улсын төсөв	НБХ	2022 оны 03 дугаар сарын 01-нээс ачаалал ихтэй 10 цэцэрлэгийн 84 бүлэгт ээлжийн 42 багш ажиллаж эхэлсэн. Ээлжийн багш ажиллаж буй 10 цэцэрлэг өглөө 07:00 цагаас орой 19:00 цаг хүртэл 12 цагаар үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд эцэг, эхчүүд ажил, хөдөлмөрөө тайван эрхлэх боломжийг бүрдүүлсэн. Ээлжийн багш ажиллуулснаар багш нарын цалин хөлстэй холбоотой тодорхой хүндрэлүүд үүссэн тул бусад цэцэрлэгүүдэд нэмж ээлжийн багш ажиллуулах асуудал шийдэгдээгүй. 2023 онд ээлжийн багш нарын цалин хөлсөнд 763.6 сая төгрөгийг улсын төсвөөс олгосон.	50

Зорилт 2.2. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлэх замаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.										
23.	ТЖҮЧ 2.2.1 ЗДҮАХ 1.5	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудлыг дэмжих “Эмч” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	“Эмч” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн байна.	Хөтөлбөрийн хэрэгжилт 90 хувь	Хэрэгжилтийг 95% хангасан байна.	60.0	Орон нутгийн төсөв	НБХ ЭМГ	“Эмч” хөтөлбөрийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон 175.0 сая төгрөгийн төсөв батлагдсан. Тус хөтөлбөрийн хүрээнд: - Төгсөлтийн дараах сургалтад 112, ажлын байран дахь сургалтад 2221 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна. - “UpToDate программын хэрэглээг өргөжүүлэх нь” ажил мэргэжлийн уралдааныг зохион байгуулж нийт 35 эмч оролцлоо. - Эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж нийт 30 илтгэл хэлэлцүүлэв. - Өндөр хөгжилтэй оронд нийт 40 эмч, мэргэжилтэн суралцаж, мэдлэг, чадвараа дээшлүүлсэн - Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн чиглэлээр нийт 27 удаагийн соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулсан бөгөөд 594 эмч, мэргэжилтнүүд хамрагдсан байна. Тайлант хугацаанд 2 өргөдөл ирснийг судлан шийдвэрлэсэн. - Эрүүл мэндийн салбарын 40 наснаас дээш нийт 400 ажилтныг бамбай булчирхайн дааврын шинжилгээнд хамруулан 49 ажилтан өөрчлөлттэй гарсныг эмчлэн, эрүүлжүүлж байна. - Эрүүл мэндийн байгууллагуудын Үйлдвэрчний эвлэлийн хорооноос зохион байгуулагдсан 4 төрөлт спортын наадамд Орхон аймгийн эрүүл мэндийн салбарын баг тамирчид амжилттай оролцон 2-р байр эзэллээ. Тайлант хугацаанд төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний 7.9 хувь, нийгмийн дэмжлэгт 24.4 хувь нь хамрагдсан ба тус хөтөлбөрийн хэрэгжилт 100%-тай байна.	100
24.	ТЖҮЧ 2.2.2 ЗДҮАХ 1.1	Иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг оношилгоонд хамрагдах нөхцөлийг сайжруулж, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх зорилтот арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Урьдчилан сэргийлэх үзлэгийн тоог нэмэгдүүлж, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлсэн байна.	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь 39.9	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь 40	90.0	Орон нутгийн төсөв	ЭМГ	Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 533717 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэгт 184182 буюу 34.5 хувь хамрагдаж өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар нэмэгдсэн байна. Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн хамралт 73.0 хувь болж өмнөх оны мөн үеэс 41.6 хувиар нэмэгдсэн байна. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоог эрчимжүүлэхээр байгууллагуудад 18-34 насны ажиллагсдыг үзлэгт хамруулах чиглэл өгч ажилласнаар үзлэгийн хамралт 3.7%-аар нэмэгдсэн. Улс орон даяар зохион байгуулагдаж байгаа урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт нийт хүн амын 39.2 хувь нь үзлэгт хамрагдаж, үзлэгээр 26858 хүнд зөвлөгөө өгч, 2846 хүнийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналтад, 6841 хүнийг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт шилжүүлсэн байна. Аймгийн Засаг даргын санаачилгаар “Эрүүл Эрдэнэт хүн” төслийг хэрэгжүүлэн, тус төслийн хүрээнд 1519 хүн үзлэгт хамруулснаас эрүүл мэндийн даатгалгүй иргэд 544 буюу 35.8 хувийг эзэлж байна. “Орхон 100 км”, “Туг аялуулах хөтөлбөр”, “Эрүүл мэнд эко гороо аялал”, “Эмчтэй хамт алхъя”, “Таны хөл бол эмч юм” гэх мэт 10 гаруй алхалтыг иргэдийн дунд зохион байгуулж, давхардсан тоогоор 3000 орчим иргэнийг хамруулсан.	100
25.	ТЖҮЧ 2.2.2 ЗДҮАХ 1.1	Хорт хавдартай иргэдийн эмийн болон эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх	Хорт хавдартай иргэдэд дэмжлэг	Дэмжлэгт хамрагдсан 17.2 хувь	Дэмжлэгт хамрагдсан 17.2 хувь	44.2	Орон нутгийн төсөв	НБХ ЭМГ	Хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэхээр ИТХ-ын 2022 оны 13/09 дүгээр тогтоолоор 70.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэснээс 2023 оны байдлаар 110 иргэнд 44.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Тайлант хугацаанд хавдрын	100

			үзүүлсэн байна.						159 тохиолдол бүртгэгдэж, хяналтад орсноос эмийн болон эмчилгээний дэмжлэгт 69.2 хувь нь хамрагдсан байна	
26.	ТЖҮЧ 2.2.2 ЗДҮАХ 1.1	БОЭТ-ийн оношилгоо, эмчилгээний чадавхыг нэмэгдүүлэх, шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэд орон нутагтаа эмчлүүлэх боломжийг бүрдүүлнэ.	Дэвшилтэт технологийг нэвтрүүлж, оношилгоо, эмчилгээний чадавхыг сайжруулсан байна.	Үзлэгт хамрагдсан 5 хувь	Үзлэгийн хамрагдалт 15-20 хувь	210.0	Орон нутгийн төсөв	ЭМГ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь нийт 140232 үзлэг хийсэн нь аймгийн нийт үзлэгийн 26.3 хувийг эзэлж байна. Шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх хүрээнд: - Орон нутгийн 210.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар зүрхэн дотор цахилгаан сэдэл өгөх аппарат, зүрхний холтер зэрэг аппаратууд нийлүүлэгдэн тусламж үйлчилгээнд ашиглагдаж байна. - Мухар олгойг дурангаар авах мэс заслыг нэвтрүүлж, 3 хүнд мэс засал хийгдсэн. - Шээлгүүрийн дуранг өөрийн 112.0 сая төгрөгөөр авч нийт 3 хүнд оношилгоо эмчилгээ хийсэн байна. - Дутуу нярайн нүдний эвэрлэгийн эмгэг судасжилт илрүүлэх шинжилгээг 67 дутуу нярайд хийснээс 4 нярайг дээд шатлалд илгээсэн. - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирлын тушаалаар Тархины харвалтын нэгж байгуулагдаж, тайлант хугацаанд судсан дотуурх оношилгоо эмчилгээг 182 хүнд хийж, зүрхний цочмог шигдээс өвчний нас баралтыг өнгөрсөн оноос 11 тохиолдлоор буюу 1 промиллоор бууруулсан байна. Орон нутгийн төсвөөс 80.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, 12 ширхэг бүлэн хайлуулах РЭПИ/актилизе/-р хангасан байна. Тайлант хугацаанд бүлэн уусгах эмчилгээ 5 үйлчлүүлэгчид амжилттай хийгдэж, эмчилгээнд хамрагдсан 5 үйлчлүүлэгчийн гар хөлийн саа 1-4 цагийн дотор сэргэсэн үр дүнтэй байна. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 602.0 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн хангалт 92.5 хувьтай байна.	100
27.	ТЖҮЧ 2.2.2 ЗДҮАХ 1.1	“Эрүүл хамт олон” ажлын байранд эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөн өрнүүлж, жил бүр шалгаруулан сайн туршлагыг нийтийн хүртээл болгон урамшуулах	Ажлын байрны эрүүл мэндийг дэмжиж, эрүүл, идэвхтэй хамт олныг бий болгосон байна.	Хамрагдсан ЭМДБ-ын тоо 68	Хамрагдах ЭМДБ-ын тоо 69 байна.	14.0	Орон нутгийн төсөв	НБХ ЭМГ	Төрийн 28 байгууллагатай хамтран эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг сар бүр тогтмолжуулан ажлын байранд эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөнийг өрнүүлэн 1244 албан хаагчийг эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад хамруулсан. Төрийн байгууллагын албан хаагчдын дунд “Энэ жилдээ эрүүл жиндээ“ аяны хүрээнд жин бууруулах 1 сарын уралдааныг зохион байгуулж 10 байгууллагын 60 албан хаагч оролцож хамгийн их жин хассан 3 байгууллагыг шалгаруулахад нийт 93.4 кг жин хассан үр дүн гарсан. Тайлант хугацаанд Эрүүл мэндийг дэмжигч байгууллага 76 байгууллагаас боловсролын байгууллага 44, үйлдвэр аж ахуйн нэгж 11, эрүүл мэндийн байгууллага 13, бусад 8 байгууллага тус тус оролцсон. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих аян өрнүүлэх, эрүүл идэвхтэй хамт олныг бүрдүүлэх хүрээнд орон нутгаас 14.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн.	100
28.	ТЖҮЧ 2.2.2 ЗДҮАХ 1.2.3	Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг аминдэмжүүлэх, цус цусан бүтээгдэхүүний хангалтыг нэмэгдүүлэх ажлуудыг зохион байгуулах	Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн аминдэмийн хангалтыг нэмэгдүүлсэн байна.	Жирэмсэн, хөхүүл эхийг аминдэмээр хангалт - 12%	Жирэмсэн, хөхүүл эхийг аминдэмээр хангалт 15%	15.0	Орон нутгийн төсөв	ЭМГ	Нийгмийн халамж нэн шаардлагатай бүлгийн жирэмсэн болон хөхүүл эхийг аминдэмжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2023 оны А/195 дугаар захирамжаар батлагдсан 10.0 сая төгрөгийн санхүүжилтийн хүрээнд сум өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 20100 ширхэг аминдэмийг хуваарилан 689 эхийг 100 хувь аминдэмжүүлсэн. Аминдэмжүүлэлтэд хамрагдсан нийт 689 эхээс цус багадалттай 264 эх байгаа нь 38.3 хувийг, нийгмийн халамж дэмжлэг нэн шаардлагатай бүлгийн 128 эх, эх барихын	100

									ужиг дутагдалтай 297 эхийг аминдэмжүүлж, эх барихын хүндрэлгүй төрүүлсэн. Эхийн аминдэмийн төсөв өмнөх онтой харьцуулахад 42 хувиар, аминдэмд хамрагдах эхийн тоо өмнөх онтой харьцуулахад 1.4 дахин нэмэгдсэн.	
29.	ТЖҮЧ 2.2.3 ЗДҮАХ 1.2.4	Нярайн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	Дэвшилтэт технологийг нэвтрүүлж, амьсгал хямралын хам шинжийн нярайн эндэгдлийг бууруулсан байна.	Нярайн эндэгдэлд эзлэх амьсгал хямралын хам шинжийн хувь- 29.5%	Нярайн эндэгдэлд эзлэх амьсгал хямралын хам шинжийн хувь- 28.5%	-	-	ЭМГ	Орон нутагт нярайн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи сурфактант эмчилгээг 2015 оноос эхлэн нэвтрүүлж тайлант хугацаанд сурфактант эмчилгээг амьсгал хямралын хам шинжтэй, дутуу төрсөн 15 нярайд хийж, 80 хувийн үр дүн өгсөн байна. Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийг төрсөн 1705 нярайд 100 хувь үзүүлсэн. Нярайн тандалт скрининг шинжилгээнд төрсөн нярай бүрийг 100 хувь хамруулж байгаа бөгөөд дутуу нярайн нүдний эвэрлэгийн эмгэг судасжилт илрүүлэх шинжилгээг 67 дутуу нярайд хийснээс 4 нярайг дээд шатлалд илгээсэн. Тайлант хугацаанд нялхсын эндэгдэлд эзлэх нярайн эндэгдэл 62.5 хувь байгаагаас амьсгал хямралын хам шинжийн шалтгаант эндэгдэл 2 бүртгэгдсэн нь нийт нярайн эндэгдлийн 20 хувийг эзэлж байна.	100
30.	ТЖҮЧ 2.2.3 ЗДҮАХ 1.2.1	Сувилахуйн тусламж үйлчилгээг өргөжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх	Сувилахуйн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.	-	Сувилахуйн төвийн зураг төсөв, газрын асуудлыг шийдвэрлүүлэх	14.2	Орон нутгийн төсөв	НБХ ЭМГ	Сувилахуйн төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийг боловсруулах “Сувилахуйн тасралтгүй сургалтын чиг хандлага” сэдэвт цахим сургалт, хэлэлцүүлгийг Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан. Нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх ажлын хүрээнд “Up To date программыг өргөжүүлэх нь” сэдэвт сургалтад 47 ахлах сувилагч, эх баригчийг хамруулсан. Сувилагчдын Эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж хэлэлцэгдсэн 10 илтгэлээс шалгаруулж 2.5 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд “Сувилагч мэргэжлээр суралцагчдын шийдвэр гаргах чадварыг хөгжүүлэх нь” номд оюуны өмчийн эрхийг авсан бөгөөд цахим хуудаст байршуулан сурталчилж ажилласан. Сувилахуйн мөн чанар, үнэ цэнийг сурталчлан таниулах өдөрлөгийн хүрээнд ерөнхий боловсролын 14 сургуулийн ахлах ангийн 704 сурагчийг сувилахуйн тусламж үйлчилгээний төрөл, сувилагч нарын өдөр тутмын үйл ажиллагаатай танилцуулсан. “Бидний сувилагч-Бидний ирээдүй” уриан дор Монголын Сувилагчдын Нийгэмлэгээс “Сувилахуй ба эрх зүй” сургалт, хэлэлцүүлэг, “Сувилагч ба эрүүл мэнд” аяныг УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэнгийн ажлын албатай хамтран зохион байгуулж, төвийн бүсийн 6 аймгийн 300 гаруй сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд оролцлоо. “Олон улсын сувилагчдын эрхийг хамгаалах өдөр”-ийг угтан аймгийн ЗДТГ-ын дэмжлэгтэйгээр БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ордос хотын төв эмнэлгийн үйл ажиллагаатай танилцан туршлага судлах уулзалтад 11 сувилагч хамрагдсан. БОЭТ-ийн “Яаралтай тусламжийн сувилахуй судлал”-ын төрөлжсөн мэргэжлийн сургалтад 4, ”Эрчимт эмчилгээний сувилахуйн судлал”-аар 1 сувилагч суралцаж байна. Байнгын асаргаа сувилгаа шаардлагатай 952 иргэнд гэрээр сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. Тайлант хугацаанд сувилахуйн тусламж үйлчилгээгээр 1 клиник тусгай зөвшөөрөл авч, аймгийн хэмжээнд 2 сувилахуйн клиник тусламж үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.	70

									ЭМЯ-нд Сувилахуйн төвийн барилгын төсвийг улсын төсөвт тусгуулахаар хүсэлт хүргүүлсэн боловч дэмжигдээгүй, харин Үйлс бадрах ӨЭМТ-ын барилгын ТЭЗҮ-ийг хийлгэхээр болсон.	
31.	ТЖҮЧ 2.2.8 ЗДҮАХ 1.2.5	БОЭТ-ийн барилга их засвар, дэд агааржуулалтын системийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлэх	Засвар үйлчилгээг хийж, чанар стандартын шаардлага хангасан тусламж үйлчилгээг үзүүлнэ.	-	БОЭТ-ийн агааржуулалтын нэгдсэн систем шинэчлэгдсэн байна.	647.6	Орон нутгийн төсөв	НБХ ЭМГ	2024 онд БОЭТ-ийн агааржуулалтын системд хэсэгчилсэн засвар үйлчилгээг хийхээр төлөвлөгдсөн. Тайлант хугацаанд байгууллагын төсвөөр лабораторийн тасгийн засварыг 274.8 сая төгрөг, амбулаторийн 3, 4-р давхрын засварыг 372.8 сая төгрөгийн санхүүжилтээр засварласан.	30
32.	ТЖҮЧ 2.2.8 ЗДҮАХ 1.2.5	БОЭТ-ийн амбулаторийн өргөтгөлийн барилгатай болгож ажиллах орчин нөхцөлийг сайжруулах	Амбулаторийн өргөтгөлийн барилгын ТЭЗҮ-ийг хийлгэсэн байна.	-	БОЭТ-ийн амбулаторийн 2 давхар өргөтгөл баригдсан байна.	20.0	Орон нутгийн төсөв	НБХ ЭМГ	БОЭТ-ийн амбулаторийн өргөтгөлийн барилгын зураг төсөв зуруулахаар 20.0 сая төгрөг батлагдаж, уг зураг төсвийг “Вилла проект” ХХК хийж бүрэн зурагдсан.	30
33.	ТЖҮЧ 2.2.8 ЗДҮАХ 1.2.5	Анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлэх орчин бүрдүүлэх	Стандарт, чанарын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлсэн байна.	Стандартын шаардлага хангасан орчин бүрдүүлсэн эрүүл мэндийн төв-88.9%	Стандартын шаардлага хангасан орчин бүрдүүлсэн эрүүл мэндийн төв-100%	20.0	Орон нутгийн төсөв	ЭМГ	Тайлант хугацаанд: - Жаргалант сумын эрүүл мэндийн төвд Жаргалант сумын төсвөөс 20.0 сая төгрөг шийдвэрлэн стандартын дагуу болгож засварлах урсгал засвар хийгдсэн. - Алслагдсан 2 өрхийн эрүүл мэндийн газрын асуудал шийдвэрлэгдэж 2024 онд 2 стандартын шаардлага хангасан өрхийн эрүүл мэндийн төвийн барилгыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барихаар шийдвэрлэгдсэн. - Өрхийн эрүүл мэндийн төвүүд цусны дэлгэрэнгүй шинжилгээний анализатор, биохимийн аппарат, шээсний шинжилгээний аппарат, центрифугээр 100 хувь хангагдсан. Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат 17, дефибриллятор 9, билиметр 9 байна. Сэргээн засах тусламж үйлчилгээний аппаратын хангалт 85 хувьтай байна. Сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн барилга байгууламж 100 хувь стандартын шаардлага хангасан. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 95 хувьтай байна	100
34.	ТЖҮЧ 2.2.4 ЗДҮАХ 1.3.1	Тохиолдол удирдлагын тогтолцоог бэхжүүлж хариу арга хэмжээний чадавх, гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийг нэмэгдүүлэх	Хариу арга хэмжээний чадавх, гамшиг нийгмийн эрүүл мэндийн нөөцийг нэмэгдүүлсэн байна.	Хариу арга хэмжээний чадавх-75% ЭМБ-ын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэлт 50%	Хариу арга хэмжээний чадавх - 85% ЭМБ-ын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэлт 52%	25.0	Орон нутгийн төсөв	ЭМГ	Тохиолдол удирдлагын тогтолцоог бэхжүүлж, хариу арга хэмжээний чадавхыг нэмэгдүүлэх хүрээнд орон нутгийн төсөвт 25.0 сая төгрөгийг тусгаж, санхүүжилтийг шийдвэрлэснээр эрүүл мэндийн байгууллагуудад дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг хариуцсан 40 мэргэжилтэн бэлтгэгдэж, эрүүл мэндийн 3 байгууллагад олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO 9001 стандарт эрсдэлийн менежментийн тогтолцоо ISO31000:2018 стандарт нэвтрэн, томуу, томуу төст өвчний дэгдэлтийг хүндрэл бэрхшээлгүй даван туулсан. ХӨСҮТ-д нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрсдэлийн үнэлгээ хийх төвийн сургалтад ЭМГ-аас 2 мэргэжилтнийг хамруулж чадавхжуулсан. ОБЕГ-аас зохион байгуулсан Стратеги команд штабын сургуулилтад эрүүл мэндийн албаны 15 гишүүн, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн мэргэжлийн ангийн 55 бие бүрэлдэхүүн оролцож, 2 удаагийн жагсаалын бэлтгэл хийн, Онцгой байдлын газраас өгөгдсөн 7 удаагийн цагийн байдалд хариу арга хэмжээ авч	100

									ажилласан. Эрүүл мэндийн байгууллагуудын гамшгийн үеийн нөөцийн хангалт дунджаар 95 хувь байна.	
35.	ТЖҮЧ 2.2.3 ЗДҮАХ 1.2.	Яаралтай тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, анхан шатны ЭМБ-уудад нэгж байгуулах, амь тэнссэн тусламж үйлчилгээг үзүүлэх чадавхыг нэмэгдүүлэх	Амь тэнссэн тусламж үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлсэн байна.	Амь тэнссэн тусламж үйлчилгээний чадавх-65%	Амь тэнссэн тусламж үйлчилгээний чадавх-85%	30.0 45.0	Орон нутгийн төсөв БОЭТ	ЭМГ	Яаралтай тусламж үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлэх хүрээнд хүний нөөцийн чиглэлээр: - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт яаралтай тусламжийн сувилахуйн чиглэлээр 3 сувилагч суралцаж төгссөн, намрын элсэлтээр 4 сувилагч суралцаж байна. - Хувийн хэвшлийн 7 эмнэлэг яаралтай тусламжийн мэргэшсэн сувилагчийг ажиллуулж байна. - Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд БОЭТ-ийн Яаралтай тусламжийн тасагтай хамтран 7 удаагийн сургалтад 52 эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтнийг хамруулж чадавхжуулсан. - Амилуулах суурь тусламжийг сайжруулах хүрээнд ажил мэргэжлийн уралдааныг Монголын Яаралтай тусламжийн Нийгэмлэгтэй хамтран зохион байгуулж 14 багийн 70 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, орчин үеийн технологи Kahoot, Quiz maiker программыг анх удаа ашиглан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн гардан болон онолын мэдлэгийг нэмэгдүүлсэн. - Монголын яаралтай тусламжийн нийгэмлэгтэй хамтарсан “Амилуулах суурь тусламж” болон “Зүрх зогссон үеийн яаралтай тусламж” сэдвээр 121 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургалтад хамруулж, чадавхжууллаа. Тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх хүрээнд: - БОЭТ-ийн Төрөх тасгийн хүлээн авах тасагт SUMSUNG ЭХО аппаратын датчикийг байгууллагын 45 сая төгрөгийн санхүүжилтээр шийдвэрлэж оношилгооны чадавхыг нэмэгдүүлсэн. - Яаралтай түргэн тусламжийн тасагт шархны анхдагч цэгцлэлтийн багажаар хангасан. Амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээний чадавх, мэргэшсэн хүний нөөц, багаж тоног төхөөрөмжийн хангалт өмнөх оноос 5 хувиар нэмэгдэж 90 хувьд хүргэсэн.	100

36.	ТЖҮЧ 2.2.5. ЗДҮАХ 1.2.3	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг бүх талаар дэмжиж, зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх	Гэрээт үйлчилгээний тоог нэмэгдүүлсэн байна.	Гэрээт үйлчилгээний тоо 1 байгаа.	Гэрээт үйлчилгээний тоо 2 болно.	-	-	НБХ	Хувийн хэвшлийн 1 нэгдсэн эмнэлэг, 11 ор бүхий клиникүүдтэй аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газар хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллалаа. Тайлант хугацаанд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд 75683 үзлэг хийсэн нь аймгийн хэмжээнд хийгдсэн нийт үзлэгийн 14.2 хувийг, 13824 иргэнийг хэвтүүлэн эмчилсэн нь нийт эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн 49.2 хувийг эзэлж, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн ачааллыг хуваалцсан байна. Хувийн хэвшлийн төрөлжсөн эмнэлэг 1, хүүхдийн 4 клиник томуу томуу төст өвчний үеийн тусламж үйлчилгээний ачаалал, хүлээгдлийг бууруулах чиглэлээр уртасгасан цагийн зохицуулалт хийж хамтран ажилласан. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай 2 тусламж үйлчилгээгээр гэрээ байгуулан ажилласан. Үүнд: - Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулахад 6 хувийн хэвшлийн нөхөн үржихүйн клиникүүдтэй гэрээ байгуулан 16-49 насны 1895 эмэгтэйг үзлэгт хамруулан 354 буюу 77.5 хувь бүрэн эмчлэн эрүүлжүүлэн, лавлагаа шатлалд 457 эмэгтэйг илгээсэн байна. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын оношилгооны чадавх 90 хувьтай байна. - Суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх, гэр сувилал ажиллуулахаар орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөгийг шийдвэрлэн, сульдаа, уураг илчлэгийн дутагдал, цус багадалт зэрэг суурь эмгэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй 150 хүүхдийг нар ус агаараар чийрэгжүүлэх зуны сувилалд хамруулан эрүүлжүүлсэн.	100
Зорилт 2.3. Гэр бүлд суурилсан хүний хөгжил, оролцоог дээшлүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмж, салбар дундын уялдаа холбоог сайжруулан, залуучуудын идэвхэжсэн хандлагыг дэмжинэ.										
37.	ТЖҮЧ 2.3.1 ЗДҮАХ 2.1.1	Гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	Боловсрол олгох сургалт, нөлөөллийн ажлыг нэмэгдүүлсэн байна.	Нийт өрхийн 15 хувь хамрагдсан.	Гэр бүлийн 30 хувийг хамруулна.	50.0	Орон нутгийн төсөв	ГБХЗХГ	Тайлант онд "Бүх хайраа гэр бүлдээ" уриан дор өдөрлөг, сургалт, нэвтрүүлэг зэрэг олон талт арга хэмжээг 2 сарын хугацаанд зохион байгуулсан. Мөн "Гэр төсөл"-ийн хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 7-30 хоногийн баривчилгаанд байгаа иргэдэд зориулсан хувь хүний сэтгэл зүйн эрүүл мэндэд дэмжлэг үзүүлэх сэтгэл зүйн бүлгийн зөвлөгөөг 7 хоног бүр тогтмол явуулж 528 иргэн хамрагдсан байна. Гэр бүлийн чиглэлээр сургалт нөлөөллийн ажил өнгөрсөн оноос 13 буюу 23 хувиар нэмэгдэж нийт 69 байгууллагын 704 хүнийг хамруулан ажилласан. “Гэр бүлийн харилцаа”, “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга”, “Байгууллагын эцэг эхийн зөвлөл байгуулах" сургалтыг нийт 17 байгууллагын 329 албан хаагчдад, байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлүүд буюу нийт 52 байгууллагын 375 хүнд тус бүр ажлын байран дээр нь зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн. Дээрх	100

									нийт 10 төрлийн арга хэмжээнд давхардсан тоогоор 9125 өрхийг хамруулсан нь аймгийн нийт өрхийн 32 хувийг эзэлж байна.	
38.	ТЖҮЧ 2.3.1 ЗДҮАХ 2.1.1	Эмэгтэйчүүдийг дэмжих /зорилтот бүлгийн/ хөтөлбөр болон гэр бүлд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх	Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн байна.	Хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн.	Хөтөлбөр үргэлжилнэ.	89.5	Орон нутгийн төсөв	НБХ	Тайлант онд Эрдэнэтийн ээжүүдийг чадавхжуулах холбоотой хамтран гар урлаачдыг сургах, хөгжүүлэх өрхийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг чадавхжуулах "Гэрэл" төсөл, "Гэр бүлийн үнэ цэнтэй харилцаа" сургалт нөлөөллийн цуврал лекц, “Бидний дуу хоолой"-2023” охидын чуулган зэрэг олон талт арга хэмжээг зохион байгуулсан. "Хөөрхөн зүрх" ТББ-тай хамтран "Өөрийгөө хайрлая" сургалтыг багуудын нийгмийн ажилтан, ХХҮГ-ын халамжийн нийгмийн ажилтан-28, Цагдаагийн газарт 2022-2023 оны гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн болон бусад гэмт хэрэг зөрчилд холбогдсон эмэгтэйчүүд-12, Говил багийн зорилтот бүлгийн эмэгтэйчүүд-48, Жаргалант сумын эмэгтэйчүүд-46, Баян-өндөр сумын зорилтот бүлгийн эмэгтэйчүүд-30, нийт 160 гаруй эмэгтэйчүүдэд, "Гэр бүлийн үнэ цэнтэй харилцаа" сэдэвт сургалт, нөлөөллийн ажлыг 41 байгууллагын 1989 ажилтан албан хаагчид, эцэг эх асран хамгаалагч нарыг оролцуулж зохион байгуулсан. Түүнчлэн Шүүхийн тамгын газар хамтран гэрлэгчдэд сэтгэл зүйн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, уулзалт хийх, гэр бүлийн хөгжил-боловсрол, тогтвортой байдлыг дэмжиж сургалт, зөвлөгөөг явуулах чиглэлээр "Гэр төслийг хэрэгжүүлж байна. Эдгээр арга хэмжээнд давхардсан тоогоор 8500 гаруй охид, эмэгтэйчүүд хамрагдсан. Хөтөлбөрийг холбогдох шатны хурлуудаар хэлэлцүүлэн 92 хувийн хэрэгжилттэй дүгнүүлсэн.	100
39.	ТЖҮЧ 2.3.2 ЗДҮАХ 2.1.2,	Хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах	Хамтарсан багийн гишүүдийн хамрагдалт нэмэгдсэн байна.	Хамтарсан багийн гишүүдийн хамрагдалт 40%	Хамтарсан багийн гишүүдийн хамрагдалт 60%	17.2	Улсын төсөв	ГБХЗХГ	Тайлант онд хамтарсан баг, хүүхдийн элч, ЕБС-ийн хүүхэд хамгааллын баг, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын багийг чадавхжуулах 8 удаагийн сургалт, 3 удаагийн зөвлөн туслах арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулж, давхардсан тоогоор 298 хүн хамрагдсан. Хамтарсан багийн гишүүдэд 37 кейсийн 2.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Хамтарсан багийн бүрэлдэхүүнд ажлын байран дээр зөвлөгөө өгөх, чадавхжуулах сургалтыг үе шаттайгаар 7 удаа зохион байгуулж 242 гишүүн хамрагдаж, хамрагдалт 80-аас дээш хувьтай байна.	100
40.	ТЖҮЧ 2.3.3 ЗДҮАХ 2.1.1 ЗДҮАХ 2.1.2	Хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад холбогдох байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах	Холбогдох байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, өргөдөл гомдлын шийдвэрлэлт ийн хувийг нэмэгдүүлнэ.	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 90%	108 утас, бусад хүсэлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь 98%	15.0	Улсын төсөв	ГБХЗХГ	Тайлант онд 196 дуудлага ирж, шийдвэрлэлт 100 хувь байна. Үүнээс хүүхэд хамгааллын дуудлага 97.4 хувь, нийт дуудлагын 87.9 хувь нь гэр бүлийн хүрээнд гарсан дуудлага байна. Дуудлагыг хүүхэд өөрөө өгсөн нь 26 хувийг эзэлж байна. Хүүхдийн тусламжийн 108 утас”-ны дуудлагын шийдвэрлэлтийн чанар, хэрэгжилт, гүйцэтгэл дээр чанартай ажиллах төлөвлөгөөний дагуу Улаанбаатар хотын “Хүүхдийн тусламжийн 108 утас”-ны үйлчилгээний төвийн ажилтнуудтай хамтран практикт суурилсан сургалтыг Баян-Өндөр сумын 27 багийн нийгмийн ажилтныг хамруулан зохион байгуулж, дуудлага тус бүрийг шууд багийн нийгмийн ажилтан хүлээн авч, түргэн шуурхай үйлчилгээг хүргэн ажиллах арга зүйд суралцсан. Мөн “Хүүхдийн тусламжийн 108 утас”-ны үйлчилгээ, хүүхдийн эрхийг хэрхэн хамгаалдаг талаар сурталчлан таниулах зорилгоор сургуулийн нийгмийн ажилтан, хүүхэд төлөвшлийн менежер, цэцэрлэгийн эрхлэгч нарт сургалт хийсэн. Хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлагыг 2 сум, 26 багийн нийгмийн ажилтнууд шууд хүлээн авч хариу үйлчилгээг шуурхай үзүүлж, дуудлагыг хааж, шийдвэрлэдэг болсон нь үр дүнтэй байна. Өмнөх оны мөн үетэй	100

									харьцуулбал дуудлагын тоо 5 дуудлагаар буюу 4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	
41.	ТЖҮЧ 2.3.3 ЗДҮАХ 2.1.2	Эрсдэлийн программд бүртгэлтэй эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг хөгжлийн хөтөлбөрт хамруулах	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг хөгжлийн хөтөлбөрт хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	Эрсдэлийн программд байгаа хүүхдүүдийн 6% хамруулсан.	Эрсдэлийн программд байгаа хүүхдүүдийн 10% хамруулна.	10.0	Улсын төсөв	ГБХЗХГ	Тайлант онд нийт 569 хүүхэд бүртгэгдсэн. Дахин судалгааг шинэчилж 426 хүүхдийг илрүүлэн бүртгэлжүүлж, тусламж дэмжлэг 186, хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зөрчил 35, эрүүл мэндийн үйлчилгээнд 28, эцэг эхийг нь ажилд зуучилсан 5, архины хамааралтай гэр бүлд амьдарч байгаа 29 хүүхдэд сэтгэл зүйн болон халамжийн зэрэг үйлчилгээнүүдийг үзүүлж 283 хүүхдийг хамруулсан нь 66.4 хувийг эзэлж байна. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо 4 хүүхдэд холбогдох үйлчилгээг үзүүлсэн. Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн хуралдааныг 1 удаа зохион байгуулж, 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Гэрийн эргэлтээр байнгын хяналтад 93 хүүхэд байна. Номин даатгалтай хамтран 258 хүүхдийг даатгалд хамруулсан.	100
42.	ТЖҮЧ 2.3.3 ЗДҮАХ 2.1.2	Түр хамгаалах байрны үйл ажиллагааг сайжруулах, дутуу баригдсан барилгын үйл ажиллагааг үргэлжлүүлэх	Барилгын ажлыг үргэлжлүүлнэ.	Барилгын ажил дутуу 40%-ийн гүйцэтгэлтэй байна.	Барилгын үйл ажиллагааг 70% -д хүргэнэ.	30.0	Орон нутгийн төсөв	ГБХЗХГ	Тайлант онд 67 хүнд үйлчилгээ үзүүлж 23.5 сая төгрөг зарцуулсан. Дуудлага мэдээллээс гэр бүлийн хүчирхийлэл 22 буюу 32.8 хувийг эзэлж байна. Түр хамгаалах байрны барилгын үйл ажиллагаа 85 хувьтай байна.	100
43.	ТЖҮЧ 2.3.5 ЗДҮАХ 2.1.3	Залуучуудын ордны үйл ажиллагааг өргөжүүлэн, олон талт үйл ажиллагаа зохион байгуулах	Хамралтын хувь	Тохижилт 25% хийгдсэн байна	Залуучуудын хамрагдалт 40%-д хүрнэ.	339.6	Орон нутгийн төсөв	ГБХЗХГ	Тайлант онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 156.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардалд 183.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Давхардсан тоогоор 12000 залуучууд Залуучуудын ордноос үйлчилгээ авсан. Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хөгжлийн бэрхшээлтэй залуучуудад чиглэсэн урлаг, спорт, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлийн үйл ажиллагаа зохион байгуулж хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын нийгэмд эзлэх байр суурь зохих түвшинд дээшилсэн. Мөн тусгай шалгуурын дагуу 8 оюутан сургалтын тэтгэлэгт хамрагдаж, сурч боловсрох, хөгжих боломжоор дэмжин ажилласан байна. Залуучуудын ордонд сэтгэл зүйн цогц үйлчилгээ үзүүлэх өрөөг тохижуулж, “Сэтгэл нэмье” төслийг хэрэгжүүлж, нийгэмд эерэг мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж, 250 гаруй эрчүүдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ хүргэсэн. Мөн дартсын Эрчим клуб, Анза дуу бичлэгийн студи, бүжгийн Social dance клуб, шагай харваа, бийрэн бичиг, 1 амьд хөгжмийн хамтлагийг дэмжин дэргэдээ авч, хамтран ажиллаж, 11 сонирхлын клуб үйл ажиллагаа явуулж, бүртгэлтэй 200 гишүүн хамрагдаж байна. Тайлант хугацаанд 134 арга хэмжээнд 11440 гаруй хүүхэд залуучууд хамрагдсан.	100
44.	ТЖҮЧ 2.3.5 ЗДҮАХ 2.1.3	Залуучуудад чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг нэмэгдүүлэх, сайн дурын ажилд оролцоог дэмжих, бүртгэх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах	Хамралтын хувь	Залуучуудын 25% хамрагдсан.	Залуучуудын 40% хамрагдана.	158.0	Орон нутгийн төсөв	ГБХЗХГ	Тайлант онд “Сэтгэл нэмье” төслийн хүрээнд Updated хөвгүүдэд зориулсан сургалтыг “Өсвөр насны хүүхдийн сэтгэл зүйн онцлог, хайрцаглагдсан эр хүн” сэдвээр ЕБС-ийн 15,16,17,1-р сургуулийн ахлах ангийн 200 гаруй хөвгүүд, Макреме сүлжмэл, эсгий гутал хийх сургалт, сүлжмэл тоглоом хийх, гар урлалын сургалтад 80 залуучууд, Жаргалант сумын 200 өсвөр үе, хүүхэд, залуучуудад ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө, бүлгийн уулзалт зөвлөгөө, “Мэргэжил сонголт”, “Сайн дурын ажилд залуусаа манлайлцгаая”, “Аз жаргалтай гэр бүлийг бүтээцгээе”, “Ажлын байрандаа эерэг соёл бүтээцгээе”, “Хаа ч байсан хайртай аав ээж байя”, “Эрүүл мэндээ хамгаалцгаая” зэрэг сэдэвт сургалтуудыг төрийн 10 байгууллага, үйлдвэрийн 4 газар, хувийн хэвшлийн 1, ЕБ-ын 8 сургуульд нийт 3500 залуучуудыг хамруулан тус тус зохион	70

									байгуулсан. "Сэтгэл Нэмье" гэр бүлийн өдөрлөгийг 11 удаагийн давтамжтай зохион байгуулж 60 гаруй гэр бүл оролцсон. - Нөхөн үржихүйн боловсрол олгох сургалтыг Орхон аймгийн ЕБ-ын нийт 15 сургуулиудад зохион байгуулж 1000 орчим өсвөр үеийн хөвгүүд хамрагдсан. Сургалт, олон талт нөлөөллийн үйл ажиллагаанд нийт 6040 хүн хамруулсан нь нийт залуучуудын 20 хувийг эзэлж байна. Амьдрах ухаан, нөхөн үржихүйн чиглэлийн 231 постер зөвлөмжийг хийж, цахимаар өсвөр үе залуучуудад сурталчилсан нь 34650 тандалт авсан.	
Зорилт 2.4. Шинжлэх ухаан, технологийг аймаг, хотын тогтвортой хөгжлийн үндсэн хүчин зүйлсийн нэг болгон хөгжүүлж, үр ашигтай инновацыг хөгжүүлнэ.										
45.	ТЖҮЧ 2.3.5 ЗДҮАХ 3.3.2	Залуучуудын ордныг түшиглэн “Залуу зохион бүтээгчдийн төв” байгуулах	“Залуу зохион бүтээгчдийн төв” байгуулах	-	Төвийг байгуулна.	-	-	ГБХЗГ, БШУГ	Залуучуудын ордны дэргэдэх unitel hub төвд робот угсралт, программчлалын robo kid сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж, 40 сурагчийг хамруулан тэдний STEAM боловсролыг дэмжихийн зэрэгцээ, смарт юмс хэрхэн бүтээгддэгийг ойлгох, төхөөрөмжийг угсрах явцад техник сэтгэлгээ, зохион бүтээх чадвар, авьяасыг хөгжүүлснээр одоогийн байдлаар 13 сурагчид Robo kid Робот угсралт инженерчлэл, кодчиллын анхан шатны сертификатыг олгоод байна. 14 дүгээр сургуульд хэрэгжиж байсан залуу зохион бүтээгчдийн "Хос нислэг" клубтэй хамтран техник, загварын спортоор дамжуулан ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын техник сэтгэлгээ, инженер сэтгэлгээ, зохион бүтээх чадварыг хөгжүүлэх "Би инженер" төслийг Залуучуудын ордны дэргэд хичээллүүлэхээр өрөө, танхимыг тохижуулж, хичээллэх бэлтгэл ажлыг хангаж байна. "Би инженер" төсөлд хамрагдан хичээллэж байсан 1 сурагч Техник технологийн улсын олимпиадад оролцож 2 дугаар байранд орсон амжилтыг үзүүллээ.	50
46.	ТЖҮЧ 2.4.	Аймаг, орон нутгийнхаа байгалийн болон бусад нөөцөд тулгуурласан, шинжлэх ухаан, технологийн үр дүнд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх	Бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгох	Суурь судалгаа бий болж, ажил эхэлсэн байна.	Технологи дамжуулах, бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгох	3.0 130.0	Орон нутгийн төсөв Гадаад зээл	ХБТХОХ ЭШУТП	Эрдэнэт ШУТП нь Германы хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран, орон нутгийн байгалийн болон бусад нөөцөд тулгуурласан, шинжлэх ухаан, технологийн үр дүнд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэсэн 12 төслийг сонгон шалгаруулж, зөвлөх үйлчилгээ үзүүлж байна. Эдгээр төслүүдэд 130.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Эрдэнэт хотын тулгамдсан асуудлыг бүхий л салбарын хүрээнд болон түвшин бүрд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлж, орон нутгийн нөөц бололцоонд түшиглэсэн гарц шийдлийг эрэлхийлэх, шинэ санал санаачилга дэвшүүлэх, харилцан туршлага солилцох, бүс нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах, эрдэмтэн судлаачдын судалгааны ажлын үр дүнг сурталчлах зорилгоор "Эрдэнэт хотын тулгамдсан асуудал, гарц шийдэл" эрдэм шинжилгээний хурлыг Орхон аймгийн боловсрол, шинжлэх ухааны газартай хамтран зохион байгуулсан.	70
47.	ТЖҮЧ 2.4.2 ЗДҮАХ 3.3.2	Их, дээд сургууль, МСҮТ, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдыг хамруулсан гарааны бизнесийг дэмжин хөгжүүлэх	Гарааны бизнесийг дэмжин хөгжүүлэх	Гарааны 5 бизнес санааг дэмжсэн.	Гарааны 5 бизнес санааг дэмжин хөгжүүлнэ.	33.0	Орон нутгийн төсөв	НБХ ШУТП Хувийн хэвшил	2022 онд "Боломжоос өөрчлөлт рүү" шинэ санаа, шилдэг технологийн уралдаан зохион байгуулж, 20 гаруй гарааны бизнесийн санаа бүртгэснээс 5 төслийг шалгаруулан тус бүр 400.000 төг санхүүжилт олгож дэмжсэн. 2023 онд "Судлаач-Энтрепренер" хөтөлбөр хэрэгжүүлж инновацын төсөл, гарааны компани хөгжүүлэх 18 залуу судлаач, оюутны төсөл хүлээн авч, оролцогчдыг 2 сарын турш сургалтад хамруулан сонгон шалгаруулалтаар 1 дүгээр шатанд шалгарсан	100

									ШУТИС-ийн 2 оюутныг төслөө хэрэгжүүлэхэд ажлын байраар хангаж байна. Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн 120 оюутны дунд гарааны бизнесийн уулзалт зохион байгуулж, 20 оюуны баг бүрдүүлэн зөвлөн ажиллаж байна. "Гарааны бизнес-2023" төслийн хүрээнд өрхийн болон бичил бизнес эрхлэгч 33 иргэнд эргэн төлөгдөх нөхцөлөөр 2 жилийн хугацаатай, тус бүр 5.0 сая, хүнсний болон ногоон сууцны үйлдвэрлэлийн 3 төсөлд эргэн төлөгдөх нөхцөлөөр 2 жилийн хугацаатай, тус бүр 35.0 сая, нийт 270.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. IT-гийн чиглэлээр компьютерын код бичих мэдлэг олгох сургалтад 62 сурагч хамруулсан ба орон нутгаас 33.0 сая төгрөгийн компьютероор дэмжлэг үзүүлсэн.	
48.	ТЖҮЧ 2.4.2.	Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийг түшиглэн боловсрол эрдэм, шинжилгээ, үйлдвэрлэлийн уялдаа холбоог бий болгох, “Байгалийн ухаан, инженерчлэлийн Эрдэнэт сургалтын үйл ажиллагааг явуулах, сургалтын чанарыг дээшлүүлэх, оюутан суралцагчдын бүтээлч байдлыг хөгжүүлэх	3 модуль сургалт бий болох	Төсөл, хөтөлбөр хэрэгжиж эхлэн 1 модуль сургалт орж эхэлсэн.	3 модуль сургалт бий болох	-	-	НБХ ЭШУТП	Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийг түшиглэн хүүхдүүдийг байгалийн ухааны хичээлд сонирхолтой болгох, улмаар ирээдүйн чадварлаг инженерүүдийг төрүүлэх зорилгоор ЕБС-ийн физик, мэдээлэл зүйн хичээлийн агуулгад тохирсон туршилтуудыг сонирхолтой хэлбэрээр хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй, системтэй мэдлэг олгоход анхааран ажиллаж байна. STEAM боловсрол олгох ШИМТ+ЭРДЭНЭТ дугуйлан энэ онд 5 мэргэжлийн багш, 150 орчим хүүхдүүдэд сургалт өгсөн. "Судлаач-Энтрепренер" хөтөлбөр хэрэгжүүлж инновацын төсөл, гарааны компани хөгжүүлэх 18 залуу судлаач, оюутны төсөл хүлээн авч, оролцогчдыг 2 сарын турш 3 модуль сургалтад хамруулан сонгон шалгаруулалтаар 1 дүгээр шатанд шалгарсан ШУТИС-ийн 2 оюутныг төслөө хэрэгжүүлэхэд ажлын байраар хангаж байна. Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн 120 оюутны дунд гарааны бизнесийн уулзалт зохион байгуулж, 20 оюуны баг бүрдүүлэн зөвлөн ажиллаж байна.	100
49.	ТЖҮЧ 2.4.1. ЗДҮАХ 3.3.2.	Бизнес эрхлэгчдэд инновацын төсөл, ЭШУТП-ын ТЭЗҮ боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг зах зээлд гаргах, хөгжүүлэхийг дэмжих	Инновацын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг зах зээлд гаргах, хөгжүүлэхийг дэмжих	1 бизнес эрхлэгчид технологи дамжуулсан.	Бизнесийг дэмжих, хөгжүүлэх үйлчилгээг 3 бизнес эрхлэгчдэд хүргэнэ.	32.0	Олон улсын байгуулллага	ХБТХОХ ХХААГ ЭШУТП Сумдын ЗДТГ	2022 онд цаас, хүнсний хог хаягдлыг дахин боловсруулж түлш үйлдвэрлэх төсөл буюу "Агдир бүтэмж" ХХК, яс дахин боловсруулж нохойн хоол үйлдвэрлэх "Хос луу баян" ХХК, арьс шир боловсруулж "Handmade" бүтээгдэхүүн үйлдвэрлэх "Өндөрлөг" брэнд зэрэг 3 бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүний технологийн хөгжүүлэлт, зах зээлд гаргах дээр бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлж дэмжин ажилласан. 2023 онд хүнсний ногооны үр үйлдвэрлэлийн төслийг инновацын төслөөр хөгжүүлэхээр зөвлөх үйлчилгээ үзүүлж байна. "Баяжуулагч-Одод" ХХК-ийн хатаасан аарц, "Идэрбаялаг" ХХК-ийн давсалсан махны хатаамал зэрэг инновац шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжихэд тус бүр 6.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. Цаасны хог хаягдлаар эко түлш боловсруулах үйлдвэрлэл эрхэлж буй "Агдир бүтэмж" ХХК гарааны бизнес эрхлэхэд нь дэмжлэг үзүүлж үйлдвэрлэсэн түлшээ нөөцлөхөд зориулж 20.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. 11 өрхийн үйлдвэрлэл эрхлэгч нэгдэн хоршоо байгуулж мөөг ургуулах хөрс үйлдвэрлэж байна. Ингэснээр сард 500 кг мөөгийг ургуулах боломж бүрдүүлээд байна. Иргэн Зулчимэгийн амттаны үйлдвэрлэл, "Ган компасс" ХХК-ийн экспортын тоглоом үйлдвэрлэл, "Мөөг кластер" ХХК-ийн чипс үйлдвэрлэл, тариалалтын ухаалаг чингэлэг үйлдвэрлэл, эмийн мөөг тариалалт, "Бидэрт манхан" ХХК-ийн	100

									хуванцар эдлэл үйлдвэрлэл, "БМОМ" ХХК-ийн биомасс боловсруулах зэрэг 9 төслийг дэмжин хөгжүүлж байна.	
50.	ТЖҮЧ 2.4.1 ЗДҮАХ 3.3.3	Бизнес эрхлэгчдэд инновацын төсөл хэрэгжүүлэх, зөвлөх үйлчилгээг үе шаттай хүргэх, чадавхжуулах	Инновацын төсөл хэрэгжүүлэх, зөвлөх үйлчилгээг үе шаттай хүргэх, чадавхжуулах	8 бизнес эрхлэгч	10 бизнес эрхлэгчийг чадавхжуулна.	100.0	Олон улсын төсөл хөтөл бөр	ХБТХОХ ЭШУТП Хувийн хэвшил	Европын Холбооны "СВИЧ-Эйшиа" хөтөлбөрийн хүрээнд дөрвөн жилийн хугацаанд нийт 2.2 сая европын санхүүжилттэйгээр "Эдийн засгийн ногоон шилжилт" төслийг Пипл ин Нийд, Каритес Чех Репаблик, Монголын тогтвортой хөгжлийн санхүүжилтийн холбоо, Хөгжлийн шийдэл ТББ хамтран хэрэгжүүлж байна. Тус төслийн хүрээнд газар тариаланд суурилсан хүнс, ундааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бичил, жижиг, дунд үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчдэд салбартаа тогтсон хэв загвараа илүү ногоон болгон өөрчлөхөд нь шаардлагатай техникийн туслалцаа үзүүлэх, ногоон баталгаажуулалт, эко шошгожуулалтыг зах зээлд нэвтрүүлж, ногоон санхүүжилтэд хүрэхэд туслах зорилготой сургалт зохион байгуулж "Чацарганы шүүс үйлдвэрлэл"-ийн чиглэлээр хувиараа хөдөлмөр эрхлэгч 1 иргэн зөвлөх үйлчилгээ авч байна. 2023 онд ЭШУТП-ийн Технологи дамжуулах төв нь дундын оффисын чиглэлээр үйл ажиллагаа явуулж, 40 гаруй аж ахуйн нэгж, 200 иргэнд зөвлөх үйлчилгээ үзүүлж байна. Хүнсний ногооны үр үйлдвэрлэлийн чиглэлээр 1 аж ахуйн нэгжид технологи дамжуулж үйлдвэрлэлийг эхлүүлсэн. Мөн "БМОМ" ХХК, "Мөөг кластер" ХХК-иудад мөөгний технологийн зөвлөх үйлчилгээ үзүүлж байна. ЭШУТП нь Шинжлэх ухаан, технологийн сантай хамтран халтиргаанаас сэргийлэх зорилгоор цас, мөс хайлуулах бодис, сахар үйлдвэрлэл, дулааны станцын хаягдал үнс дахин боловсруулах чиглэлээр судалгааны ажил хийж байна.	100
Зорилт 2.5.Эрүүл, аюулгүй, баталгаат орчин бий болгоно.										
51.	ТЖҮЧ 2.5.1 ЗДҮАХ 4.1.1	Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, зам талбай, тохижилтын нэгдсэн мэдээллийн сан байгуулж болзошгүй аваарыг түргэн шуухай илрүүлж, засварлах ажлыг зохион байгуулах	Болзошгүй аваарыг түргэн шуухай илрүүлж, засварлах ажлыг зохион байгуулах	-	Аюул эрсдэлийг бууруулна.	1092.8	Орон нутгийн төсөв	ХЗА	2023 онд Erdenet.mn сайтаар дамжуулан Эрдэнэт иргэн https://irgen.erdenet.mn/ хэсэгт иргэдийн өгсөн мэдээллийн дагуу холбогдох газруудтай хамтран газар дээр нь үзлэг шалгалт хийж болзошгүй гэмтэл эвдрэлийг илрүүлж, засварлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2023 онд аваарын байдалтай байсан ДГТ-3-р байрны подвалын инженерийн шугам сүлжээг шинэчлэх шинэчлэх ажилд 79.9 сая төгрөг, төрийн албан хаагчдын чийрэгжүүлэлтийн танхимын инженерийн шугам сүлжээ, узелыг засварлаж шинэчлэх ажилд 79.3 сая төгрөг, Говил баг, Арбулаг хэсэгт 6/0.4 кВ-ын 160 кВА дэд станц, 6/0.4 кВ-ын ЦДАШ барих ажилд 96.2 сая төгрөг, Уурхайчин багт хот дахин төлөвлөлтийн барилгажуулах төслийн цэвэр усны шугам шилжүүлэх ажилд 243.6 сая төгрөг, Уртын гол багт баригдсан 260 айлын орон сууцны ус, дулаан, дамжуулах төвд нэмэлт тоноглол суурилуулах ажилд 36.7 сая төгрөг, Чандмань багт Эко хороллын гадна шугам сүлжээний шинэчлэлт, засварын ажилд 543.8 сая төгрөг, Дэнж багийн Баруун дэнжийн 4 дүгээр гудамжинд байршилтай ус түгээх байранд цэвэр усны нөөцийн сав байрлуулах /гадна пандусны хамт/ ажилд 13.2 сая төгрөг нийт 1.1 тэрбум төгрөгийг болзошгүй аваарын зардлаар шийдвэрлэснээр нийт ажлын гүйцэтгэл 95 хувьтай хэрэгжиж байна.	100
52.	ТЖҮЧ 2.5.1	Газар хөдлөлтийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг хийлгэх	Нарийвчилсан үнэлгээг хийлгэх	-	Эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг	50.0	Орон нутгий	ОБГ	Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийг 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдөр хуралдуулж, 2023 онд авч хэрэгжүүлэх 13 заалт бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг	100

	ЗДҮАХ 4.3.11				хийлгэсэн байна.		н төсөв		хангаж ажиллаж байна. 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газар хөдлөлтийн гамшигт тэсвэргүй гэсэн мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан барилгуудын танилцуулга, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хуралдаж шийдвэрийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.	
53.	ТЖҮЧ 2.5.2 ЗДҮАХ 5.5	Гэр хорооллын дахин төлөвлөх үйл ажиллагааг олон нийтийн оролцоотой зохион байгуулж, төлөвлөлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж хүлээн авах	Төлөвлөлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж хүлээн авах	-	Төслийн хэрэгжилт 60%	-	-	ХЗА ХБТХОХ	Аймгийн хэмжээнд Цагаанчулуут багт 11.9 га, Уурхайчин багт 1.3 га газарт дахин төлөвлөлтийг хийхээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоолоор батлуулсан. Тус тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Уурхайчин багт 1.3 га газарт дахин төлөвлөлтийн ажил гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулан төсөл эхлүүлснээр хэрэгжилт 30 хувьтай, Цагаанчулуут багт 11.9 га талбайд дахин төлөвлөн барилгажих хэсэгчилсэн төлөвлөлтийн зураг төсөл хийгдэж байна. Дахин төлөвлөх үйл ажиллагааг мэргэжлийн байгуулаагаар хийлгэх ажлын хүрээнд Эрдэнэ багт 2.5 га талбайд дахин төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулан сонгон шалгаруулалт зарласан. Оюут багийн Сархиа уулын энгэрт 4 га талбайд 300 айлын амины орон сууцны төслийг хэрэгжүүлэхээр суурь судалгааны ажил хийгдэж байна. Баян-Өндөр сумын Хүрэнбулаг багт Уурхайчин-1 хорооллын баруун талд амины болон цөөн давхар барилгын хэсэгчилсэн төлөвлөлтийг 10га талбайд хийлгэж байгаа ба зураг төсөл боловсруулах ажил 30 хувийн гүйцэтгэлтэй байна.	70
54.	ТЖҮЧ 2.5.2 ЗДҮАХ 5.5	Гэр хорооллын багийн төвүүд болон айл өрхийн төвлөрсөн шугам барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Төвлөрсөн шугам барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	-	3.29 км	1,200.0	Улсын төсөв	ХЗА ХБТХОХ	Цагаанчулуут багийн өргөх насос станцаас Наран багийн УДХТ хүртэлх Ф125, Ф159 мм-н 1.2 км ил дулааны шугамыг шинэчилж сувагт хийх ажлын нийт төсөвт өртөг 4.3 тэрбум төгрөгийн дүнтэй ажил 75 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Тус ажлын хүрээнд Ф273мм диаметртэй 1.7 км урттай дулааны хос ган яндан хоолой, Ф200мм диаметртэй цэвэр усны шугам цайрдсан ган яндан угсралт хийгдэнэ. Мөн Их залуу багт төв дулаан, цэвэр усны шугам, ус дулаан дамжуулах төвийн барилга, 1.7 км 3 хос гадна инженерийн шугам сүлжээний ажлын нийт төсөвт өртөг 1.37 тэрбум төгрөгийн дүнтэй ажил 98 хувийн гүйцэтгэлтэйгээр ажиллаж байна. Дээрх 2 ажил хийгдсэнээр Цагаанчулуут, Наран, Их залуу багийн айл өрхийг төвлөрсөн инженерийн шугам сүлжээний холбогдох нөхцөл бүрдэнэ. Хотын нийтийн орон сууцууд болон аж ахуйн нэгж, байгууллагыг төвлөрсөн дулаан хангамжаар хангадаг 3.5 км төв дулааны шугамыг ф720 мм-ын шугамаар өргөтгөн барих 4.3 тэрбум төгрөгийн төсөвтэй ажил 65 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.	90
55.	ТЖҮЧ 2.5.5 ЗДҮАХ 4.3	Орон нутгийн хэмжил зүйн лабораториудын эталоны анги нарийвчлалыг дээшлүүлэх, итгэмжлэлийн хүрээг өргөтгөх	Итгэмжлэлийн хүрээний төрөл, тоо, ширхгийг нэмэгдүүлсэн байна.	Итгэмжлэлийн хүрээний төрөл , тоо, ширхэг 4	Итгэмжлэлийн хүрээний төрөл, тоо, ширхэг 5	-	-	СХЗХ	2022 онд газын түгээгүүр шалгах даралтат цилиндр, хошуу, газын денсиметр, KERN маркийн 0.01 нарийвчлал бүхий 60 кг, 0.0001 нарийвчлал бүхий 210 г эталон жинг механик хэмжлийн лабораторт, сорьцын хяналтад KERN маркийн 0.1 нарийвчлал бүхий бичил жингээр хангагдан, үйл ажиллагаандаа ашиглаж байна. Нийт 4 аж ахуйн нэгжийн 7 ш хийн түгээгүүрийг холбогдох стандартын дагуу шалгаж баталгаажуулж байна. 2020 онд цахилгаан хэмжлийн төрлөөр CALMET TE30 маркийн тоолуур шалгах горимтой чадлын хяналтын зөөврийн багажаар эталоны нэр төрлийг нэмэгдүүлсэн бөгөөд МС маркийн 0.001 г/см3 нарийвчлалын ангийн 0.500-0.650 г/см3 хэмжих хязгаар	100

									бүхий газденсиметр, ШТС-ын нөөцлөх савны хазайлтыг хэмжих зориулалттай невлер эталон тоног төхөөрөмжийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Эзлэхүүний хэмжлийн төрлөөр шалгалт тохируулгын эрх, температурын хэмжлийн төрлөөр улсын шалгагчийн эрх авснаар хэмжил зүйн шалгалт, баталгаажуулалтын чиглэлээр 5, шалгалт тохируулгын чиглэлээр 3 нэр төрлийн үйл ажиллагаа явуулж байна.	
56.	ТЖҮЧ 2.5.5	Бүтээгдэхүүн үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд Чанар, ХАБЭА-н менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх аж ахуйн нэгж, байгууллагуудад олон улсын стандартын мэдээлэл, сургалт зохион байгуулах, зөвлөн туслах	Сургалт, нэвтрүүлсэн байгууллагын тоо	Сургалтад хамрагдсан байгууллагын тоо 10 Нэвтрүүлсэн байгууллагын тоо 3	Сургалтад хамрагдсан байгууллагын тоо 30, Нэвтрүүлсэн байгууллагын тоо 4	2.0	Орон нутгийн төсөв	СХЗХ	"Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018" сэдэвт сургалтад 3 аж ахуйн нэгж, байгууллагын 7 ажилтан хамруулснаар махны 1 үйлдвэрийн лаборатори итгэмжлэгдэж, төрийн 1 лаборатори итгэмжлэлийн магадлан үнэлгээнд хамрагдсан. Бүтээгдэхүүн үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх "Чанарын удирдлагын тогтолцоо-Шаардлага MNS ISO 9001" стандартын сургалтад 3 байгууллагын 11 хүнийг хамруулан гэрчилгээ олгосон. Менежментийн тогтолцооны аудитын заавар MNS ISO 19011:2020 стандартын сургалтыг 5 ахуйн нэгж, байгууллагын 12 хүнийг хамруулан сургаж гэрчилгээ олгосон. Хоол, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 20 байгууллагын ажилтнуудад салбарын болон бусад хууль, эрх зүйн уялдаа холбооны талаар мэдлэг олголоо. Хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн хүнсний аюулгүй байдлын талаарх хууль эрхзүйн мэдлэг, салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах 1 сарын хөтөлбөрт сургалтыг Best хөтөлбөр, Обзерв Консалтинг хүнсний аюулгүй байдлын зөвлөх байгууллагатай хамтран зохион байгуулж, хүнсний боловсруулах 35 үйлдвэр, цехийн ажилтнуудыг 5 удаагийн сургалтад хамруулан мэдлэг олгон сертифкатжуулсан.	100
57.	ТЖҮЧ 2.5.5 ЗДҮАХ 4.3	Хүнсний сүлжээний бүх үе шатанд чанар, аюулгүй байдлыг дээшлүүлэн, баталгаажуулалтын төвшнийг нэмэгдүүлэх.	Баталгаажуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний хувь	Баталгаажуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээ 40%	Баталгаажуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээ 50%	-	-	СХЗХ	Хүнсний чиглэлийн үйлдвэрлэл эрхлэгч 9 аж ахуйн нэгж, үйлчилгээ эрхлэгч 174 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд холбогдох стандартын дагуу тохирлын үнэлгээ хийж, стандартын хэрэгжилтийн түвшнийг дээшлүүлэх арга зүйгээр хангаснаар нийт 17 аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 142 хүнсний чиглэлийн үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгосон нь баталгаажуулсан бүтээгдэхүүн үйлчилгээний түвшнийг 4.4 хувиар нэмэгдүүлсэн байна.	50
ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА **Зорилт 3.1.** Ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлнэ.										
58.	ТЖҮЧ 3.1.2 ЗДҮА 2.1.4	“Ач санах” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Хөтөлбөрийг хэрэгжүүлнэ	40.0 хувь	Хэрэгжилт 60 хувь	105.0	Орон нутгийн төсөв	НБХ	Ахмад настны Ач санах хөтөлбөр нь 3 зорилтын хүрээнд 20 үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2023 онд хөтөлбөрийн хүрээнд: -Олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Зэвсэгт хүчний 102 жил, Монгол цэргийн бахархлын өдөрт зориулсан Хүндэтгэлийн арга хэмжээ, "Эх үрийн элбэрэл" тоглолт, "Ахмадууд дуулж байна" урлагийн наадам, аймгийн аварга шалгаруулах волейбол, шатар, софт воллейбол, ширээний теннисний тэмцээн, сар бүрийн 15-ны өдөр ахмадын "Дуулах өдөр" дуун цэнгүүн, ахмад настанд чиглэсэн 4 удаагийн сургалтын үйл ажиллагаа зэрэг арга хэмжээнүүдэд давхардсан тоогоор 13600 гаруй ахмад	100

									хамрагдсан байна. Мөн Орхон аймгийн ХХҮГ, Улаан загалмайн хороо хамтран Жаргалант сумын 78 ахмад, Баян-Өндөр сумын 224 ахмад настныг өдрийн үйлчилгээнд хамруулсан. Мөн олон улсын ахмадын өдрийг угтан хэвтрийн өвчтэй 250 ахмадад хүндэтгэл үзүүллээ. 2023 оны 9 дүгээр сараас эхлэн ахмад настанд зориулсан алжаал тайлах өрөө, номын сан, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх танхимыг тохижуулан ажиллуулж өдөрт 30-45 хүн тогтмол үйлчилгээ авч байна. Мөн номын сангийн номын фондыг ахмадууд нэмэгдүүлэн одоогоор 1500 орчим номтой болоод байна. Ахмадын ордонд сэтгэл зүйчийн танхимыг нээн ажиллуулснаар 1 сарын хугацаанд бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөөг 100 гаруй ахмадад, ганцаарчилсан зөвлөгөөг 19 ахмадад тус тус өгсөн. Дээрх үйл ажиллагаануудад орон нутгийн төсвөөс 105.0 сая төгрөг зарцуулаад байна.	
59.	ТЖҮЧ 3.1.2 ЗДҮА 2.1.4	“Анхдагч” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Хөтөлбөрийг хэрэгжүүлнэ	40.0 хувь	Хэрэгжилт 60 хувь	40.0	Орон нутгийн төсөв	НБХ	Анхдагч дэд хөтөлбөр нь 3 зорилт 10 үндсэн үйл ажиллагагааг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Хөтөлбөрийн хүрээнд МАНЗ-Баатар холбоо, төрийн байгууллагуудын Соёмбо холбоо, Эрдэнэтийн овооны анхдагч илгээлтийн эздийн холбоо, Барилгачин дайчдын холбоо, Залуу насаа эргэн дурсахуй холбооны гишүүдийн дунд зохион байгуулах олон талт үйл ажиллагааны зардалд 28.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Тус дэмжлэгийн хүрээнд хүнд нөхцөлд амьдарч буй 87 анхдагчид тусламж, хэвтрийн өвчтэй 127 анхдагчид гэр эргэлт, ахмадын сувилалд 197, өдөр өнжүүлэх үйл ажиллагаанд 85 анхдагч тус тус хамрагдсан. Мөн тэмдэглэлт өдрүүдийн арга хэмжээг 3, сургалтын үйл ажиллагаа 2, туршлага судлах уулзалт аялал 5, спортын урлагийн 5 төрөлт тэмцээн зэргийг зохион байгуулж 1400 гаруй анхдагч, ахмадууд хамрагдсан байна. Дээрх үйл ажиллагаануудад орон нутгийн төсвөөс 40.0 сая төгрөг зарцуулаад байна.	100
Зорилт 3.2.Хүн амын бүлгүүдийн хэрэгцээ, шаардлагын ялгаатай байдалд нийцүүлэн, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэж, ил тод, нээлттэй байдлыг хангана.										
60.	ТЖҮЧ 3.2 ЗДҮАХ 2.2.2	Нийгмийн халамжийн багц хуулийн хүрээнд нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх	Нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх	Нийгмийн халамжийн 72 үйлчилгээнд давхардсан тоогоор 40500 иргэн хамрагдсан.	41500 иргэнд (давхардсан тоогоор)	1,500.0 137.9	Улсын төсөв Орон нутгийн төсөв	ХХҮГ	Тайлант онд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн 72 төрлийн үйлчилгээнд давхардсан тоогоор нийт 41500 иргэн хамрагдаж 1.6 тэрбум төгрөг зарцуулсан. Хүүхдийн мөнгөн тэтгэмжид 38575 хүүхэд хамрагдаж 46.3 тэрбум төгрөг зарцуулсан.	100
61.	ТЖҮЧ 3.2.1 ЗДҮАХ 2.2.2	Нийгмийн халамжийн үйлчилгээг ehalamj системд шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэх	Халамжийн үйлчилгээг цахимжуулна.	55 хувь буюу Нийгмийн халамжийн 32 үйлчилгээг цахимд шилжүүлсэн.	72 төрлийн үйлчилгээний 80 хувийг цахимжуулна.	-	-	ХХҮГ	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Цахим Монгол" хөтөлбөрийн хүрээнд 2020 оны 08 дугаар сараас эхлэн нийгмийн халамжийн үйлчилгээ нь ehalamj.mn цахим системд үе шаттайгаар шилжиж эхэлсэн. 2020 онд 6, 2021 онд 26 төрлийн үйлчилгээ дээрх системд шилжсэн. 2022 онд 40 үйлчилгээг цахимд шилжүүлж, нийгмийн халамжийн үйлчилгээ 100% цахимжсаны үр дүнд иргэд нийгмийн халамжийн үйлчилгээнд цахимаар хамрагдаж, өргөдөл хүсэлтээ гаргах боломж бүрдсэн.	100
Зорилт 3.3. Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий суурцаар хангах бодлогыг дэмжинэ.										

62.	ТЖҮЧ 3.3.2 ЗҮАХ 5.3	Инженерийн хангамжтай нийтийн орон сууцны хорооллуудыг гэр хорооллын багуудад барьж аймгийн орон сууцны санг нэмэгдүүлэх	Аймгийн орон сууцны санг нэмэгдүүлэх	Уртын гол багт шинээр орон сууц барих газрын асуудал шийдвэрлэг дэж ажил эхэлсэн.	5 блок, 260 айлын орон сууцны ажлын гүйцэтгэл 80 хувь	27400.0	Эрдэнэт үйлдвэр, Орон нутгийн төсөв	ХЗА ХБТХОХ	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар дундаж орлоготой өрхүүдэд зориулан түрээслэх болон өмчлөх хэлбэрээр Уртын гол багт 5 блок бүхий 260 айлын орон сууцны барилгын ажил хийгдэж байна. 5 блок барилгын А блок 70 хувь, D блок 80 хувь, Е блок 12 хувийн гүйцэтгэлтэй, В,С блок ажил бүрэн дуусаж ашиглалтад хүлээлгэн өгснөөр тус төсөл 80 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Одоогийн байдлаар ашиглалтад орсон 2 блок барилгад нийт 70 айл орсон. Төслийн хүрээнд Ус дулаан дамжуулах төв, цахилгааны дэд өртөөний барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулсан. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтаар 400 айлын "Уурхайчин-3" амины орон сууцны хорооллын барилга угсралтын ажил 55 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Мөн хувийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд нийтийн орон сууцны 863 айлын 15 төсөл Оюут, Цагаан чулуут, Найрамдал, Зэст багуудад тус тус баригдаж байгаагаас одоогийн байдлаар 448 айлын орон сууц ашиглалтад орсон.	100
63.	ТЖҮЧ 3.3.2 ЗҮАХ 5.3	Инженерийн хангамжтай нийтийн болон амины орон сууцны хорооллуудыг барьж аймгийн орон сууцны санг нэмэгдүүлэх	Аймгийн амины орон сууцны санг нэмэгдүүлэх	Инженерийн хийцлэлтэй амины орон сууцны тоо...	Амины орон сууцны иж бүрэн зураг төсөл боловсруулсан байна.	32.0	Орон нутгийн төсөв	ГХБХБГ	Амины орон сууцны иж бүрэн нэг маягийн загвар зураг төсөл боловсруулах ажилд аймгийн төсвөөс 32.0 сая төгрөг баталсан. Төсвийн хүрээнд Зураг төсөл боловсруулах даалгавар боловсруулсан. Одоо төсөл сонгон шалгаруулалтын ажил хийгдэж байна.	70
Зорилт 3.4 Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд үр дүнд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлэн ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ.										
64.	ТЖҮЧ 3.4.1 ЗДҮАХ 2.2.5, 2.2.6	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх, мэргэжлийн сургалтад хамруулан, ажилд зуучлах үйлчилгээг хэрэгжүүлэх	Мэргэжлийн сургалтад хамруулан, ажилд зуучлах	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө мэдээллийг зорилтот бүлгийн 1200, мэргэжил олгох сургалт 54, ажилд зуучлах үйлчилгээнд 1000 иргэн хамрагдсан.	Зорилтот бүлгийн 600 иргэнд өгөх, сургалтад 90, ажилд зуучлах үйлчилгээнд 1000	145.5	Улсын төсөв	ХХҮГ	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс жил бүр баталж хэрэгжүүлдэг "Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр"-ийн хүрээнд Орхон, ХАА-н МСҮТ-үүдтэй хамтран хийж, цахилгаанчин, тогооч, барилгын засал чимэглэлч, гагнуурчин, үсчин, оёдолчин 7 мэргэжлээр ажил хайгч 95 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй 10 иргэн нийт 105 иргэнийг сургаж, 47.9 сая төгрөг зарцуулсан. Сургалтын дараа 10 иргэн байнгын ажлын байртай болж нийгмийн даатгалын шимтгэл төлж ажиллаж байна. Ажилд орсон иргэдийг салбараар нь авч үзвэл боловсруулах үйлдвэрт 3, уул уурхайд 2, худалдаа үйлчилгээнд 4, төрийн байгууллагад 1 иргэн тус тус ажилд орсон. Иргэд мэргэжлийн сургалтад хамрагдаж суурь мэргэжил эзэмшсэнээр залуучууд хөдөлмөрийн харилцаанд орж, орлого олохоос гадна эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулах боломж бүрдсэн. ХХҮЕГ-аас эрх авсан "Алтан алхам" сургалтын төв, Насан туршийн боловсролын төв зэрэг байгууллагуудтай хамтарч ерөнхий боловсролын түшиц 7 сургуулийн 8 дугаар ангийн 329 сурагч, хорих ангид хүмүүжиж байгаа 40 иргэн, ажил хайгч 31 иргэн нийт 400 иргэнд бүлгийн зөвлөгөө, 250 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө, нийт 650 иргэнд зөвлөгөө мэдээллийг өгч 5.0 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан. 2023 оноос хөдөлмөр эрхлэх чадавхын үнэлгээ, хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулах үйлчилгээг шинээр нэвтрүүлж 800 иргэнийг хамруулснаар ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг нийт 1450 иргэнд үзүүлсэн байна.	100
65.	ТЖҮЧ 3.4.2	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн	Бичил, жижиг, дунд	Хөтөлбөрт 86 иргэн	Хөтөлбөр-108, Ажил	846.6	Улсын төсөв	ХХҮГ	Тайлант онд нийт 101 иргэнд 830.0 сая төгрөгийг 50-100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй 24-36 сарын хугацаатай хүүгүй	90

	ЗДҮАХ 2.2.7,	тогтоолоор баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр арга хэмжээний хүрээнд бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих замаар ажлын байрыг нэмэгдүүлэх	бизнесийг дэмжих замаар ажлын байрыг нэмэгдүүлэх	хамрагдаж, 100 иргэн байнгын болон түр ажлын байраар, Ажил олгогчийн урамшуулал-13 иргэн хамрагдсан.	олгогчийн урамшуулалд 15, 150 байнгын болон түр ажлын байраар хангагдсан байна.				барьцаагүй олгосон. Үүний үр дүнд 101 ажлын байр хадгалагдаж 59 шинэ ажлын байр бий болсон байна. Залуучуудын Старт-ап арга хэмжээг "Шинэ эхлэл цэг" ТББ-ын сургалтын төвтэй хамтран зохион байгуулж, 65 залуусыг оролцуулснаас эцсийн шалгаруулалтаар 1 баг шалгарч 10.0 сая төгрөгийн буцалтгүй санхүүгийн дэмжлэг авч үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж шинээр 2 ажлын байр нэмэгдсэн. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд мэргэжлийн чадамжийн гэрчилгээ, цахим ур чадварын сертификат олгох 21 хоногийн цахим сургалтыг зохион байгуулж 40 эмэгтэйг хамруулж, 6.6 сая төгрөг зарцуулж, 5 ажлын байр бий болсон. Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2023 онд 2 ажил олгогч аж ахуй нэгж байгууллага 3 ажлын байранд гэрээ байгуулсан.	
66.	ТЖҮЧ 3.4.2	Бичил, жижиг, дунд бизнест чиглэсэн санхүүгийн, дэмжлэгийг нэмэгдүүлж, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх	Санхүүгийн, дэмжлэгийг нэмэгдүүлж, ажлын байр бий болгох	Ажлын байр нэмэгдүүлэх жижиг зээлд 15 иргэн, хамрагдаж 20 ажлын байр бий болгосон.	Жижиг зээлд 50 иргэн хамрагдаж 70 ажлын байр бий болгох.	290.0	Улсын төсөв	ХХҮГ	Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор батлагдсан жижиг зээл олгох журмын 2.8-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгож буй Жижиг зээлийн санхүүжилт авах хүсэлтэй 63 төсөл хэрэгжүүлэгчдийн танилцуулсан бизнесийн үйл ажиллагаа, төслөөс ажлын хэсгийн гишүүд 39 төсөл хэрэгжүүлэгчдийн материалыг Төрийн банкаар судлуулахаар шийдвэрлэсэн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох журмын дагуу зээлийн өмнөх сургалтыг Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран зохион байгуулсан. Банкаар судлагдсан иргэдээс 11 иргэн дэмжигдэж 290.0 сая төгрөгийн санхүүжилтийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Төрийн банкаар дамжуулан олгож, 12 ажлын байр хадгалагдан шинээр 15 ажлын байр бий болсон байна. Жижиг зээлд хамрагдсан 11 иргэний ажлын байр болон үйл ажиллагаатай танилцахад, ихэнх иргэд үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүнээ авч, захиалсан үр дүнтэй байна.	78
67.	ТЖҮЧ 3.4.2. ЗДҮАХ 7.2.3.	"Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Шинэчлэн боловсруулж батлуулан, хэрэгжиж эхэлсэн байна.	Хөтөлбөрийн биелэлт 30%	20.0	Орон нутгийн төсөв	ХБТХОХ ЭШУТП ХХААГ	Аймгийн ИТХ-ын 2023 оны 14/02 дугаар тогтоолоор "Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хөтөлбөр" батлуулан 3 зорилтын хүрээнд 10 арга хэмжээ төлөвлөн, дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Өрхийн үйлдвэр эрхлэгчдийг чадавхжуулах сургалт зохион байгуулж, 52 өрхийн үйлдвэрлэл эрхлэгчийг хамруулснаар өрхийн бизнес загвараа хэрхэн гаргах талаар мэдлэг, мэдээлэлтэй болж зөвлөх үйлчилгээнд хамрагдсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн өрхийн болон бичил үйлдвэрлэл эрхлэгч нийт 880 иргэнд хүлэмж, оёдол, гутлын тоног төхөөрөмж, сүү боловсруулах болон махны төхөөрөмж зэрэг шаардлагатай тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. "Бялхам Ивээл" ХХК-тай хамтран дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, хүлэмжийн аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэдээлээр хангах замаар хүний нөөцийн чадавхыг сайжруулах зорилгоор "Хөдөө аж ахуй технологи" сэдэвт сургалтыг зохион байгуулж, хүлэмжийн аж ахуй эрхлэгч 45 иргэнийг хамруулснаар хөрсний менежментийн болон суулгац, эрт тариалах, усалгааны, халдварт өвчнөөс сэргийлэх, улаан лооль, өргөст хэмх тариалах технологийн мэдлэгтэй болсон. Мөн Сэлэнгэ аймгийн Баруунхараа суманд хүлэмжийн аж ахуйн туршлага судлах аялалд өрхийн тариаланчдыг хамруулсан. "Эрдэнэтэд үйлдвэрлэв-2023" үзэсгэлэн худалдааг зохион	100

									байгуулж, 45 өрхийн үйлдвэрлэл эрхлэгч оролцлоо. Хөтөлбөрийн хэрэгжилт 35 хувьтай байна.	
68.	ТЖҮЧ 3.4.5	Аймаг, орон нутаг, бүсийн түвшинд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чиглэлээр эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулиудтай хамтран ажиллах	Эрдэм шинжилгээний байгууллагаих, дээд сургуулиудтай хамтран ажиллах	Санамж бичиг байгуулан ерөнхий ажлын төлөвлөгөө боловсруулан баталж, ажил эхэлсэн.	Судалгааны ажил 3, туршилт, зүгшрүүлэлт 3, шаардлагатай боловсон хүчинг бэлтгэсэн байна.	-	-	ХБТХОХ ЭШУТП	БШУЯ, ШУ-ны Академтай хамтарч "Судлаач энтрепренер" хөтөлбөрийг боловсруулж орон нутгаас 13 бизнес эрхлэгчийг бүртгэн шинжлэх ухааны судалгаатай холбоотой ажил хийсэн. "Хүнсний ногооны үр тариалалт"-ын гарааны компанийг инновац технологийн арга хэмжээнд оролцуулж Грант шагнал авсан. Мөн 12 байгууллага хамтран технологи дамжуулах ажлыг эхлүүлээд байна. Шинжлэх ухаан, технологийн сантай хамтарч Завхан, Ховд, Говь-Алтай, Өвөрхангай гэсэн 4 аймагт "Инновацыг нутагшуулъя" аяны хүрээнд "СТАРТАП МЕНТОРШИП" арга хэмжээ зохион байгуулж гарааны бизнесийн тухай сургалт, инновац, энтрепренер сэтгэлгээ, гарааны бизнес, шинэ санаа хөгжүүлэлт, оюуны өмч, маркетинг сэдвүүдээр сургалт хийсэн. ЭШУТП нь Австри улсад бордоо үйлдвэрлэлийн чиглэлээр судалгаа хийдэг эрдэмтэнтэй хамтран Жаргалант суманд ургамлын болон хоол хүнсний хог хаягдал, шарилж ашиглан бордоо үйлдвэрлэх гарааны бизнес эхлүүлэхээр ажиллаж байна.	90
69.	ТЖҮЧ 3.4.6	“Хоршоо хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр III”-ыг орон нутагт хэрэгжүүлэх	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 80%	Хөтөлбөрийн хэрэгжилт 100%	10.0 533.0	Гадаадын төсөл, хөтөлбөр, ХХСан	ХХААГ	Аймгийн хэмжээнд мал аж ахуй, газар тариалан, худалдаа, нийтийн тээвэр, оёдлын чиглэлээр 62 хоршоо бүртгэлтэй байдгаас тогтвортой үйл ажиллагаа явуулдаг 13 хоршоо байна. 2022 онд мал аж ахуйн чиглэлийн "Арга билиг арвин сүрэг" хоршоо, 2023 онд мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн "Арвин сүргийн өгөөж" хоршоо шинээр байгуулагдсан. Арга билиг арвин сүрэг хоршоо нь Оюут багт өөрийн нэрийн дэлгүүрээ нээн 10 гаруй нэр төрлийн цагаан идээгээр иргэдэд үйлчилж байна. Тус хоршооны технологичийг ӨМӨЗО-д туршлага судлахад дэмжлэг үзүүлсэн. Энэ хоршоо нь Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн PROGRES төслөөс 10.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн, "Үйлдвэрлэгч баг" төслийн хүрээнд сүү сүүн бүтээгдэхүүний тоног төхөөрөмжийн дэмжлэг авсан. Ингэснээр үйл ажиллагаагаа өргөжүүлж 9 ажлын байр шинээр нэмэгдсэн. Мөн тус төслөөс газар тариалангийн чиглэлийн Шонхорын хүч, Агро Элит хоршоо нь тус бүр 10.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг авсан. Тайлант онд Хоршоо хөгжүүлэх сангаас 27 иргэн, аж ахуйн нэгжид 533.0 сая төгрөгийн зээл олгосон. Мөн улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн Олон талт түншлэлийн хүрээнд гутал засварын багц тоног төхөөрөмжийг "Талын шанд трейд хоршоо"-д олгосноор үйл ажиллагаагаа өргөжүүлсэн.	90
70.	ТЖҮЧ 3.4.6. ЗДҮАХ 7.2.3.	Орон нутгийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг дэмжих, хөнгөлөлттэй зээл, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрт хамруулах, түүний хэрэгжилт үр дүнд хяналт, үнэлгээ хийх	Гадаад, дотоодын төсөл хөтөлбөрт хамруулах, хяналт тавих	Борлуулалтын цэгийн тоо 2, үйлдвэрлэгчийн тоо 50 байна. 2019-2020 онд зээл авсан 14 төсөлд хяналт хийсэн.	Үр ашиг, хүртээмжийг сайжруулах, үйлдвэрлэгчийн тоо 70, ЖДҮ-ийн сангаас зээл авсан бүх төслийг 100% хамруулах	14200.0 894.0 280.0 1900.0 3200.0	ХХАА-г дэмжих сан ЖДҮ сан ХЭДС Бест хөтөлбөр Жайка төсөл	ХБТХОХ ЭШУТП ХХААГ, ХХҮГ,	Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор олгож буй 5-6 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлд аймгийн хэмжээнд 22 аж ахуйн нэгж, 19 иргэн хамрагдаж 14.2 тэрбум төгрөгийн зээл авсан. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлд 5 аж ахуйн нэгж хамрагдаж 894.0 сая төгрөгийн зээл авсан. Орхон аймагт сүлжмэл үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 40 гаруй иргэн аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаагаас үйл ажиллагаа явуулж байгаа 28 иргэн, аж ахуйн нэгж байгаа бөгөөд 20 гаруй нэр төрлийн сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаагаас Орхон хаан сүлжмэл, Түмэн сүлжээ, Эвсэг сүлжмэл, иргэн Д.Батцэцэг нар экспортод чиглэсэн сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Орон нутагт үйлдвэрлэж байгаа, экспортод гаргах боломжтой бараа бүтээгдэхүүний судалгааг гаргаж Жижиг	100

						100.0	ХХСан		дунд үйлдвэрийн газарт хүргүүлсэн. Судалгаанд Орхон хаан сүлжмэл ХХК, Ширмэг цүнх ХХК, Мөнх баян Алт ХХК, Аранжин ХХК, Ган сан ХХК зэрэг 8 аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн хамрагдсан. ХХҮГ-ын хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд 28 иргэн тэнцэж 280.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан. АНУ-ын Олон Улсын Хөгжлийн агентлагийн санхүүжилттэй хэрэгжиж байгаа "Бест" хөтөлбөрөөс явуулж буй сургалтад хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлснээр хүнсний үйлдвэрлэл, хувцас үйлдвэрлэл, газар тариалан, бусад чиглэлээр 37 иргэн, аж ахуйн нэгж 1.9 тэрбум төгрөгийн бизнесийн зээлийг авч 76 ажлын байр хадгалагдаж, 6 ажлын байр шинээр нэмэгдсэн. Жайка төслөөс нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 4 төсөлд 3.2 тэрбум төгрөгийн зээл олгогдсон. Хоршоо хөгжүүлэх сангаас нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 3 иргэн, 2 аж ахуйн нэгж 100.0 сая төгрөгийн зээл авсан.	
71.	ТЖҮЦ 3.4.7 ЗДҮАХ 7.2.3	Бизнес хөгжлийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх, сайжруулах төслийн бичиг баримт боловсруулах, хэрэгжүүлэх	Төслүүдийг дэмжин хөгжүүлэх, тоог нэмэгдүүлэх	10 төрлийн үйлчилгээ үзүүлж байна.	Үйлчилгээний төрлийг 4-өөр нэмэгдүүлнэ.	50.0	Улсын төсөв	ХБТХОХ ЭШУТП	ЭШУТП-ын Бизнес хөгжлийн төвийн ажилтан орон нутгийн өрхийн болон бичил бизнес эрхлэгчдэд зөвлөх бизнес ширээг тогтмол ажиллуулж байна. Таримал мөөгний кластер үүсгэн үйлдвэрлэл, хоршоо, маркетинг, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн баг бий болгож 30 иргэнийг хамруулсан. Мөн Германы хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран 6 бизнес эрхлэгчид тогтмол зөвлөх үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Иргэн Зулчимэгийн амттаны үйлдвэрлэл, Ган компасс ХХК-ийн экспортын тоглоом үйлдвэрлэл, Мөөг кластер ХХК-ийн чипс үйлдвэрлэл, тариалалтын ухаалаг чингэлэг үйлдвэрлэл, эмийн мөөг тариалалт, Бидэрт манхан ХХК-ийн хуванцар эдлэл үйлдвэрлэл, БМОМ ХХК-ийн биомасс боловсруулах зэрэг төслүүдийг дэмжин хөгжүүлж байна.	70
72.	ЗДҮАХ 2.2.9	Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэх	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах	15 үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлж ажилласан.	Хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА-н чиглэлээр 15 үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан байна.	20.0	Улсын төсөв	НБХ, ХХҮГ	“Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу сургалт, уулзалт, зөвлөгөөн, хурал, холбогдох байгууллагуудаас санал авах дээд шатны байгууллагуудад хүргүүлэх, видео бичлэг хийх зэрэг 18 ажлыг зохион байгуулсан. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн аймгийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу сарын аян, сургалт, улсын үзлэг зохион байгуулах, уулзалт хэлэлцүүлэг хийх, туршлага түгээн дэлгэрүүлэх зэрэг 9 ажлыг 100 хувь хийж гүйцэтгэсэн. Жилийн ажлын төлөвлөгөөний дагуу 4 дүгээр сард "Эрүүл аюулгүй ажил-бидний суурь эрх" уриатай сарын аяныг Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн холбоо, Мэргэшсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтнүүдийн холбоо ТББ, аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран зохион байгуулж 3.0 сая төгрөг зарцуулсан. Аж ахуй нэг байгууллагуудад "Эрүүл аюулгүй ажил-Бидний суурь эрх" уриан дор "Ажил олгогчийн эрх, үүрэг, Үйлдвэрлэлийн осол гарах шалтгаан нөхцөл, стандартууд болон оффист суудаг ажилтнууд, дэлгэцийн донтолтоос үүдэж эрүүл мэндэд ямар хор уршиг үзүүлж байгаа талаар 3 төрлийн зөөврийн самбарыг 21 байгууллагын 3491 ажилчид болон иргэд уншиж, танилцаж,	100

									мэдлэг мэдээлэл өгсөн. ХАБЭМТөвийн баг бүрэлдэхүүн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн чиглэлээр мэдээлэл өгөх, сургалт хэлэлцүүлэгт нийт 50 хүн оролцлоо. Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа зохион байгуулах ажлын хүрээнд 14 ААНБ-ын 380 албан журмаар даатгуулагчдад мэдээлэл хүргэсэн. ХАБЭА-н талаарх суурь мэдлэг, хууль эрх зүйн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан. Аймгийн ХАБЭА-н зөвлөл нь ажлаараа сүүлийн 2 жилд дараалан улсад тэргүүлсэн амжилтыг гаргасан.	
Зорилт 3.5. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын зөв хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, спортоор хичээллэх ээлтэй орчныг бүрдүүлнэ.										
73.	ТЖҮЧ 3.5.4 ЗДҮА 1.6	Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчдын тоог нэмэгдүүлж, тэмцээн уралдаанд амжилттай оролцуулах.	Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчдын тоог нэмэгдүүлэх	Спортын 16 төрлөөр 168 тамирчин хичээллэж байна.	Тамирчдын тоог 14 төрлөөр 182-т хүргэнэ.	75.0 32.9 10.0	Орон нутгийн төсөв Улсын төсөв Хувийн хэвшил	БТСГ	Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн спортыг төрлүүдийг жил бүр 1-ээр, тамирчдын тоог 14-өөр нэмэгдүүлж 2022 онд 15 төрөлд 168 тамирчин хичээллэж байсан. Тайлант онд сагсан бөмбөг 3х3, 5х5 төрөлд 28 хүүхэд, байт харваа-5, гимнастик-8, цана-16, хөл бөмбөг-20, бадминтон-5, бокс-10, буудлага-8, таеквондо-10, ширээний теннис-4, самбо, жудо-18, чөлөөт бөх-12, волейбол-20, шатар-2, хөнгөн атлетик-16 тамирчин тус тус хичээллэж нийт спортын 16 төрөлд 182 тамирчин бэлтгэл сургуулилалтаа тогтмол хийж байна. Шигшээ багийн тамирчдын ур чадварыг сайжруулах зорилгоор өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 17 төрлөөр зохион байгуулж, нийт 2764 сурагчид хамрагдсан. Өсвөрийн улс, бүс, аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах, оролцоход нийт 135.8 сая төгрөг зарцуулагдсан. Үүнээс: Орон нутгийн төсвөөс 92.9 сая төгрөг, улсын төсвөөс 32.9 сая төгрөг, ивээн тэтгэгч байгууллагаас 10.0 сая төгрөгийн зардлыг тус тус санхүүжүүлсэн. Тайлант онд өсвөрийн шигшээ багийн тамирчид "Монголын хүүхдийн спортын VII их наадам", улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээнд нийт 142 медаль хүртсэнээс алт-43, мөнгө-43, хүрэл-56 авсан амжилтыг үзүүлсэн. 2023 онд өвлийн спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллаж буй гадаад улсын буцалтгүй тусламжаар гүйлтийн цана 20 ширхгийг хүлээн авч, цанын өсвөрийн шигшээ багийг хэрэглэл материалаар хангасан.	100
74.	ТЖҮЧ 3.5.3 ЗДҮА 1.6	Улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнийг орон нутагт зохион байгуулах	Улс, бүсийн чанартай уралдаан тэмцээн зохион байгуулах	Зохион байгуулсан тэмцээний тоо 4	5 удаа зохион байгуулна.	152.4 275.0	Орон нутгийн төсөв Улсын төсөв	БТСГ	Орон нутагтаа улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнийг зохион байгуулах ажлын хүрээнд 2021 онд улс аварга шалгаруулах тэмцээн 2 удаа, 2022 онд улсын аварга шалгаруулах тэмцээн 5 удаа, бүсийн аварга шалгаруулах тэмцээн 4 удаа тус тус зохион байгуулж 3142 тамирчин хамруулж, орон нутгийн төсвөөс 160 сая төгрөг зарцуулсан. Тайлант онд улсын аварга шалгаруулах тэмцээн 7 удаа, бүсийн аварга шалгаруулах тэмцээн 2 удаа тус тус зохион байгуулж ажилласан нь өмнөх оноос улсын аварга шалгаруулах тэмцээнийг 3-аар, оролцсон тамирчдын тоог 498-аар нэмэгдүүлж 3640 тамирчдыг хамруулан зохион байгуулсан. Улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулахад улсын төсвөөс 275.0, орон нутгийн төсвөөс 152.4 сая төгрөг нийт 427.4 сая төгрөгийг зарцуулж, Орхон аймагт 1300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, худалдан авалт хийгдэж худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлсэн. Улсын аварга шалгаруулах тэмцээнээс дурдвал:	100

									- Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадам, Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадмыг тус тус аймагтаа амжилттай зохион байгуулсан. Тус наадмуудад 13 аймаг, 7 дүүргийн нийт 760 тамирчид 526 багц медалийн төлөө хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн. -Байт харвааны заалны улсын аварга шалгаруулах 15 дахь удаагийн тэмцээнд 24 аймаг, дүүрэг, клуб оролцсон. Тэмцээнд 2 төрөлд нийт 307 тамирчин 57 багц медалийн төлөө өрсөлдсөн. -2023 онд хэрэглэлтэй Пауэрлифтингийн 17 дахь удаагийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 30 аймаг, дүүрэг, клуб оролцсон. Тэмцээнд өсвөр, насанд хүрэгчдийн ангилалд нийт 230 тамирчин 148 багц медалийн төлөө өрсөлдсөн. -Авто спортын "SPRINT RALLY" улсын аварга шалгаруулах тэмцээнд 4 ангилалд 45 тамирчин оролцлоо. -Монгол Улсын Усанд сэлэлтийн 32 дахь удаагийн өсвөр, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 27 клубийн 378 тамирчид, -Хэт бартаат замын улсын аварга шалгаруулах тэмцээнд 4 төрөлд 33 багийн 71 тамирчин тус тус хамрагдсан.	
75.	ТЖҮЧ 3.5.3 ЗДҮА 1.6	Үндэсний болон багийн спортын төрлүүдээр иргэдийн спортын их наадмыг шат дараатай зохион байгуулах	Спортын их наадмыг зохион байгуулах	Багийн иргэдийн дунд үндэсний бөх, сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис, ширээний шагай, олс таталт гэсэн 6 төрлөөр зохион байгуулсан.	Спортын 8 төрлөөр зохион байгуулах	20.0	Орон нутгийн төсөв	БТСГ	Үндэсний болон багийн спортын төрлүүдээр "Иргэдийн спортын наадам"-ыг 2021 онд спортын 3 төрлөөр (сагсан бөмбөг, волейбол, олс таталт) зохион байгуулж, 900 иргэн хамруулсан бол 2022 онд спортын 6 төрлөөр зохион байгуулж 897 иргэнийг хамруулж, 12.8 сая төгрөг зарцуулсан. 2023 онд Баян-Өндөр, Жаргалант сумдын ЗДТГ-тай хамтран "Иргэдийн спортын наадам"-ыг үндэсний болон багийн спортын 8 төрлөөр зохион байгуулж сагсан бөмбөгийн төрөлд 308 иргэн, волейболын төрөлд 384 иргэн, олс таталтын төрөлд 184 иргэн, ширээний теннисний төрөлд 46 иргэн, үндэсний бөхийн төрөлд 69 иргэн, буудлагын төрөлд 92 иргэн, дартсын төрөлд 46 иргэн, Мас-рестлинг /Модон барилдаан/-ны төрөлд 32 иргэн оролцож нийт 1143 иргэн хамрагдсан. Тэмцээний үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 20.0 сая төгрөг зарцуулсан.	100
76.	ТЖҮЧ 3.5.7 ЗДҮАХ 1.6	Спортын хэрэгслийн /ердийн болон цахилгаан дугуй, цана, тэшүүр, дугуйт цана, дугуйт тэшүүр/ түрээсийн үйлчилгээг нэвтрүүлэх санал санаачилгыг дэмжих	Түрээсийн үйлчилгээг нэвтрүүлэх, тоог нэмэгдүүлэх	Түрээсийн үйлчилгээ үзүүлж буй ААНБ, иргэдийн тоо жил бүр нэмэгдсэн байна.	Түрээсийн үйлчилгээ үзүүлж буй ААНБ, иргэдийн тоо нэмэгдсэн байна.	-	-	БТСГ	Тайлант онд 6 байршилд 6 иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, уулын цана, чарга, тэшүүр, цахилгаан дугуй /скүүтер/, ердийн болон гэр бүлийн дугуйн төлбөрт үйлчилгээг 7200 гаруй хүүхэд залууст хүргэж ажиллалаа.Үүнд: -Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Сархиа цанын баазад чарга, уулын цана, тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд 2000 иргэн, - 19-р сургууль /орос сургууль/ дахь мөсөн талбайн тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд 500 иргэн; -А.Амарын талбай, "Эрдэнэт спорт амралтын хүрээлэн", "Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн"-д ердийн болон гэр бүлийн дугуйн түрээсийн үйлчилгээнд нийт 3200 иргэн; -Хот доторх авто замд "Erdenet jet" ХХК-аас 230 ширхэг цахилгаан дугуй/скүүтер/-аар түрээсийн үйлчилгээг нэвтрүүлж өдөрт дунджаар 40-50 иргэнд, сард 1200-1500 иргэнд тус тус үйлчилгээ үзүүлсэн.	100

77.	ТЖҮЧ 3.5.2 ЗДҮАХ 1.8	Хийн болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөнийг сурталчилж “Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшэе” аяныг аймгийн иргэд болон аж ахуйн нэгж байгууллагуудын дунд өрнүүлэх	Хамруулсан иргэдийн тоог нэмэгдүүлнэ.	7500 иргэнийг хамруулсан /Давхардсан тоогоор 46846 иргэдийг хамруулсан /.	Хамруулсан иргэдийн тоо 8000	10.0	Улсын төсөв	БТСГ	"Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аянд 2021 онд 15954, 2022 онд 44856 иргэн тус тус хамрагдсан. 2023 онд аяны хүрээнд "Нэг анги-Нэг өглөө" өглөөний дасгалын үйл ажиллагааг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд ерөнхий боловсролын 11 сургуулийн 12632 сурагч, 2597 эцэг эх давхардсан тоогоор нийт 15229 иргэнийг дасгал хөдөлгөөнд хамруулсан байна. Мөн БТСГ-ын нээлттэй хаалганы өдөрлөгийг 2 удаа зохион байгуулж 8 сургуулийн 506 сурагч, спортын холбоодын багш, дасгалжуулагчид, өсвөрийн шигшээ багийн тамирчид зэрэг 254 иргэнийг хамруулсан. Аяны хүрээнд төрийн албан хаагчдын дунд ажлын байрны дасгалын уралдааныг зохион байгуулж 750 гаруй албан хаагчид хамрагдсан. Ингэснээр иргэдийг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлж, дасгал хөдөлгөөнөөр дамжуулан эрүүл амьдралын дадлыг олгох нөхцөл бүрдсэн.	100
78.	ТЖҮЧ 3.5.6 ЗДҮАХ 1.9	Өвлийн спортын дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хэрэгжилтийн 70%	Хэрэгжилтийг 100%-д хүргэнэ.	40.0	Орон нутгийн төсөв	БТСГ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Өвлийн спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөр"-ийн биелэлт 2021 онд 76 хувь, 2022 онд 86.5 хувь, 2023 онд 92.5 хувийн биелэлттэй хэрэгжсэн байна. Хөтөлбөрийн хүрээнд спортын 7 төрлөөр 10 удаагийн нээлттэй тэмцээнийг зохион байгуулж 560 гаруй иргэнийг хамруулсан. Тамирчид тив, улс, бүсийн аварга шалгаруулах 32 тэмцээнд оролцож 280 медаль авсан амжилтыг үзүүлсэн. Мөн биатлоны Монгол улсын шигшээ багт 5, хоккейн улсын шигшээ багт 14 тамирчин шалгаран тус тус бэлтгэл сургуулилтаа хийж байна. Өвлийн спортын төрлүүдийг хөгжүүлэхэд орон нутгийн төсвийн 220.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цана 17 ширхэг, тэшүүр 14 ширхэг, цас буудагч буу, цасны мотоцикль, усны шланк зэргийг авсан. Швейцарын холбооны улс, Бүгд найрамдах Франц улсын өвлийн спортын үндэсний төвүүдтэй хамтран ажиллаж 200ш хоккейн тэшүүр, 13 цана хандиваар авч цана, тэшүүрийн тамирчдыг бэлтгэл сургуулилтаа хийхэд хэрэглэл материалаар ханган ажилласан. Хөтөлбөрийн хүрээнд шинээр 2 мөсөн талбай байгуулж өвлийн спортын мөсний сур харваа, мөсөн шагай, тэшүүр, шорт трекийн спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлснээр хичээллэгсдийн тоо 600-аар, тамирчдын тоо 342-оор тус тус нэмэгдэж нийт 2532 иргэн хичээллэдэг болсон. 2023 онд орон нутагтаа анх удаа Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадам, Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадмыг нэгэн зэрэг өндөр түвшинд зохион байгуулж 12 аймаг, 7 дүүргээс 700 гаруй дасгалжуулагч, тамирчид, зочид төлөөлөгчид хүрэлцэн ирж зочид буудал, хоол үйлдвэрлэл, бэлэг дурсгал, хэвлэл мэдээлэл, бусад үйлчилгээний байгууллагуудаас Орхон аймагт нийт 1 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалт, худалдан авалт хийгдсэн байна. Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадамд Орхон аймаг багийн дүнгээр 2-р байрт шалгарсан.	92.5
79.	ТЖҮЧ 3.5.6	Орон сууцны болон гэр хороллын дундах амралт чөлөөт цагийн талбайн ашиглалт, хүртээмжийг нэмэгдүүлэх	Чөлөөт цагийн талбайн ашиглалт, хүртээмжийг нэмэгдүүлэх	Амралт, чөлөөт цагийн 114 талбай ашиглагдаж байна.	Жил бүр 1 заал нэмэгдсэн байна.	741.4	Орон нутгийн төсөв	БТСГ	Аймгийн хэмжээнд орон сууцны дундах байршилд 6, гэр хороллын дундах байршилд 2 амралт, чөлөөт цагийн талбай шинээр байгуулж нийт 122 талбай ашиглагдаж байна. Тайлант онд амралт, чөлөөт цагийн 5 талбайд идэвхтэй дасгал хөдөлгөөнд 700 иргэн, спортын 4 удаагийн тэмцээнд 760 иргэнийг тус тус хамруулсан. Мөн төрийн өмчит байгууллагууд болон	100

									хувийн хэвшил, ерөнхий боловсролын сургуулиудад 35 спорт заал хэвийн үйл ажиллагаа явуулж байна.	
Зорилт 3.6. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэн хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.										
80.	ТЖҮЧ 3.6.1 ЗДҮАХ 5.1.1	Тухай жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан үе шаттай зохион байгуулах, бүртгэлийн системд хамруулах	Төлөвлөгөөг хэрэгжүүлж, бүртгэлд хамрагдалтыг нэмэгдүүлэх	Төлөвлөгөө боловсруулагдсан. Бүртгэлд хамруулсан нэгж талбар 21800	Төлөвлөгөө ний хэрэгжилт 15 хувь, Бүртгэлд хамруулах нэгж 22800	-	-	ГХБХБГ	Баян-Өндөр сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг 9 арга хэмжээний хүрээнд боловсруулан сумын ИТХ-ын 02 дугаар тогтоолоор, тус төлөвлөгөөнд нэмэлт тодотголыг сумын ИТХ-ын 2023 оны 13/06 дугаар тогтоолоор батлуулж, нийт 12 арга хэмжээний хүрээнд 333.33 га газар төлөвлөснөөс 311.07 га газрыг эзэмшүүлж төлөвлөгөө 90.01 хувьтай, Жаргалант сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг 11 арга хэмжээний хүрээнд боловсруулан сумын ИТХ-ын 02 дугаар тогтоолоор батлуулж 442.7 га талбайг төлөвлөснөөс 371.9 га газрыг эзэмшүүлж төлөвлөгөөний хэрэгжилт 83.9 хувьтай байна. Тус сумын Дулаан-Уул багт байрлах Цагаан хустад зуслангийн зориулалтаар төлөвлөсөн газар нь "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ашиглалтын лицензийн талбайтай давхацсан тул хэрэгжээгүй байна. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 13/06 дугаар тогтоолоор батлагдсан "Газрын харилцааны талаар 2023 онд баримтлах үйл ажиллагааны чиглэл"-д Баян-Өндөр сумын 4 байршилд 0.7 га, Баян-Өндөр сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд 4 байршилд 5.7 га, Жаргалант сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу 7 байршилд 56.8 га газарт ашиглах, эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг зохион байгуулахаар төлөвлөсөн. Аймгийн хэмжээнд газрын биржийн цахим системийг ашиглан 15 удаагийн дуудлага худалдааг зохион байгуулж нийт 35 оролцогч оролцсон байна. Дуудлага худалдаагаар 9 байршилд 15.3 га газрыг худалдаж, 5 байршилд оролцогч бүртгүүлээгүй, 1 байршилд нэг оролцогч бүртгэгдсэн байна. Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны зар мэдээллийг Газрын биржийн цахим систем болох www.mle.mn, аймгийн Засаг даргын Тамгын газрын /www.erdenet.mn/ болон, /www.erdenetgazar.mn/ цахим хуудас facebook www.facebook.com/erdenetgazar хуудсаар иргэд, олон нийтэд ил тод сурталчилсан. Аймгийн хэмжээнд дуудлага худалдааны орлогоос нийт 582,380,000 /таван зуун наян хоёр сая гурван зуун наян мянган/ төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.	100
81.	ТЖҮЧ 3.6.3 ЗДҮАХ 5.1.5	Газрын биржийн үнийн судалгаа, газар өмчлөх, эзэмших, ашиглах иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг газрын үнэлгээ, төлбөрийн цахим системд хамруулах	Нэгж талбарын тоог нэмэгдүүлсэн байна.	Бүртгэсэн нэгж талбарын тоо 3500	Бүртгэсэн нэгж талбарын тоо 4000	-	-	ГХБХБГ	2023 онд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхээ шилжүүлсэн 721 нэгж талбарын үнийн мэдээг Газрын биржийн www.mle.mn цахим программд бүртгэгдсэн байна. Өссөн дүнгээр 4607 нэгж талбарын үнийн мэдээ бүртгэгдсэн.	100
82.	ТЖҮЧ 3.6.1 ЗДҮАХ 3.6.3	Суурьшлын бүсэд газрын төлөв байдал, чанарын хяналт баталгааны дүгнэлт гаргах ажлыг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэн хүлээн авах	Мэргэжлийн байгууллагаар хийлгэж хүлээн авсан байна.	5-10 га газрыг хамруулсан.	Жил бүр 5-10 га газрыг хамруулна.	-	-	ГХБХБГ	Орхон аймгийн Жаргалант сумын 12956.50 га газарт хот, тосгон, бусад суурин газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг мэргэжлийн байгууллага "Гео батаник" ХХК-аар гүйцэтгүүлэг хүлээн авсан. 2023 онд Орхон аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөл бүхий 15 аж ахуйн нэгжээс газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны дүгнэлтийг цахим хэлбэрээр хүлээн авч иргэн, аж ахуйн 700 нэгж талбар буюу 74 га газрын захиалгат чанарын хянан баталгааны тайланг баталгаажуулсан.	100

83.	ТЖҮЧ 3.6.4 ЗДҮАХ 5.1.4	Геодезийн сүлжээний цэгүүдэд үзлэг тооллого хийж, гэмтсэн болон устсан цэгүүдийн судалгааг гаргаж, нөхөн сэргээх, шинээр байгуулсан цэг тэмдэгтийг хүлээн авах	Тооллого хийж, гэмтсэн болон устсан цэгүүдийн судалгааг гаргаж, нөхөн сэргээж, тоог нэмэгдүүлсэн байна.	116 цэг	Жил бүр 2 цэг нэмэгдүүлнэ	-	-	ГХБХБГ	2023 онд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгөөр "Дроникс" ХХК шинээр 16 геодезийн цэг шинээр нэмж байгуулсан ажлыг хүлээн авч өгөгдлийг геопорталд бүртгэх ажил хийгдсэн, мөн геодезийн сүлжээний цэгүүдэд үзлэг тооллогын ажлыг зохион байгуулж Зэст багийн нутаг дэвсгэрт ПП7209 дугаартай 1, Цагаанчулуут багийн нутаг дэвсгэрт-РП001 дугаартай 1 цэг бүтээн байгуулалтын улмаас устсан байх тул нөхөн сэргээх талаар тухайн цэг тэмдэгтийг устгасан аж ахуйн нэгжүүдэд мэдэгдэл хүргүүлээд байна.	100
ДӨРӨВ.ЭДИЙН ЗАСАГ **Зорилт 4.1.** Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.										
84.	ТЖҮЧ 4.1 ЗДҮАХ 2.2.4	Хувийн хэвшлийн харилцаа хандлага, үйлчилгээг сайжруулах ажлыг зохион байгуулах	Ажил зохион байгуулсан байна.	-	Чиг хандлага, үйлчилгээнд ахиц гарсан байна.	10.0	Орон нутгийн төсөв	ХБТХОХ	Аймгийн ЗДТГ-аас Соёл урлагийн газартай хамтран зохион байгуулж буй "Соёлыг түгээе" сарын аяны хүрээнд "Орхон молл" худалдааны төв, Төгөл их дэлгүүр, ЦАХ маркет, Хангайн бүс худалдааны төв, Худалдааны гудамжны худалдаа, үйлчилгээ эрхлэгчид, түрээслэгч нар болон үйлчилгээний ажилтнуудад "Гэр бүлийн харилцаа", "Замын хөдөлгөөний соёл", "Галын аюулгүй байдал" зэрэг сэдвүүдээр соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулсан. Мөн Эрүүл мэндийн газартай хамтран ажлын байранд очиж худалдагч, түрээслэгч нарыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулан, сэтгэл зүй, хууль зүйн ганцаарчилсан зөвлөгөө өгч ажилласан. "Соёлыг түгээе" сарын аяны хүрээнд "Баян" "Төгөл" худалдааны төвийн ажиллах цагийг туршилтын журмаар уртасгасан.	100
85.	ТЖҮЧ 4.1.2. ЗДҮАХ 5.9	Дэлхийн банкны Эрчим хүч-2 төслийг Орхон аймагт хэрэгжүүлэх	Төслийг хэрэгжүүлэх	0.4кВ-ын ЦДАШ-266.4км 2 тарифт тоолуур-24000ш Дэд станц -9 ш 57%	Төсөл-100%	-	-	“ЭБЦТС” ТӨХК	Ажил гүйцэтгэгчээр "Ричвелл инженеринг" ХХК ажиллаж байна. 0.4кВ-ын ЦДАШ-ын гүйцэтгэл 92.1 хувь, хуучин орон сууцны цахилгаан хангамж 85.9 хувь, гэр хорооллын тоолуржуулалт 62.8 хувь, орон сууцны тоолуржуулалт 80.3 хувь, 6кВ-ын ЦДАШ-ын гүйцэтгэл-39.8 хувийн гүйцэтгэлтэйгээр төлөвлөгөөний дагуу ажил хийгдэж байна. Ажил 86.9 хувьтай хэрэгжиж байна.	90
86.	ТЖҮЧ 4.1.7 ЗДҮАХ 7.2.2	“Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг орон нутагт хэрэгжүүлэх	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх	4 зорилт, 16 үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.	Хөтөлбөрийн хэрэгжилт 100%	10.0	Орон нутгийн төсөв	ЗДТГ ХБТХОХ ХХААГ	"Ахуйн үйлчилгээг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 11 арга хэмжээг тусган хэрэгжилтийг ханган ажилласнаар төлөвлөгөөний хэрэгжилт 60 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг чадавхжуулах, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор "Өөрийгөө хөгжүүлэх нь", "Амжилтын 10000 цагийн төлөвлөгөө" сэдэвт сургалтад 50 гаруй хүн хамрагдаж мэдээлэл авсан. Жаргалант сумын ЗДТГ, мэргэжлийн холбоодтой хамтран "Явуулын ахуйн үйлчилгээ"-г Дулаан-Уул багийн Баруунбулагт зохион байгуулж гутал засвар, цаг засвар, үсчин, маникюр, гар урлалын 5 чиглэлээр 100 гаруй хүнд үйлчилгээ үзүүлэв. Үсчин, гоо засалч, хумс засалч, нүүр будагч мэргэжлээр ажиллаж, сурч хөдөлмөрлөж байгаа иргэдийн мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, салбарын шинэ чиг хандлагыг таниулан сурталчлах, нэвтрүүлэх зорилгоор Үсчин, гоо засалчдын холбоотой хамтран аймгийн Үсчин, гоо засал, хумс урлалын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулж, тэмцээнд 17 төрөлд 109 хүн амжилттай оролцсон. Аймгийн хэмжээнд ахуйн үйлчилгээний салбарт 346 цэгт аж ахуйн нэгж, иргэн үйл ажиллагаа явуулж байгаагийн 4.0 хувь нь нийтийн халуун ус, 23.1 хувь нь үсчин, гоо сайхан 24.6	72

									хувь нь хувцас захиалга, засвар, 1.4 хувь нь гэрэл зураг авах, угаах, 0.9 хувь нь хими цэвэрлэгээ, угаалга, 0.9 хувь нь ахуйн электрон, цахилгаан хэрэгсэл засвар, 6.9 хувь нь гутал захиалга, засвар, 5.5 хувь нь гэр ахуйн модон эдлэл захиалга, засвар, 2.3 хувь нь алт, мөнгө, үнэт эдлэлийн захиалга, засвар, 30.6 хувь нь бусад үйлчилгээний чиглэлээр тус тус үйл ажиллагаа явуулж байна. Хөтөлбөрийн хэрэгжилт 72 хувьтай байна.	
87.	ТЖҮЧ 4.1.8 ЗДҮАХ 7.2.3.	“Эрдэнэтчүүд Эрдэнэтчүүддээ хайртай” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 100%	Хөтөлбөрийн хэрэгжилт 100%	270.0	Орон нутгийн төсөв	ХБТХОХ ХХААГ ЭШУТП	Эрдэнэтчүүд Эрдэнэтчүүддээ хайртай хөтөлбөрийн "Гарааны бизнес-2022" арга хэмжээгээр ажлын байр нэмэгдүүлэх, инновацын болон гарааны бизнесийг дэмжих 270.0 сая төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэй, хүүгүй санхүүжилтийг өрхийн болон бичил бизнес эрхлэгч 34, орон нутгийн брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэх 2, хог хаягдал дахин боловсруулах 2 төсөл дэмжин ажилласан. Мөн Эрдэнэт ШУТП, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран Германы Эдийн засгийн хөгжлийн яамны санхүүжилтээр 8 ангиллаар 27 орон нутгийн бизнес эрхлэгчдэд тус бүр 10.0 сая, нийт 270.0 сая төгрөгийн грант олгосон. Тус 2 төслийн нийт 65 бизнес нь брэнд бүтээгдэхүүн, инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээ, шинэ технологиуд зэрэг төрөл бүрийн гарааны бизнесүүд бий болж байгаа бөгөөд нийт 200 орчим ажлын байр хадгалах, шинээр 50 орчим ажлын байр нэмэгдсэн. "Гарааны бизнес-2023" төслийн хүрээнд хүнсний шинэ төрлийн бүтээгдэхүүн, ногоон сууц үйлдвэрлэлийн ангилалд Эко чихэр, Мөөгний чипс, Блок хаус үйлдвэрлэх 3 төсөл тус бүр 35 сая, нийт 105 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, өрхийн болон бичил үйлдвэрлэлийн ангилалд бетон хийцийн 1, арьсан эдлэлийн 6, хүнсний 11, оёдлын 8, металл хийцийн 2, мэдээллийн технологийн 1, биомасс дахин боловсруулах 2, бусад 2 нийт 33 төсөлд тус бүр 5 сая, нийт 165 сая төгрөгийн хөрөнгө оруулалт олгов.Хөтөлбөрийн хэрэгжилт 75 хувьтай байна.	75
88.	ЗГҮАХ 3.2.7.5. ТЖҮЧ 4.1.5. ЗДҮАХ 7.1.2.	Эрдэнэт үйлдвэрт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр барих	Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр барих	5 хувь	10 хувь	-	-	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	Зэсийн баяжмалыг тасралтгүй ажиллагаатай хос SKS технологиор хайлуулан, боловсруулах металлурги-химийн үйлдвэр байгуулах ТЭЗҮ-ийг БНХАУ-ын ENFI болон NFC консорциумтай хамтран боловсруулж УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар ТЭЗҮ-ийг хэлэлцүүлж дэмжигдсэн. ТЭЗҮ-ээр зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр нь жилд 560 мянган тонн зэсийн баяжмал (хуурай) боловсруулж А зэрэглэлийн катодын зэс 124.1 мянган тонн, алт (99.9%) 72 кг, мөнгө (99.9%) 38.2 кг, элементийн хүхэр 182 мянган тонн, шингэрүүлсэн хүхрийн хүчил 118.2 мянган тонныг үйлдвэрлэх хүчин чадалтай байна. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрээс ялгарах металлургийн хийг боловсруулж, элементийн хүхэр үйлдвэрлэх туршилтын ажлыг БНХАУ-ын ENFI компани гүйцэтгэж байна. Элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтыг БНХАУ-ын Шинжиан Уйгарын өөртөө засах орны Xinjiang Xinxin Mining Industry компанийн харьяа Karatongke Copper Nickel Mine хайлуулах үйлдвэрлэлийн бүсэд явуулж байна. Туршилтын үйлдвэрийн бүх тоног төхөөрөмж, барилга угсралтын ажил 100 хувь дууссан ба "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь туршилтад ашиглах 500 тн шигшсэн нүүрс бэлтгэн БНХАУ-руу тээвэрлэх ажлыг зохион байгуулан үйлдвэрт хүргүүлж, туршилтын ажлыг эхлүүлсэн.	50

89.	ЗГҮАХ 3.2.7.6. ТЖҮЧ 4.1.5 ЗДҮАХ 3.3.1	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах Катодын зэсийн үйлдвэр байгуулах	Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах Катодын зэсийн үйлдвэр байгуулах	6.5 хувь	25 хувь	-	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын захиалгаар "Катодын зэсийн үйлдвэрийн ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах" зөвлөх үйлчилгээний ажлыг "Майнинг Шорт Лонг Терм" ХХК гүйцэтгэж байна. Гүйцэтгэгч компани ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн. 2023 оны 06 дугаар сард зураг төсөл, төсөв гүйцэтгэгч "Майнинг шорт лонг терм" ХХК-тай байгуулсан гэрээний хугацаа дуусан боловч зураг төслийн гүйцэтгэл дутуу ажлуудыг яаралтай дуусгах талаар 2 тал хэлэлцэж гүйцэтгэл хангалтгүй тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авахаар төлөвлөн ажиллаж байна. 2023 оны 05 дугаар сард гүйцэтгэгч компанид 33.8 хувийн санхүүжилтийг олгосон.	30
90.	МУТЖҮЧ 4.2.11 ЗГҮАХ 3.2.7, 3.2.8.	Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" Үйлдвэрлэл, технологийн парк барих	"Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" Үйлдвэрлэл, технологийн парк барих	10 хувь	85 хувь	-	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Үйлдвэрлэл, технологийн парк төслийн нэгж нь Ерөнхий инженерийн харьяалалд үйлдвэрийн газрын бие даасан бүтцийн нэгж болон өөрчлөгдсөн. Үйлдвэрлэл, технологийн парк дэд бүтцийн шугам татах трассын зураг гаргахад аймаг орон нутгийн зүгээс газрын давхцал бусад инженерийн шугам сүлжээний трассын мэдээллийг солилцон хамтран ажиллалаа. Үйлдвэр технологийн паркийн дэд бүтцийн аялуд дараах үед шаттай явагдаж байна. ҮТП-ын цахилгаан хангамжийн 220/110/35 кв, 110/35/10 кв дэд станц, ЦДАШ 9 кмыг барьж байгуулах нарийвчилсан зураг төслийн ажлыг Зураг төслийн хүрээлэн гүйцэтгэж байгаа бөгөөд ҮТП-ын төслийн нэгжийн зүгээс шаардлагатай ажлуудыг батлагдсан төсөвт өртөгт багтаан зохион байгуулах, ажлын гүйцэтгэлд хяналт тавих зэрэг ажлын гүйцэтгэл 20 хувь, төмөр зам барьж байгуулах ажлын явц 48 хувь, авто зам барьж байгуулах ажлын явц 34 хувь, ҮТП-ыг байгуулах газрын хил хязгаарыг тойруулан хашаа барих ажлын явц 85 хувьтай тус тус явагдаж байна.	50
91.	ТЖҮЧ 4.1.7.	Шинжлэх, ухаан, технологи, инновацын үйл ажиллагааг дэмжин ажиллах чиг үүрэг бүхий Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийг Засаг даргын дэргэд байгуулан үйл ажиллагааг дэмжин ажиллах	Салбар зөвлөлийг байгуулан үйл ажиллагааг эхлүүлэх	Зөвлөл байгуулагдаж, ажлын төлөвлөгөө батлагдсан байна.	Судалгаа ажлууд эхэлсэн байна.	-	-	ХБТХОХ ЭШУТП	Аймгийн "Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөл"-ийг Засаг даргын дэргэд байгуулан 2023 оны төлөвлөөг батлуулан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу инновац, технологи дамжуулах чиглэлд салбар яам, бизнес хөгжүүлэгч хувийн хэвшил дээр нэгтгэгдсэн 21 төслийг орон нутгийн иргэд, бизнес эрхлэгчдэд танилцуулж, хамтын ажиллагааг эхлүүлсэн. Мөн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг шинжлэх ухааны үндэстэй чадавхжуулах, судалгааны арга зүйгээр хангах, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, бусад аймаг, орон нутгийн инновацын бүтээгдэхүүнийг Орхон аймагт нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл хэлбэрээр нутагшуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	70
Зорилт 4.2.Хариуцлагатай, тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэлийг дэмжинэ.										
92.	ТЖҮЧ 4.2.1. ЗДҮАХ 7.1.1.	Хувийн хэвшлийн оролцоотой ширмийн үйлдвэрлэлийг ISO14001 стандартын дагуу байгуулах	Ширмийн үйлдвэрлэлийг байгуулах	Ширмийн үйлдвэрлэлийн төсөл эхэлсэн.	Төсөл бүрэн хэрэгжиж дуусна.	-	-	Хөгжлийн банк	2022 оны эхний хагас жилд үндсэн болон туслах түүхий эд (төмрийн хүдэр, кокс, шохойн чулуу, галд тэсвэртэй материал) нийлүүлэгч компаниудын судалгаа хийгдсэн. Түүхий эдийн шинж чанарын судалгааг хийж гүйцэтгэж байна. Зуухны галд тэсвэртэй доторлогоог шинэчлэн доторлосон. Агаар халаах зуухны форсунк, хий дамжуулах шугамд засвар хийсэн. Домен зуухны тоосны байгууламжийн уутан фильтрүүдийг шинээр сольж, засвар гагнуур хийсэн. Зуухны хаалтуудад тосолгоо үйлчилгээ хийсэн. Зуухны фурмын нөөц бэлдэх ажил хийж шинээр 20 ш	30

									фурм хийж нөөцөд бэлдсэн. Түүхий эд ачаалах автомат систем зураг төсөл хийж, угсрах бэлтгэл ажил хийгдэж байна. 2-р ээлжийн 70м.куб Домен зуухны бүтээн байгуулалт 70м.куб-ийн Домен зуухны агаар халаах зуух, материал ачаалах системийн угсралт, гагнуурын ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Хөгжлийн банкны зээлтэй холбоотой 2022 оны 6 дугаар сараас хойш үйл ажиллагаа явуулаагүй.АТГ-аас шалгаж үйлдвэрийг хааж битүүмжилсэн.	
93.	ТЖҮЦ 3.4.7 ЗДҮАХ 7.2.3	Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшилтэй хамтарч орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдээ дэмжиж, дотоодын зах зээлээ хамгаалах	Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдээ дэмжсэн байна.	-	Зохион байгуулалт ын үйл ажиллагаа явагдсан байна.	-	-	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ ТББ-ууд	"Орхон аймагт байгуулагдах Үйлдвэрлэл технологийн парк, олон улсын туршлага, хөрөнгө оруулалт, хамтран ажиллах боломж" Орхон аймгийн бизнес эрхлэгчид аж үйлдвэрийн парк-д хэрхэн оролцох талаар танилцуулга уулзалт Уурхайчин урлаг соёлын цогцолборт 2023 оны 03 дугаар сарын 29-нд болсон. Танилцуулгад Солонгос улсаас мэргэжилтнүүд оролцож мэдээлэл хийсэн. Мөн Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Үйлдвэр технологийн паркийн танилцуулгыг 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Орхон аймаг, "Ачит-Ихт" ХХК "Эрдмин" ХХК -ийн 2023 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөг баталж, гарын үсэг зурлаа. 2023 онд тус бүр хамтын ажиллагааны хүрээнд 9-н арга хэмжээг тусгаж, хамтран ажиллахаар болсон ба Ачит-Ихт ХХК-тай 1329.8 сая, Эрдмин ХХК-тай 1078.0 сая төгрөгийн хамтран ажиллах төлөвлөгөөг баталсан. Хамтын ажиллагааны төлөвлөгөөнд орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор орон нутгаас 1.0 тэрбум төгрөгөөс доошгүй худалдан авалтыг хийх, иргэдэд мэдээлэх гэсэн заалтыг оруулж өгсөн. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-тай 3.0 тэрбум төгрөгийн 14 арга хэмжээг тусган 2023 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөг баталсан. 2023 онд ЭШУТП-ын Технологи дамжуулах төв нь дундын оффисын чиглэлээр үйл ажиллагаа явуулж, 40 гаруй аж ахуйн нэгж, 200 иргэнд зөвлөх үйлчилгээ үзүүлж байна. Хүнсний ногооны үр үйлдвэрлэлийн чиглэлээр 1 аж ахуйн нэгжид технологи дамжуулж үйлдвэрлэлийг эхлүүлсэн. Мөн "БМОМ" ХХК, "Мөөг кластер" ХХК-уудад технологийн хөгжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, халтиргаанаас сэргийлэх материал, сахар үйлдвэрлэл, дулааны станцын хаягдал үнс дахин боловсруулах чиглэлээр судалгааны ажил хийж байна.	100
Зорилт 4.3. Эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан, олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлнэ.										
94.	ТЖҮЧ 4.3.1 ЗДҮАХ 4.2, 4.3	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн ур чадварыг дээшлүүлэх, ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулах, улс бүсийн арга хэмжээнд дэмжин оролцуулах, чадавхжуулах сургалт зохион байгуулах	Ажил мэргэжлийн уралдаан сургалт зохион байгуулсан байна.	Төв, Хангайн бүсийн аварга шалгаруулах уралдаан 1 удаа, чадавхжуулах сургалтыг 3 удаа зохион байгуулсан.	Уралдаан 1-ээс доошгүй удаа, сургалтыг 2-оос доошгүй удаа зохион байгуулах	5.0	Орон нутгийн төсөв	ЗДТГ, ХБТХОХХ ХААГ	“Тогоочдын холбоо" ГҮТББ-тай хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах талаар баримталж буй бодлогыг хэрэгжүүлэх, аймгийн хоол үйлдвэрлэлд ажиллаж буй тогооч нарын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор уралдаан тэмцээнд оролцоход дэмжих, холбогдох сургалтад хамруулах, хоол үйлдвэрлэлд шинэ технологи нэвтрүүлэх, орон нутгаас зохион байгуулж буй холбогдох ажилд зохион байгуулалттайгаар идэвхтэй оролцох, төр хувийн хэвшлийн харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулсан. Тус гэрээний хүрээнд "Угсаатны хоол, идээ ундааны өв соёл" урлагийн наадам зохион байгуулах, "Чингис хаан" Олон Улсын тэмцээнд тогооч нарыг оролцуулах, Төв, Хангайн бүсийн аварга тогооч шалгаруулах уралдаанд тогооч нарыг дэмжин оролцуулах арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Дээрх ажлуудыг зохион байгуулахад орон нутгийн төсвөөс 5.0 сая төгрөг зарцуулсан.	100

95.	ТЖҮЧ 4.3.2 ЗДҮАХ 4.3	ХАА-н зохистой дадлыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд сургалт, арга зүйгээр хангах, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх	ХАА-н зохистой дадлыг үйл ажиллагаанд аа нэвтрүүлсэн тоо нэмэгдсэн байна.	Газар тариаланги йн 6 иргэн, ААНБ хамруулсан .	5-аар нэмэгдүүлн э.	6.9	Орон нутгийн төсөв	ХХААГ	Хөдөө аж ахуйн зохистой дадлыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн 4 иргэн, 2 аж ахуйн нэгж байна. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний 12 цэгт зохистой дадлыг хэрэгжүүлж, хэвшүүлэх талаар мэдээлэл өгч, арга зүйгээр ханган ажилласан. Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийг мэдлэг олгох зорилгоор plant.mofa.gov.mn цахим системд газар тариалангийн салбарын мэдээ, мэдээллийг оруулах, баталгаажуулах, "Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам"-ыг танилцуулах, урамшуулал, дэмжлэгт хамрагдахад системийг хэрхэн ашиглах, дэмжлэг, урамшууллын материалыг цахимаар хэрхэн бүрдүүлэх, Хөрсний үржил шим сайжруулах, ургацыг нэмэгдүүлэх зорилгоор бордоо хэрэглэсэн иргэн, хуулийн этгээдэд татаас олгох баримт бичгийн танилцуулга, Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журмын танилцуулга сэдвээр сургалт өгч, тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийн бүртгэлийг хийж, мэдээлэл оруулахад зөвлөн тусалсан. Дээрх сургалт, арга хэмжээнд 2 сумын 180 гаруй тариаланчдыг хамруулсан. "Хөгжлийн шийдэл" ТББ-тай хамтран "Сүүний технологи, эрүүл ахуйн зохистой дадал" сэдэвт сургалтыг зохион байгуулж эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 15 иргэн, аж ахуйн нэгж оролцуулсан.	90
96.	ТЖҮЧ 4.3.1 ЗДҮАХ 7.4	Татварын багц хуулийн хэрэгжилтийг хангуулах, татвар төлөгчдөд сургалт, сурталчилгаа хийх	Сургалт, сурталчилгаа хийсэн байна.	26 удаагийн сургалт зохион байгуулж, 3 телевизтэй хамтран сурталчилс ан.	20 удаагийн сургалт хийж, 4 телевизтэй хамтран 4 удаа сурталчилг аа хийх	10.0	Орон нутгийн төсөв	Татварын хэлтэс	2023 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг "Цахим татварын жил"-ийн болон Орхон аймаг, Эрдэнэт хот 2023 хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж батлуулсны дагуу холбогдох сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, татварын ерөнхий газраас баталсан стандартыг ханган биелүүлэхэд онцгойлон анхаарч ажиллалаа. Татвар төлөгчийн ангилал тус бүрийн зан хандлага, хэрэгцээ шаардлага тодорхойлох санал асуулга авч "Шинэ татвар төлөгч", Шинэ НӨАТ-ын суутган төлөгч, Татварын хяналт шалгалтаар илэрдэг нийтлэг зөрчил, Татварын албаны цахимжилт, Тайлан хоцроодог татвар төлөгчдөд зориулсан сургалт, Татвараа төлж хэвшээгүй татвар төлөгч, Хасагдах зардалд тавих хяналтыг сайжруулах нь, Малчид, тариаланч нарт татварын харилцаа, анхаарах асуудлууд, ХХОАТ зэрэг үндсэн 9 сэдвийг цахим хичээл болгон сургалтууд явуулсан. Сургалтыг танхимын болон цахим хэлбэрээр явуулсан. Мөн дээрх сургалтуудыг бүрэн QR үүсгэн android болон iOS үйлдлийн системтэй утаснаас сургалтыг бүрэн судлах боломжтой цаасгүй, цахим сургалтын материал үүсгэн татвар төлөгчдөд хүргэж ажилласан. Татвар төлөгчдөөс авсан зан хандлага, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон судалгааны үр дүнд нийцүүлэн сургалтыг танхимаар 35, ажлын байраар 62, цахимаар 41 удаа нийт 138 удаагийн сургалт зохион байгуулж, эдгээр сургалтад давхардсан тоогоор дунд сегмент 52, жижиг сегмент 485, бичил сегмент 4357, хувь хүн 14815 нийт 19709 татвар төлөгчийг хамруулсан. Татвар төлөгчийг мэдээллээр хангах зорилгоор давхардсан тоогоор 20135 татвар төлөгчид масс мессеж илгээсэн. Олон нийтийн цахим сүлжээнд 402 сургалт сурталчилгаа, мэдээ байршуулснаар нийт 229722 хүнд хүрч, 5780 лайк, 45657 иргэн хуваалцсан байна.	100

									Татвар төлөгч нарт зориулан 18 төрлийн гарын материал хэвлүүлэн тараах ажлыг зохион байгуулсан.	
97.	ТЖҮЧ 4.3.1 ЗДҮАХ 7.4	Малчид, тариаланчид, ногоочдын татварын цахим үйлчилгээний боловсролыг дээшлүүлж, төлбөрийн баримтын нэгдсэн системд холбох, тэдгээрийг төрөөс олгож буй урамшууллаа цахимаар авах боломжийг олгох ажлыг зохион байгуулах	Малчид, тариаланчид, ногоочдын татварын цахим үйлчилгээний боловсролыг дээшлүүлж, үйлчилгээг цахимаар авах боломжийг нэмэгдүүлнэ.	-	Цахимаар үйлчилгээ авах боломжийг хангах	45.0	Орон нутгийн төсөв	Татварын хэлтэс	Малчид, тариаланч, ногоочдын татварын цахим үйлчилгээний боловсролыг дээшлүүлж, төлбөрийн баримтын нэгдсэн системд холбох, тэдгээрийг төрөөс олгож буй урамшууллаа цахимаар авах боломжийг олгох зорилгоор тухайн үйл ажиллагааг явуулж буй 12 ААН, 560 гаруй иргэнд 4 удаагийн сургалт, 3 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж 9 төрлийн 7500 ширхэг гарын авлагаар ханган ажиллалаа. И-баримт үүсгэх, Ибаримт апп QR код уншуулан баримт үүсгэх, баталгаажуулахтай холбоотой 5 төрлийн видео контент бэлтгэн Орхон аймгийн татварын хэлтэс пэйж хуудас, Тусгал тв "Улсын тэргүүний Жаргалант сум" FB групп-ээр дамжуулан давхардсан тоогоор 17800 татвар төлөгчид хүргэсэн. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл "Тусгал", ETV, "Гэрэгэ" ТВ, сайт, "Арбис" сайтаар дамжуулан сургалт сурталчилгааг явуулж, телевизэд 10, вэб сайтад 6 удаагийн ярилцлага, мэдээ мэдээлэл, сургалт сурталчилгаа хийсэн. Малчин, тариаланч иргэдээрээ 3 удаа тойрч гэр, тариалан эрхэлж байгаа газруудад очин давхардсан тоогоор 693 өрхөөр орж 6 төрлийн 6500 гарын авлага тараан татварын мэдээ, мэдээллээр ханган ажилласан. Ингэж ажилласны үр дүнд 14 малчин сүүний урамшуулалд 9565.4 мянган төгрөгийн, 107 ногоочин хүнсний ногооны урамшуулалд 32025.3 мянган төгрөгийн урамшуулал тус тус аваад байна.	100
Зорилт 4.4. Харилцаа, хамтын ажиллагаат хөрш орнуудын муж, хотуудтай хамтран эдийн засгийн харилцааг хөгжүүлнэ.										
98.	ТЖҮЧ 4.4.1 ЗДҮАХ 3.3	Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх олон талт арга хэмжээ зохион байгуулах	Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлсэн байна.	-	хамтын ажиллагаат хот, мужуудтай харилцаа өргөжинө.	-	-	ХБТХОХ	Дархан хотод байрлах Ерөнхий консулын газартай хамтран ажиллаж Ялалтын баяр, Найрамдал хамтын ажиллагааны өдрүүдийг тэмдэглэх ажлын хүрээнд арга хэмжээг зохион байгуулсан. 2023 оны 09 дүгээр сарын 22-ноос 23-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Зэс фестиваль эвент арга хэмжээнд Дархан хотод байрлах Ерөнхий консул, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хотын төлөөлөгчид 2 бизнес төлөөлөгчид оролцсон. БНКУ-тай харилцаа холбоо тогтмолжиж ирэх онд ах дүү хотын санамж бичигт гарын үсэг зурахаар хоёр тал хэлэлцэж тохиролцсон. Монгол-Чехийн бизнес форум 2023 оны 11 дүгээр сарын 01-ээс 02-ны өдрүүдэд явагдсан бөгөөд тус форумд Орхон аймгаас Худалдаа аж үйлдвэрийн танхимын шугамаар бизнес эрхлэгч 6 аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл оролцсон.	100
99.	ТЖҮЧ 4.4.1 ЗДҮАХ 3.3	Гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагааг өргөжүүлэн хэрэгжүүлэх	Гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	-	Шинээр 1-2 төсөл хэрэгжүүлнэ.	150.0	Орон нутгийн төсөв	ХБТХОХ	НҮБ-ын Хүүхдийн сангийн 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Яргуйт багийн 28-р цэцэрлэг болон Эрдэнэ багийн хэсэгт газрын гүний дулаан болон нарны эрчим хүчээр дулаан үйлдвэрлэх чиглэлээр хамтран ажиллаж, хөрсний геологийн судалгааны ажил бүрэн хийгдэж дууссан. 2022 онд НҮБХС, БОАЖЯ, Аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд 49 өрхөд, 2023 онд орон нутгийн хөрөнгөөр 150.0 сая төгрөгөөр гэр хороллын 60 өрхөд Монгол гэрийн дулаалга, цахилгаан халаалтын багц /ЧИП/-ыг олгож гэр хороллын яндангийн тоог бууруулаа.	100
100.	ТЖҮЧ 4.4.1 ЗДҮАХ 3.3	Иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг орон нутгийн онцлогт тохирсон арга хэлбэрээр дэмжиж, төрийн	Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлнэ.	-	Гэрээгээр гүйцэтгүүлсэн байна.	80.0	Орон нутгийн төсөв	ХБТХОХ	Аймгийн Засаг даргын Тамгын газраас 2021, 2022 онуудад нийт 120 сая төгрөгийн санхүүжилтээр 30 төрийн бус байгууллага болон холбоодтой хэлтэс нэгжүүд гэрээ байгуулан жил бүрийн оны сүүлчээр дүгнэн ажилласан. 2023 онд аймгийн Засаг даргын Тамгын газраас ТББ-уудтай гэрээ байгуулахад 80.0 сая төгрөг	100

		зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх							зарцуулахаар батлагдсаны дагуу хэлтэс, нэгжээр хуваарь батлуулан гэрээ байгуулан ажилласан. Чиг үүргийн хувьд хэрэглэгчийн эрх ашгийн төлөө, хоршоо хөгжүүлэх, байгаль экологийн, хүнсний аюулгүй байдал, сургалт мэдээлэл, нийгмийн оролцоо, хөгжил, хууль эрх зүйн мэдлэг, үнийн асуудал зэрэг 14 чиг үүргийн хүрээнд хамтран ажиллаж байна.	
101.	ТЖҮЧ 4.4.2 ЗДҮАХ 2.1.1	Шилжилт хөдөлгөөний асуудлаар холбогдох байгууллагатай хамтран иргэдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх	Хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх	-	Шилжиж ирсэн иргэдийн сэтгэл ханамж, ая тухтай байдал сайжирсан байна.	70.5	Орон нутгийн төсөв	НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр	Шинэ сэргэлтийн бодлогын Хот хөдөөгийн сэргэлт зорилтыг хангах, Шилжилт хөдөлгөөний бодлоготой уялдуулан хүн амыг нэмэгдүүлэхэд иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих "Хамтдаа Эрдэнэтэд хөгжье" хөтөлбөрийг ИТХ-ын 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 15 дугаар хуралдаанаар батлуулсан. Шилжилт хөдөлгөөнийг дэмжих талаар сургалт, Үндэсний чуулган, бүсчилсэн хөгжлийн зөвлөгөөнд хамрагдаж, "Хамтдаа Эрдэнэтэд хөгжье" төлөвлөгөөнд тусгагдсан шилжин ирсэн иргэдэд ногоон карт олгож, төрийн үйлчилгээ болон хөнгөлөлттэй зээл тусламжид хурдан шуурхай хамрагдах, бүртгэлжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн. Шилжин ирсэн хүн ам, өрхийн талаар мэдээлэл цуглуулж тэдэнд тулгамдаж буй асуудлыг судлан Улаанбаатар хотоос шилжин ирсэн 946 иргэний дэлгэрэнгүй судалгааг авч, үр дүнг ЭЗХЯ-нд 2 удаа хүргүүлсэн. Шилжин ирсэн иргэдийн нийгмийн баталгааг хангах зорилгоор багш, эмч дэд хөтөлбөр, Орлогод нийцсэн орон сууц хөтөлбөр, төрийн албан хаагчийн хөгжлийн хөтөлбөр зэрэг 10 гаруй хөтөлбөрт хамруулан дэмжлэг туслалцаа үзүүлж, Коллор филм студитэй хамтран "Сайн уу? Эрдэнэт", "Эрдэнэт хотын шинэ иргэд" гэсэн 2 төрлийн нэвтрүүлэг, контентыг цувралаар хийж сурталчлан ажиллаж байна. Мөн томоохон төслүүдийг эхлүүлж хүн амын өсөлттэй холбогдуулан шилжин ирсэн иргэдийг ажлын байртай, ая тухтай амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор ОУ-ын стандартад нийцсэн эмнэлэг, сургууль, хүнс болон малын түүхий эдийн үйлдвэр, тээвэр логистик барих зэрэг 13 төслийн ТЭЗҮ хийлгэхээр ЭЗХЯ-нд хүсэлт хүргүүлсэн. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП-ын бүтээн байгуулалтын ажил, Европын сэргээн босголт хөгжлийн банктай хамтран ИШС-ны томоохон төслүүдийг эхлүүлж, эрчимжүүлэн ажиллаж байна. Хамтдаа Эрдэнэтэд хөгжье хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөний биелэлтийг Засаг даргын зөвлөл, ИТХ-ын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилт 93.2 хувьтай үнэлүүлсэн.	90
ТАВ. ТОГТВОРТОЙ ЗАСАГЛАЛ-ЭРДЭНЭТ ХҮЧ **Зорилт 5.1**. Төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.:										
102.	ТЖҮЧ 5.1.1 ЗДҮАХ 8.1.1	МУ-ын ЗГ-аас хэрэгжүүлж буй цахим шилжилтийн бодлого зорилттой уялдуулан Төрийн сангийн портал системийг нэвтрүүлэх	Төрийн сангийн портал системийг нэвтрүүлнэ.	-	Хяналт хийх, бүтээмж нэмэгдэх, ажлын ачаалал буурах, цаг, зардал хэмнэгдэнэ.	-	-	СТСХ	Төрийн сангийн төлбөр тооцоог цахим системд шилжүүлэх зорилт амжилттай хэрэгжиж 2023.01.01-ээс эхлэн нууцад хамаарах Тагнуулын газар, ЗХ-ний 110-р анги, ЗХ-ний 186-р ангиас бусад бүх байгууллагууд Төрийн сангийн удирдлагын цахим системээр /портал/ төлбөр тооцоог хийж гүйцэтгэж байна. Цахим шилжилтийн бэлтгэл ажил болгон 102 байгууллагын 214 ажилтанд сургалт хийж, шаардлага хангасан техник тоног төхөөрөмжөөр ханган ажилласнаар цаг хугацаа, хөрөнгө зардал хэмнэж, ажлын ачаалал буурсан.	100
103.	ТЖҮЧ 5.1.1	Иргэд, байгууллагууд төрийн үйлчилгээг цахимаар авдаг болгох	Төрийн үйлчилгээг цахимжуулна.	50%	Төрийн үйлчилгээ	75.0	Орон нутгийн төсөв	ТЗУХ	Орхон аймгийн Баян-Өндөр сумын гэр хорооллын нэг цонхны байранд Төрийн үйлчилгээний цэг байгуулахаар худалдан авах	50

	ЗДҮАХ 8.1.2	ажлыг үе шаттайгаар зохион байгуулах, Баян-Өндөр сумын гэр хороололд E-Mongolia төв байгуулах			70 хувь цахимжина.				үйл ажиллагааг зарлаж Шанхат хүрэн ХХК шалгаран гэрээ хийгдэж ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна.	
104.	ТЖҮЧ 5.1.1. ТЖҮЧ 2.4.3. ЗДҮАХ 1.4. ЗДҮАХ 5.7.1.	“Цахим Эрдэнэт” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Мастер төлөвлөгөө боловсруулж батлуулан, хэрэгжиж эхэлсэн байна.	Хөтөлбөрийн биелэлт 50%	1,300.0	Орон нутгийн төсөв	ХБТХОХ ЭШУТП	Хөтөлбөрийг 2021 онд 5 зорилт, 17 арга хэмжээтэйгээр баталсан бөгөөд 2023 оны гүйцэтгэлээр 10 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 3 арга хэмжээ үргэлжилж байгаа, 4 арга хэмжээ 2024 онд хийгдэх буюу нийт тоон үзүүлэлттэй байна. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 4.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээс 2023 оны гүйцэтгэлээр 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэжд байна. Зарим ажлын үр дүнгээс дурдвал Смарт Эрдэнэт платформ байгуулснаар мэдээллийн веб, статистик дашбоард систем, аппликейшн хийгдсэн. Аппликейшн 2000 хэрэглэгчтэй болж иргэн, төрийн хоорондын харилцаа, бизнесийн талбарыг шийдсэн, мэдээллийн аюулгүй байдлын хангасан шинэлэг ажил болсон. Газар зүйн мэдээллийн систем байгуулах ажилд хүн амын 95 хувь суурьшсан 5,000 га талбайн бодит зургийг сканердан монгол улсын хаягийн систем, Google газрын зурагтай харьцуулан сайжруулж QGIS системд Эрдэнэт цахим газрын зураг бүтээж албаны болон нийтийн хэрэгцээнд объектын мэдээллүүдийг багтаасан. Хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй ажлуудад Кибер аюулгүй байдлын тухай хуулийн дагуу мэдээллийн аудит хийгдэж, иргэдэд сурталчлах, сургах, бизнес эрхлэгчдийг чадавхжуулах ажлууд мөн хийгдэж байна.	100
105.	ТЖҮЧ 5.1.3 ЗДҮАХ 8.1.2	Иргэд албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг цахимаар хянах боломжийг бүрдүүлж үйл ажиллагааг жигдрүүлэх	Цахимаар өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг хянах боломжийг бүрдүүлэх	60%	Хэрэгжилт 80%	-	-	ТЗУХ	Иргэдийн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэлт, шийдвэрлэлтийн явц хэрхэн явагдаж байгааг иргэдэд нээлттэй ил тод байхаар мөн төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн И-Оффис системтэй уялдаж ажилладаг байхаар нэгдсэн https://irgen.erdenet.mn веб системийг 2022 оны 10 дугаар сараас ашиглаж эхлээд байна. Уг систем нь хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд өргөдөл гомдол санал хүсэлтийг нийтэд ил тод, нуцад хамаарах өргөдөл гомдол санал хүсэлтийг зөвхөн өргөдөл гомдол санал хүсэлт гаргагч иргэнд өөрт харагдахаар зохион байгуулагдсан. Уг системд тайлант хугацаанд иргэдээс ирүүлсэн нийтэд хамааралтай 263 өргөдөл гомдол, санал хүсэлтүүд нийтлэгдэн нийтэд ил тод байдлаар байршсан байна. Уг веб систем нь SSL сертификатыг ашиглан вэб сервер болон хэрэглэгчийн хооронд дамжигдаж буй мэдээллийг тусгай алгоритмын аргаар кодчилж мэдээллийг дундаас алдахгүй байх зорилготой аюулгүй байдлыг хангасан үйл ажиллагаагаа жигдрүүлэн хэвийн ажиллаж байна. Хэрэгжилт 100 хувь.	100
106.	ТЖҮЧ 5.1.2	Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулах	Хүний нөөцийн мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож	Цалингийн нэгдсэн системтэй сон. Туршилт, сургалтын ажлууд хийгдсэн.	Цалингийн нэгдсэн системээр төлбөр тооцоог хийдэг болно.	-	-	СТСХ	Нуцын байгууллага зарим хүчний байгууллагуудаас /тагнуул, зэвсэгт хүчний анги салбар, цагдаагийн байгууллага/ бусад 92 байгууллагын цалин хөлсийг Төрийн албаны цалингийн нэгдсэн системээр хийж байна. Ингэснээр цалин авдаг төрийн албан хаагчдын орон тоо, цалингийн санг хянах, төрийн албаны хүний нөөцийн системтэй уялдуулж орон тоо, цалин хөлсний төлөвлөлт хийх, цалин хөлс, хүний нөөцийн тайлан мэдээлэл цаг хугацаандаа, үнэн зөв гарах нөхцөл бүрдсэн	100

			ашиглалтыг сайжруулах							
107.	ТЖҮЧ 5.1.5 ЗДҮАХ 8.1	Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлэх. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг иргэд олон нийтэд сурталчлах, нэвтрүүлэлтийн ажлыг зохион байгуулах	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг иргэдэд сурталчлах, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлэх	Шилэн дансны тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлж байна.	Шилэн дансны цахим хуудсыг шинээр хөгжүүлж, нэвтрүүлэлтийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ .	-	-	СТСХ	Улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудын нягтлан бодогч, мэдээлэл оруулагч нарт Шилэн дансны нэгдсэн цахим хуудас-СХДАА, Орхон Төрийн сан зэрэг цахим хуудсаар дамжуулан Шилэн дансны цахим системийн шинэчлэл, бүртгэл үүсгэх, мэдээлэл байршуулалттай холбоотой зөвлөгөө, мэдээллийг тогтмол хүргэж ажиллалаа. Мөн албаны www.Sankhuu.audit.or.gov.mn сайтад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах талаар хийгдсэн сургалт, мэдээллийг тогтмол байршуулж байна. 1. Орон нутгийн Тусгал телевизэд "Шилэн дансны тухай" хуулийн хэрэгжилт, дотоод аудитын дүнгийн талаар 2 удаагийн мэдээлэл өгч иргэд, олон нийтийг цаг тухай бүрд нь мэдээллээр ханган ажиллаж байна. 2. Шилэн дансны тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын хэрэгжилт, 2022 оны дотоод аудитын нэгдсэн дүн, 2023 оны 01, 02 дугаар улирлын дүнг танилцуулах, Дотоод аудитаар илэрч буй нийтлэг алдаа, зөрчил, Цахим системийн шинэчлэл, мэдээлэл байршуулахад анхаарах зарим асуудал зэргийг хамруулан 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, сургалтад Орон нутгийн өмчит төсөвт байгууллага, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, Орон нутгийн өмчит хувьцаат компани, Орон нутгийн тусгай сан, аймаг сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурал зэрэг нийт 84 байгууллагын 284 мэдээлэл оруулагч, нягтлан бодогч хамрагдахаас 265 мэдээлэл оруулагч хамрагдсан. 3. Баян-Өндөр сумын ИТХ, Хот байгуулалт барилга захиалагчийн алба, Гэр бүлийн ордон, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, 16 дугаар цэцэрлэг, 16 дугаар сургууль, Хотын захирагчийн алба зэрэг байгууллагуудын 7 нягтлан бодогчид ажлын байранд, мөн 18 байгууллагын нягтлан бодогчид утсаар ганцаарчилсан зөвлөгөө, мэдээллийг өгч, арга зүйгээр хангаж ажиллалаа.	100
Зорилт 5.2. Аймгийн хэмжээнд төрийн албаны хүний нөөцийн чадвахыг улам сайжруулж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгож, нутгийн өөрөө удирдах ёсны болон захиргааны байгууллагаас боловсруулж байгаа бодлого, түүний хэрэгжилтэд салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг хангах, мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.										
108.	ТЖҮЧ 5.1.1 ЗДҮАХ 8.1.1	Төрийн байгууллагуудын И-Оффис системийн хөгжүүлэлтийг сайжруулж ЗГХЭГ болон яамдтай холбох	И-Оффис системийг ЗГХЭГ болон яамдтай холбосон байна.	80%	Төрийн байгууллагыг 100 хувь хамруулсан байна.	-	-	ТЗУХ	Дотоод удирдлагын программ хангамж болох И-Оффис системтийг 2018 оны 05 дугаар сарын 01-ээс нэвтрүүлэн төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, Засаг даргын дэргэдэх агентлаг, харьяа байгууллага, сургууль цэцэрлэгүүдийг хамарсан 154 байгууллагын 1660 хэрэглэгч албан хэргийн үйл ажиллагаандаа ашиглаж байна. Уг системийг ажлын хэрэгцээ шаардлага, засгийн газрын тогтоолуудын дагуу жил бүр өргөжүүлж хөгжүүлсээр хоорондоо уялдаа холбоо бүхий бодлого хөтөлбөр, ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, захиргаа, хүний нөөц, албан хэрэг хөтлөлт, бүртгэл тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөө, харилцаа холбоо гэсэн 7 үндсэн системд 30-аад төрлийн дэд систем болон баяжиж хөгжсөн байна. 2023 оны байдлаар улсын хэмжээнд төрийн байгууллагуудын албан бичиг солилцооны дундын систем болох https://docx.gov.mn системд интеграци хийн холбогдож тус системд холбогдсон 1506 байгууллагатай албан бичиг солилцох нөхцөл боломж бүрдэн хэвийн ажиллаж байна.	100

109.	ТЖҮЧ 5.2.1 ЗДҮАХ 8.2.1	Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, Цагийн бүртгэлийн системийг гүйцэтгэлтэй уялдуулж нэвтрүүлэх	Цаг бүртгэл, хариуцлагыг нэмэгдүүлэх	75%	90%	5.0	Орон нутгийн төсөв	ТЗУХ	Аймгийн Засаг даргын дэргэдэх нутгийн захиргааны байгууллага, төрийн албан хаагчдад иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгах, шагнаж урамшуулахдаа хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах зарчмыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа байдалд мэргэжил арга зүйн удирдлагаар тогтмол ханган ажиллаж байна. 2023 оны 1 дүгээр улиралд аймгийн төрийн захиргааны байгууллагуудын 2022 оны хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах ажлыг зохион байгуулж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хуралдаанаас гарсан дүгнэлт, зөвлөмжийг байгууллага тус бүрээр бэлтгэн төрийн байгууллагуудад хүргүүлэн ажилласан. Төрийн албаны стандартын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж төрийн жинхэнэ албан тушаалд Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-ыг чанд баримтлан, сонгон шалгаруулан нэр дэвшүүлэн томилох, Монгол Улсын ЗГХЭГ-ын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дүгээр хамтарсан тушаалын 1.5 дахь заалтыг мөрдөн төрийн жинхэнэ албан хаагчийг адил ангилал, төрлийн албан тушаалд шилжүүлэн ажиллуулж байх зөвлөмжийг хүргүүлсэн болно. Засгийн газрын 2023 оны "Журам шинэчлэн батлах тухай" 301 дугаар тогтоолоор "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам"-ыг шинэчлэн батлагдсан. Аймгийн Төрийн захиргааны 38 байгууллагын удирдлага, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн нар оролцсон нийт 61 албан хаагчдад тус журмын танилцуулга, хэрэгжүүлэхэд анхаарах зарим асуудлууд сэдвээр сургалт зохион байгуулсан.	100
110.	ТЖҮЧ 5.2.4 ЗДҮАХ 8.2.3	Төрийн албан хаагчдыг богино, зорилтот, дунд хугацааны болон мэргэшүүлэх сургалтуудад үе шаттайгаар төрөл бүрийн хэлбэрээр хамруулах	Сургалтуудад үе шаттайгаар хамруулсан байна.	50%	80%	14.0	Орон нутгийн төсөв	ТЗУХ	Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургуультай хамтран "Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь" богино хугацааны сургалтын Сургагч багш бэлтгэх сургалтад 2 байгууллагын 3, нутгийн захиргааны байгууллагад ажиллаж байгаа анх томилогдсон төрийн албан хаагчийг чиглүүлэх зайн сургалтад 3 байгууллагын 8, дунд хугацааны мэргэшүүлэх зайн сургалтад 11 байгууллагын 16 төрийн албан хаагч, цаашид ажиллах ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц зайн сургалтад 5 байгууллагын 8 төрийн албан хаагч үүнээс тухайн байгууллагын захиалгаар 5 төрийн албан хаагч, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц зайн сургалтад 2 төрийн албан хаагч тус тус хамруулсан. Монгол Улсын хөгжлийн бодлого: төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ "Алсын хараа 2050 сэдэвт богино хугацааны танхимын ажлын байран дахь сургалтыг Ерөнхий сайдын зөвлөх, ЗГХЭГ, Удирдлагын академийн багш нартай хамтран зохион байгуулж тус сургалтад 40 байгууллагын 212 төрийн албан хаагч хамруулан суралцах явцад хяналт тавин ажилласан. Мөн Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх цахим сургалтыг 2 удаа	100

									зохион байгуулан 82 төрийн байгууллагын 2178 төрийн албан хаагчид хамрагдан гэрчилгээгээ авсан.	
111.	ТЖҮЧ 5.2.4 ЗДҮАХ 8.2.3	“Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөр” боловсруулах	Хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	-	100%	300.0	Орон нутгийн төсөв	ТЗУХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 13/05 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөр"-ийг боловсруулан батлуулсан. Аймгийн Засаг даргын 2023 оны А/126 дугаар захирамжаар тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. 2023 онд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсөвт 300.0 сая төгрөг батлагдсанаас хугацаанд 47 төрийн албан хаагчдад 284.7 сая төгрөг, төрийн албан хаагчдын сургалтын зардалд 15.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Тухайн байгууллагад тогтвор суурьшил, үр бүтээлтэй, 10-аас доошгүй жил ажилласан төрийн албан хаагчдад нэг удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх дэмжлэг 9 төрийн албан хаагчдад, аймаг, орон нутгийг хөгжүүлэх, салбарын хэмжээний тулгамдсан зорилтыг шийдвэрлэхэд онцгой ач холбогдолтой эрдэм шинжилгээний бүтээл туурвисан, идэвх санаачилга гарган ажлын амжилт гаргасан, мэдлэг мэргэжлээ тогтмол дээшлүүлж байгаа болон бодит үр дүнд хүрсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн, олон нийтийг эерэг өөрчлөлт, сайн үр дүн гаргасан дэмжлэг 5 албан хаагчдад, магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр болон сайн дураараа цус, эс, эд, эрхтнээ бусдад үнэ төлбөргүй өгч донорын үүрэг гүйцэтгэсэн дэмжлэг 2 албан хаагчдад, өрхийн орлого буурч, нэг гишүүнд ногдох хэмжээ нь хүн амын амьжиргааны доод түвшинд хүрэхгүй болсон тохиолдолд гэр бүлийг нь дэмжих дэмжлэг 3 албан хаагчдад, мэргэшсэн төрийн албан хаагч бэлтгэх сургалтын дэмжлэг 1, амины орон сууц барих, орон сууц олгох, мөн худалдан авах болон орон сууцны нөхцөл сайжруулахад зохих дэмжлэгт 13 албан хаагчдад тус тус нийгмийн дэмжлэг 1.0 сая төгрөгөөс 10.0 сая төгрөг олгосон. Тус хөтөлбөрийн санхүүжилтээр УИХ-ын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо, ЗГХЭГ, Төрийн албаны зөвлөлтэй хамтран Орхон аймагт "Төрийн албан хаагчийн ёс зүй, гүйцэтгэлийн удирдлага" сэдэвт чадавхжуулах 2 өдрийн сургалт зохион байгуулсан.	100
112.	ТЖҮЧ 5.2 ЗДҮАХ 8.2	ISO37002 ОУ-ын шүгэл үлээгчийн стандарт , ISO 37001 Авлигын эсрэг үйл ажиллагааны стандарт нэвтрүүлж, хэрэгжүүлэх	Стандарт нэвтрүүлж, хэрэгжүүлсэн байна.	ISO9001 Чанарын удирдлагын стандарт хэрэгжүүлсэн.	2023 онд бүрэн нэвтрүүлсэн байна.	-	-	НДХ	Нийгмийн даатгалын байгууллагын менежментийн чадавхыг бэхжүүлэх, иргэдийг эрсдэлээс хамгаалах, удирдлага, хяналтын тогтолцоог үр ашигтай, оновчтой зохион байгуулах, төрийн байгууллагад авлига бий болох шалтгаан нөхцөлийг арилгах, хууль эрх зүйн орчныг сайжруулах, төрийн албан хаагчийн ёс зүйг дээшлүүлэх, хариуцлагыг чангатгах, шударга ёсыг бэхжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хүнд суртал, чирэгдлийг арилгах, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор олон улсын ISO 37001:2016 стандартад нийцсэн менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлыг тус хэлтэс 2022 оноос эхлэн үе шаттайгаар, холбогдох стандартаар тогтоосон шаардлагын дагуу нэвтрүүлэн ажиллаж Монгол Улсын Төрийн байгууллага дундаа анх удаа хэрэгжүүлж 2023 онд Авлигын эсрэг ISO 37001:2016 стандартад нэвтрүүлж БНЭУ-ын	100

									олон улсын баталгаажуулалтын QFC байгууллагын батламж гэрчилгээг БНЭУ-ын Элчин сайдаас гардан авсан.	
Зорилт 5.3. Хүний эрхийг хангахад чиглэсэн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.										
113.	ТЖҮЧ 5.3.1	Хүний эрхийг хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах	Төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилт 91%	Төлөвлөгөөний хэрэгжилт 95%	88.0	Орон нутгийн төсөв	ХЭЗХ	Хүний эрхийн Үндэсний Комиссын Орхон аймаг дахь ажилтан, референт Ц.Батзаяатай хамтран аймгийн Цагдаагийн газар, ШШГГ, Зэвсэгт хүчний 110 дугаар анги, Нийгмийн даатгалын хэлтэс зэрэг төрийн байгууллагуудын ажилтан, албан хаагчдад хүний эрхийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, үйл ажиллагаандаа хүний суурь эрх, арга зүйг хэрэгжүүлж ажиллах чадавхыг төлөвшүүлэх, тэр дундаа хоригдсон, баривчлагдсан, цагдан хоригдсон хүмүүстэй хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлох харьцах явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор "Хүний эрхийн үндсэн ойлголт, Хүний эрхэнд суурилсан хандлага", "Ажлын байрны дарамт, ажлын байрны бэлгийн дарамтаас ангид байх эрх" сэдвүүдээр нийт 200 гаруй албан хаагчдад сургалт зохион байгуулсан. Мөн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад "Хүүхдийн эрхийг сургуулийн орчинд хамгаалах", "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Ye тэнгийн дээрэлхэлтийг зогсооё" сэдвээр тус тус сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын захирамжаар аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд өвөл, хаврын улирал буюу 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглож, холбогдох мэргэжлийн байгууллагууд хяналт тавьж ажиллаж байна. Тайлант хугацаанд энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил бүртгэгдээгүй байна.	100
ЗУРГАА. НОГООН-ЭРДЭНЭТ ХОТ **Зорилт 6.1.** Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.										
114.	ТЖҮЧ 6.1.2 ЗДҮАХ 4.1.5	Эрдэнэт хотын агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Агаар дахь PM тоосонцрын дундаж агууламж MNS4585:200 стандартын түвшнээс хэтэрсэн.	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	184.0	Орон нутгийн төсөв	БОАЖГ ХБТХОХ	Эрдэнэт хотын агаарын чанарын хэмжилт, судалгааг нийт 4 суурин харуулаар тогтмол хийж, дүн мэдээг http://www.tsag-agaar.gov.mn/, www.Agaar.mn сайтуудаар бүх нийтэд ил тод мэдээлж байна. Агаарын чанарын 2023 оны хүйтний улирлын хяналт шинжилгээний дүнгээр хүхэрлэг хийн дундаж агууламж 21 мкг/м3 буюу агаарын чанарын MNS4585:2016 стандартаас хэтрээгүй байна. Азотын давхар ислийн дундаж агууламж 126 мкг/м3, стандартаас хэтрээгүй боловч хотын төв орчим нийт хэмжилтийн 30 хувь нь хүлцэх агууламжаас давсан байна. PM2.5 тоосонцрын агууламжийн дундаж дүн 0.0682мг/м3 хүрч стандартаас 1.4 дахин, хотын төв орчим нийт хэмжилтийн 80%, гэр хороолол орчим 63% нь хүлцэх агууламжаас давсан байна. БОАЖЯ-аас хэрэгжүүлж буй хүлэмжийн хийг бууруулах төслийн хүрээнд 2-3 өрхөд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, дулаалга, цахилгаан халаалтыг багцаар нь шийдвэрлэж, карбон кредит тооцуулах туршилтын ажлыг зохион байгуулахаар бэлтгэл хангаж, гэр хороллын нийт 480 иргэнийг сургалтад хамруулж, урьдчилсан судалгааны ажлыг эхлүүллээ. Эрдэнэт хотын агаарын чанарын бүсийг шинэчлэн батлуулсантай	70

									холбогдуулан агаарын чанарын бүсийн зураг, бүсэд мөрдөх журам, Агаарын тухай хуулийн холбогдох заалтуудыг тусгасан гарын авлагыг бэлтгэн хэвлүүлж, Баян-Өндөр сумын ЗДТГ, гэр хорооллын 19 багийн ажлын албаны хэрэгцээнд олгож, мэдээллээр хангаж ажиллалаа. Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд 166 өрх өөрийн хөрөнгөөр цахилгаан халаалт нэвтрүүлснээс гадна олон улсын төсөл хөтөлбөртэй хамтран нэмэлтээр Монгол гэрийн дулаалга, цахилгаан халаалтын багц/ЧИП/-ыг нийт 109 өрхөд олгож, агаар бохирдуулагч эх үүсвэрийн тоог 275-аар бууруулаа. Цаашид гэр, байшингийнхаа халаалтыг утаагүй технологиор өөрчилсөн өрх бүрд урамшуулал олгох тогтолцоог бүрдүүлэхээр журмын төслийг боловсруулж байна.	
115.	ТЖҮЧ 6.1.2,3,4	Агаар болон орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх	-	Төлөвлөгөө ний 11 арга хэмжээний хэрэгжилтээ р	-	-	БОАЖГ, УЦУОШТ	Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан Агаар болон орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөний нийт 17 арга хэмжээг хяналтад авч, 2023 онд 98 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжилтийг зохион байгуулж ажиллалаа. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг томоохон бохирдуулагч эх үүсвэрүүд болох 28 үйлдвэр, аж ахуйн нэгжийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хянан баталгаажуулж, технологийн болон холбогдох хууль, журмын хүрээнд тогтмол хяналт тавьж, дүгнэж ажиллалаа. Мөн бохирдуулагч эх үүсвэрүүдийн эрсдэлийг бууруулах зорилгоор 2023 оны байдлаар төлөвлөгөөт хяналт шалгалтаар 28 аж ахуйн нэгж, төлөвлөгөөт бус болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 91 үйлдвэр, аж ахуйн нэгжид гүйцэтгэж, 51 аж ахуйн нэгж, иргэнд улсын байцаагчийн албан шаардлага, 10аж ахуйн нэгж байгууллага, иргэнд зөвлөмж, 30 аж ахуйн нэгжид, иргэнд мэдэгдэл өгч, Байгаль орчны багц хууль зөрчсөн 19 зөрчилд зөрчлийн тухай хуулийн дагуу 12160.0 мянган төгрөгийн торгууль, 28918.0 мянган төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж, зөрчлийг арилгуулж ажиллалаа.	100
116.	ТЖҮЧ 6.1.3 ЗДҮАХ 4.1.6	Зориулалтын бус газар хуримтлагдсан, эзэнгүй хог хаягдлын судалгааг хийж, цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах	Судалгаа гаргаж, цэвэрлэгээни й ажлыг зохион байгуулсан байна.	Хавар, намар цэвэрлэгээн ий ажлыг зохион байгуулсан.	Зохион байгуулсан цэвэрлэгээн ий ажлын тоо 2	35.0	Орон нутгийн төсөв	БОАЖГ	Эрдэнэт хотын эргэн тойронд, Булган аймгийн хил залгаа сумдын хилийн бүс нутгаар хуримтлагдсан эзэнгүй хог хаягдлыг цэвэрлэх ажлыг ХХҮГ-тай хамтран 20 иргэнийг түр ажлын байраар ханган зохион байгуулж, нийт 55 цэгийн 840м.куб хог хаягдлыг бүрэн цэвэрлэж, дарж, устгууллаа. Орхон аймгийн хэмжээнд нийт 25 цэг байршилд 162 гаруй малын гаралтай хог хаягдал, сэг зэмийн байршлыг тогтоож, цэвэрлэж, ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг хийж гүйцэтгэлээ. Орхон АЗЗА ТӨХК-ийн Дархан-Эрдэнэт чиглэлийн А1001 дугаартай 108 км, Эрдэнэт-Булган чиглэлийн А1002 дугаартай 29.7 км авто замууд, Эрдэнэт Төмөр замын хариуцсан замын дагуух 2 талын 50м хүртэлх газрын 2тн хог хаягдлыг цэвэрлүүлж, бохирдлыг бууруулж ажиллалаа. Булган аймгийн Бугат сумын нутаг, Овоот хөтлийн баруун талд Жавхлант харгуй ХХК, Өлзий хутгийн наран ХХК-иудын гаргасан карьерын орчинд хуримтлагдсан их хэмжээний хог хаягдлыг түрүүлж, орчны тархсан 320 м.куб хог хаягдлыг цэвэрлүүллээ. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын 24 цех нэгжийн нийт 242 албан хаагчид Хангал голын голдирол дагуух хог хаягдлыг цэвэрлэх	100

									ажлыг зохион байгуулж, 28 тн хог хаягдлыг цэвэрлэн төвлөрсөн хогийн нэгдсэн цэгт буулгалаа.	
117.	ТЖҮЧ 6.1.3 ЗДҮАХ 4.1.4	Гэр хорооллын нүхэн жорлонг эко ариун цэврийн байгууламжаар өөрчлөх ажлыг үргэлжлүүлэх	Эко ариун цэврийн байгууламж нэмэгдүүлэх	673 өрх хангагдсан.	Эко ариун цэврийн байгууламжийн тоо 300	200.0	Орон нутгийн төсөв	БОАЖГ, ХБТХОХ	Гэр хорооллын айл өрхөд стандартын шаардлага хангасан эко ариун цэврийн байгууламжийн суурийн байгууламжийг барьж, гүйцэтгэх 2023 оны БЗА-65/23 гэрээт ажлын гүйцэтгэгчээр Би Юу Эм Ди ХХК ажиллаж, орон нутгийн төсвийн 200.0 сая төгрөгөөр гэр хорооллын 12 багийн нийт 45 өрхөд соруулдаг технологитой эко ариун цэврийн байгууламжийн суурийн хэсгийг иж бүрэн хийж дуусан. БЗА-41/22 гэрээт ажлын гүйцэтгэл он дамжин хэрэгжиж 2023 оны 8 дугаар сард нийт 78 өрхийн суурийн байгууламжийг бүрэн хийж, хаяавч бетоныг цутгаж, улсын комисс ажиллаж хүлээж авлаа. Мөн өөрийн хөрөнгөөр гэр хорооолд 4 өрх стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж хийсэн. 2023 оны байдлаар нийт 1718 ширхэг эко ариун цэврийн байгууламжийг шинээр барьж, ашиглалтад оруулаа.	100
118.	ТЖҮЧ 6.1.1 ЗДҮАХ 4.1.10	Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Цагаан тоосны дэгдэлтээс бий болсон нөлөөллийг	Цагаан тоосны дэгдэлтийн бууралт 30 хувь	Цагаан тоосны дэгдэлтийн бууралт 80 хувь	-	-	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах дэд хөтөлбөр" 2022 онд хугацаа дуусан тул аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурал болон аймгийн ИТХ-ын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 85 хувьтай дүгнүүлсэн. Аймгийн ИТХ-ын даргын баталсан удирдамжийн дагуу ИТХ-ын Хөгжлийн хороо, ажлын албаны төлөөлөл, аймгийн ЗДТГ, мэргэжлийн агентлагууд хамтран Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Хаягдлын аж ахуйн үйл ажиллагаатай танилцаж, Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдэж буй ажилтай газар дээр нь танилцаж, тулгамдаж буй хүндрэл бэрхшээлийн талаар нээлттэй уулзалт зохион байгуулсан ба цаашид хөтөлбөр төлөвлөгөөг үргэлжлүүлэхээр шийдвэрлэсэн тул шинэчлэн, боловсруулж, нөлөөллийн бүсийн багуудын ИНХ-аар хэлэлцүүллээ. Цагаан тоосны сөрөг нөлөөллийг бууруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 67 дугаар тушаалаар 12 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж, нийт 3 удаа хуралдаж, Хаягдлын аж ахуйг нүүлгэн шилжүүлэх чиглэл өгсний дагуу Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас хаягдал өтгөрүүлэх технологийн ТЭЗҮ-г боловсруулан батлуулж, 2027 онд ашиглалтад оруулахаар технологийн ажил хийгдэж байна. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь цагаан тоосны дэгдэлтийг бууруулах, зорилгоор тоос дарагч 3 төрлийн бодисыг устай хольж тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж ашиглан хуурайшилттай талбайд цацах, хаягдал булингад хольж өгөх, үйлдвэрийн технологийн аргуудыг хослуулан Хаягдлын аж ахуйн тоос идэвхтэй дэгддэг 1100 га хуурай талбайн 85 хувийг тогтмол дарж ажиллалаа.	100
Зорилт 6.2. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялагийг зүй зохистой ашиглуулах, нөхөн сэргээлтийг эрчимжүүлнэ.										
119.	ТЖҮЧ 6.2.2 ЗДҮАХ 4.1.9	Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудын уулын ажлын төлөвлөгөө болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд жилд 1 га-с	Нөхөн сэргээлтийн ажлыг хийлгүүлж, гүйцэтгэлд хяналт	2022 онд 3 га-д хэрэгжүүлсэн.	Аж ахуйн нэгж байгууллагуудын нөхөн сэргээлт хийх шаардлагат	-	-	БОАЖГ	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө тусган батлуулсны дагуу ил уурхайн 3 дугаар овоолго дээр 3.9 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийж 1000 ширхэг мод тарьж, арчлан хамгаалж, ургуулаад байна. Дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж	100

		доошгүй техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийлгүүлж, гүйцэтгэлд хяналт тавих	тавьсан байна.		ай талбайн хэмжээ 2 га				байгууллагуудтай "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Ногоон Эрдэнэт" хөтөлбөрийн хүрээнд "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ орон нутгийн тусгай хамгаалалттай Баян-Өндөр хайрхны зүүн талын энгэрт Хүрэнбулагийн аманд 2 га талбайд 630 метр хамгаалалтын хашаа хийж, 4 төрлийн 1500 ширхэг мод, Эрдмин ХХК нь Эрдэнэт шинэ хаалга болон Хангал голын голдирол дагуу 1 га талбайд 560 метр хамгаалалтын хашааг хийж, ногоон зурвас байгуулж 1000 ширхэг мод, Ачит-Ихт ХХК эрдэнэт шинэ хаалга болон Хангал голын голдирол дагуу 1 га талбайд 500 метр хамгаалалтын 2 хэсэг төмөр хашаа хийж 1144 ширхэг мод, Гал сэнтий ХХК нь Эрдэнэт голын голдирол дагуу 140 метр хамгаалалтын хашааг хийж 1000 ширхэг мод, Очир төв ХХК Хангал гол дагуу 500 ширхэг улиас моднуудыг 0.5га талбайд, Зэс эрдэнийн хувь ХХК үйлдвэрийнхээ авто замын ногоон зурваст 1000 ширхэг улиас, Дэлт хошуу ХХК үйлдвэрийнхээ авто замын ногоон зурваст 500 ширхэг агч моднуудыг тус тус тарьж нийт 8.4 га талбайд мод тарьж арчлан хамгаалж, ургуулан ажиллаж байна. Улсын хэмжээнд эвдэрч эзэнгүй орхигдсон 8000 га талбайгаас Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 2021-2024 оны хугацаанд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь 2000 га-д техникийн нөхөн сэргээлт хийхээс 2023 оны жилийн эцсийн байдлаар 1200 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийгээд байна.	
120.	ТЖҮЧ 6.2.3 ЗДҮАХ 4.1.9	Жаргалант сумын нутаг дэвсгэрт элэгдэж, эвдэрч, эзэнгүй орхигдсон 1.5 га газарт техникийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгүүлж нийтийн эзэмшилд шилжүүлэх	Нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээг нэмэгдүүлсэн байна.	Нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ 2022онд 62га	Нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээг 1.5 га-аар нэмэгдүүлн э.	16.0	Орон нутгийн төсөв	БОАЖГ	Орхон аймгийн Жаргалант сумын Улаантолгой багийн нутаг дэвсгэрт буюу Тасгийн толгойд эвдэрч, эзэнгүй орхигдсон 1.5га газрын техникийн нөхөн сэргээлтийн ажлыг нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллагын эрхтэй Өү би би таун ХХК-тай гэрээ байгуулан БОНХАЖС-ын 2015 оны А/138 дугаар тушаалаар батлагдсан уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлалын дагуу гүйцэтгүүлж ажлын хэсэг актаар хүлээн авч тус талбайд дахин эзэнгүй хог хаягдал асгуулахгүй, эвдэрсэн газар шинээр бий болгохгүй байхыг Жаргалант сумын ЗДТГ-ын байгаль орчны хэсэг, байгаль хамгаалагч нарт даалгаж ажилласан. Очир төв ХХК-ийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө тусган батлуулсны дагуу Баянцагаан багийн нутаг дэвсгэр дэх Моогийн айлуудын урд талд ухагдаж эвдэрсэн 0.5га-д техникийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгүүлсэн. Нийт 14.9 га талбайг нөхөн сэргээгээд байна.	100
121.	ТЖҮЧ 6.2.2 ЗДҮАХ 4.1.10	Аж ахуйн нэгж байгууллагуудаас байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ” хийж нөлөөллийг бууруулах	Шинээр хэрэгжиж буй төсөл болон өргөтгөл, шинэчлэл хийж буй байгууллагад “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ” хийх	62 аж ахуй нэгж хамруулсан.	Аж ахуйн нэгж байгууллагуудыг нэмж хамруулна.	-	-	БОАЖГ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргах процессыг И-Монголиа цахим системд шилжүүлэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын дагуу 2023 оны жилийн эцсийн байдлаар шинээр хэрэгжих болон хэрэгжиж буй нийт 56 төсөлд Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж, тус төслүүдийг нөхцөл болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой гэж дүгнэж, БОАЖЯ-ны цахим мэдээллийн санд оруулан байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулан ажиллаж байна.	100
Зорилт 6.3. Усны хуримтлал, ус хангамжийг нэмэгдүүлэх, усны нөөц, чанарын хяналт, мэдээллийн шуурхай байдлыг ханган, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах, зохистой ашиглах менежментийг хэрэгжүүлэн, хаягдал бохир усыг эргүүлэн ашиглах, усыг зөв хэрэглэх, хэмнэх төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.										

122.	ТЖҮЧ 6.3.1 ЗДҮАХ 4.1.4	Усны хэрэглээний талаар зөв мэдлэг, хандлага, дадлыг бий болгох сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах	Сургалт сурталчилгаа ны ажлыг зохион байгуулах	16 удаа	4 удаа	3.0	Орон нутгийн төсөв	БОАЖГ МХГ СГСГЗ	Монгол улсад Усны салбар үүсэж хөгжсөний 85 жилийн ойн хүрээнд "Өөрчлөлтийг хурдасгая-Дэлхийн усны өдөр"-ийг хамтран зохион байгуулах ажлын төлөвлөгөөний дагуу мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр дараах үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагууд хамтран зохион байгууллаа. Үүнд: -Монгол Улсад усны салбар үүсэж хөгжсөний 85 жилийн ойн хүрээнд ус хэмнэх чиглэлээр "УС 85" дүрс бүхий сурагчдын зураг авалтыг Colorfilm студитэй хамтран хийлээ. Тус арга хэмжээнд ерөнхий боловсролын 4, 5, 14, 15 дугаар сургуулиудын ахлах ангийн усны элч 85 сурагч хамрагдлаа. -Хотын ус хангамж, түгээлт, нийлүүлэлтийн талаар сурагчдын дунд аялал зохион байгуулж, Бүрэнбүстийн унд, ахуйн ус хангамжийн эх үүсвэрт ажиллалаа. -Мөн сурагчдын дунд усны чиглэлээр АХА танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулж, тэмцээнд амжилттай оролцсон сурагчдыг өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулав. Хүүхэд, залуучуудын театртай хамтран "Ус" драмын жүжгийг сурагчдад үзүүлж, усны үнэ цэнэ, ач холбогдлын талаар мэдээлэл хүргэлээ. -Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар Дэлхийн усны өдрийг тохиолдуулан "Цэнхэр алт" усны салбарын үндэсний чуулган "ӨӨРЧЛӨЛТ, СЭРГЭЛТИЙГ ХУРДАСГАЯ" ириалгын хүрээнд зохион байгуулагдлаа. Тус чуулганд Орхон аймгаас СГСГЗ, БОАЖГ, Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын Ус хангамжийн цех, Эрдэнэт Ус ДТС ОНӨХК-иас нийт 20 гаруй төлөөлөл оролцлоо. "Гүүд нэйборс" олон улсын ТББ-ын Монгол дахь суурин төлөөлөгч, Орхон аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу "Ундны ус эрүүл ахуй" хөтөлбөрийн хүрээнд сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулагдлаа. Тус сургалтад аймгийн БОАЖГ, ЭМГ, Баян-Өндөр сумын сумын ЗДТГ, Яргуйт, Их залуу, Эрдэнэ, Дэнж багийн ажлын албаны төлөөлөл хамрагдлаа. Дээрх хөтөлбөрийг орон нутгийн хөгжлийн хөтөлбөрт тулгуурлан, өрхийн түвшинд ундны усны аюулгүй байдлыг хангах, ариун цэврийн байгууламжийн оновчтой хэрэглээний талаар өрхийн гишүүдийн ойлголтыг нэмэгдүүлж, эрүүл аж төрөх зөв дадал хэвшилтэй болохыг дэмжих зорилгоор гэр хорооллын 1166 иргэнд сургалт хийсэн.	100
123.	ТЖҮЧ 6.3.1 ЗДҮАХ 4.1.7	Хөв цөөрөм байгуулах, булаг шандын эх ундаргыг хамгаалж тохижуулах	Цөөрөм байгуулах, булаг шандын эх ундаргыг хамгаалж тохижуулсан байна.	Хамгаалсан булаг шанд 32	Тухайн жил нэмж хамгаалалт ад авсан булаг шандын тоо 1, хөв цөөрмөө дуусгах	284.0 60.0	Орон нутгийн төсөв НҮБХХ	ХЗА БОАЖГ	Усны нөөцийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах чиглэлээр Уртбулаг, Ар булагийн урсцыг нэмэгдүүлэх боломжийн судалгааны ажлыг Шинжлэх ухааны академийн газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн судалгааны баг хийж, булгуудын дэд сав газрын физик газар зүйн нөхцөл, хөрсний шинж чанар, гадаргын усны чанар, газрын доорх усны чанарыг тодорхойлох зорилгоор дээж авах ажлыг зохион байгууллаа. Дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх ажлын хүрээнд Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт байрлах Баянцагаан, Далиу, Долоонбулаг, Хөөвөр, Хүрэнбулаг зэрэг 5 булгийн эх ундаргыг бүрэн хашиж, сэргээн засварлах ажлыг үйлдвэр, аж ахуйн нэгжүүдтэй хамтран зохион байгуулан ажиллаж байна. Бүрэнбүстийн овооны хөв цөөрмийн ажлыг 2023 онд иж бүрэн дуусгах ажлын гүйцэтгэгчээр Ээлт-Өлгий ХХК шалгарч ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдсан.	70

									Мөн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хөв цөөрмийн хамгаалалтын хашааны зардалд 60.0 сая төгрөгийг шийдвэрлүүлэн ажилласнаар 740 м урт хамгаалалтын хашааг бариулж ашиглалтад авлаа.	
124.	ТЖҮЧ 6.3.1 ЗДҮАХ 4.1.7	Газрын доорх усны горимын өөрчлөлтөд хяналт тавих зориулалт бүхий цооногийг тоноглон улсын сүлжээнд холбож, автоматжуулах	Зориулалт бүхий цооногийг тоноглон автоматжуулах	2021 онд 1 багц тоноглосон.	1 багц нэмж тоноглоно.	45.0	Орон нутгийн төсөв	БОАЖГ	2023 онд Баян-Өндөр сумын "Дэнж багийн нутаг дэвсгэрт байрлах унд ахуйн эх үүсвэрийн цооногийг бүрэн автомат төхөөрөмжөөр тоноглож, улсын сүлжээнд холбох" ажлыг усны мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрөлтэй Сантгидро консалтинг ХХК гэрээний дагуу гүйцэтгэж, актаар хүлээлгэн өглөө. Гэрээний дагуу тус мониторингийн цооногт Нидерланд Улсад үйлдвэрлэсэн бүрэн автомат системд ажилладаг багажийн иж бүрдлийг суурилуулсан "Эрдэнэт Ус ДТС" ОНӨХК хяналт тавин ажиллах боломжтой боллоо. Газрын доорх усны хяналт шинжилгээний ажлыг бүрэн автомат системээр гүйцэтгэснээр ус ашиглалтын явцад уст давхаргад үүсэх түвшин бууралт болон чанарын өөрчлөлтийг цаг тухай бүрд хүний оролцоогүйгээр хэмжиж, мэдээллийн онлайн санг бий болгодгоороо давуу талтай бөгөөд газрын доорх усны ордын цаашдын ашиглалтын горим, бодлогыг төлөвлөхөд чухал ач холбогдолтой юм.	100
125.	ТЖҮЧ 6.3.1 ЗДҮАХ 4.1.7	Усан орчны хяналт мониторингийн цэг байгуулах.	Мониторингийн цэг байгуулах хэрэгжүүлэх	-	Урсац үүсгэгч тунадас, хөрсний чийгийн динамик, ууршилт, шүүрэлт зэргийг 1 удаа тодорхойлох	53.0	Орон нутгийн төсөв	БОАЖГ	"Усан орчны хяналт мониторингийн цэг байгуулах" ажлын гүйцэтгэгчээр Таширын хүрээ ХХК шалгарч, геофизикийн тандан судалгааны ажлын үр дүнд үндэслэн Баян-Өндөр сумын Даваат багийн нутаг дэвсгэрт судалгаа шинжилгээний зориулалттай 40 м-ийн гүнтэй хяналтын цооног өрөмдөх ажлыг гэрээний дагуу гүйцэтгэлээ. Мөн урсац үүсгэгч тунадас, хөрсний чийгийн динамик, ууршилт, шүүрэлт зэргийг тодорхойлох онлайн хэмжилт хийх багажуудыг суурилуулан Баян-Өндөр сумын ЗДТГ нь админы эрхтэйгээр хамтран ажиллаж байна.	100
Зорилт 6.4. Уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг судлах, түүнийг бууруулах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.										
126.	МУТЖҮЧ 6.2.5 МУХЖТ 5.1.9 ТЖҮЧ 6.4.2 ЗДҮАХ 4.1.8	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон Эрдэнэт” хөтөлбөрийн хүрээнд Эрдэнэт хотын ойролцоох суурьшлын бус газруудад үе шаттайгаар мод тарьж, ойн төгөл, зурвас байгуулах, хамгаалалтын хашаа хийх, мод тарьж ургуулсан иргэн аж ахуйн нэгж байгууллагыг шагнаж, урамшуулах	Суурьшлын бус газруудад үе шаттайгаар мод тарьж, ойн төгөл, зурвас байгуулах	Суурьшлын бус газрын таримал ойн 42.5 га талбайд 321 мянган ширхэг тарьсан.	Суурьшлын бус газрын таримал ойн 82.5 га талбайд 471 мянган ширхэг мод тарина.	383.3	Орон нутгийн төсөв	БОАЖГ, ААНБ	Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд 2023 онд Дэнж багийн нутаг дэвсгэр Тарлан толгойн энгэрт 17.5 га-д ойн төгөл, Жаргалант суманд 6.6 га-д газар тариалангийн ойн зурвас, Сархиа уул, Хангал гол, Эрдэнэт хаалга орчим, Эрдэнэт голын эх, Хүрэн булгийн ам зэрэг газруудад 12.66 га талбайд нийт 1888068 ширхэг мод тарьсан. Мод тарих ажлыг зохион байгуулснаар 2023 онд таримал ойн хэмжээг 36,76 га талбайгаар нэмэгдүүлж, өссөн дүнгээр 92.76 га талбайд мод тарьж, ойн төгөл, зурвас байгууллаа.	100
127.	МУТЖҮЧ 6.2.5 МУХЖТ 5.1.9 ТЖҮЧ 6.4.2	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон Эрдэнэт” хөтөлбөрийн хүрээнд жилд ойжуулах талбайн хэмжээг 25 га-д хүргэх, хэрэгцээтэй тарьц,	Ойжуулсан талбайн хэмжээ нэмэгдсэн байна.	Ойжуулсан талбайн хэмжээ 126 га	Ойжуулсан талбайн хэмжээ 224 га	129.6	Орон нутгийн төсөв	БОАЖГ	2023 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ойн мэргэжлийн байгууллагаар Жаргалант сумын Хонгор морьтын амны ойн сангийн 48 га талбайг, Баян-Өндөр уулын Цагаанчулуутын аманд Япон улсын Оиска ТББ-ын дэмжлэгтэйгээр "Сайвар хээр" ХХК-аар 4 га талбайд тус тус ойжуулалтын ажлыг гүйцэтгүүлж нийт 52 га талбайг ойжууллаа.	100

	ЗДҮАХ 4.1.8	суулгацын нөөцийг бүрдүүлэх							Нийт өссөн дүнгээр ойжуулсан талбайг 114 га талбайд хүргээд байна. Аймгийн хэмжээнд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэд, аж ахуйн нэгж, нөхөрлөл, төрийн бус байгууллагуудад тарьц, суулгацын нөөц 7 дахин нэмэгдэж, 4 төрлийн шилмүүст модны 0.4 сая ширхэг, 20 төрлийн навчит модны 2.0 сая ширхэг тарьц, суулгацын нөөц бүрдүүллээ.	
128.	МУХЖТ 5.1.9 ТЖҮЧ 6.4.2 ЗДҮАХ 4.1.8	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон Эрдэнэт” хөтөлбөрийн хүрээнд суурьшлын 4 бүсэд таримал ойн төгөл байгуулах	Таримал ойн төгөл нэмэгдсэн байна.	Суурьшлын бүсийн таримал ойн талбай 22.7 га	Таримал ойн төгөл 83.7 га-д хүргэнэ.	436.0	Орон нутгийн төсөв	БОАЖГ	Тарлан толгойн хойд энгэрт 17.5 га, Сархиа ууланд 1.5 га, Говил багт 0.5 га, Ачит-Ихт ХХК-ийн үйлдвэрийн орчимд 56 га, нийт 76 га таримал ой байгуулж, 288,788 ширхэг мод тарьж, өссөн дүнгээр 98.7 га талбайд хүргэлээ.	100
ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ ХОТ **Зорилт 7.1** Гэмт хэрэг, уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоотойгоор нийгмийн аюулгүй байдлыг хангана.										
129.	ТЖҮЧ 7.1 ЗДҮАХ 8.3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна.	Төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувь	Төлөвлөгөөний хэрэгжилт 95 хувь	30.0	Орон нутгийн төсөв	Салбар зөвлөл	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.7-д заасны дагуу орон нутгийн төсвийн 30 сая төгрөгийн санхүүжилтээр "Цагаан шонхорын жигүүр" ТББ-тай хамтран сүүлийн 5 жилийн хугацаанд Орхон аймагт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох криминологийн судалгааг хийж гүйцэтгүүлсэн. Дээрх судалгааны дүгнэлтийг үндэслэн цаашид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогыг тодорхойлж аймгийн хэмжээнд 3 зорилт 21 арга хэмжээ бүхий "2024-2027 онд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр"-ийн төслийг боловсруулж аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 94.7 хувьтай байна.	99.7
130.	ТЖҮЧ 7.1.1 ЗДҮАХ 8.3.3	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих ажлыг эрчимжүүлэх	Мансууруулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх	Гэмт хэрэг зөрчлийн тоо	Энэ төрлийн гэмт хэрэг зөрчлийн тоо буурсан байна.	18.0	Орон нутгийн төсөв	ХЭЗХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 437 дугаар нээлттэй хорих ангитай хамтран хорих ангийн алба хаагч нарт "Мансуурсан этгээдэд илрэх шинж тэмдэг, биедээ авч явж болзошгүй, хэрэглүүрийг шалгах эсэх" талаар сургалт, мэдээлэл өгч, хорих ангийн хашаанд каннабисын ургамал ургаж болзошгүй байх тул хяналт шалгалтыг явуулж, хоригдогч нарын эд зүйл, биед үзлэг шалгалтыг явуулан ажилласан. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, тариур худалдаалдах зөвшөөрөлтэй 8 эмийн сан ажиллаж, эм, тариурын хадгалалт, хамгаалалт, орлого, зарлагын тайланд хяналт шалгалтыг явуулж зөвлөгөө, мэдээлэл хүргүүлж ажилласан. 2023 оны 07 дугаар сард үйл ажиллагаа явуулж буй 13 аж ахуй нэгжүүдэд Эрүүл мэндийн сайдын 2015 оны 68 дугаар тушаалаар батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахад ямар нэгэн зөрчил илрээгүй. Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй "Тархцын хяналт-2023" нэгдсэн арга хэмжээний хүрээнд 2017 оноос хойш мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг гэмт хэрэг, мансуурсан гэх зөрчилд холбогдсон этгээдүүдийн судалгааг гаргаж, эмзэг цэгийг тогтоох чиглэлээр хяналт тавьж ажиллаж байна. "Туншил" арга хэмжээний хүрээнд эмчийн хуурамч жор үйлдэн сэтгэцэд нөлөөт эм, эмийн сангаас авч хэрэглэсэн 2	100

									иргэнд холбогдох гомдол мэдээлэлд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа мөн 1 иргэнээс анхан шатны байдлаар "МЕТ" буюу Метамфетамины агууламж бүхий бодис хэрэглэсэн болох нь тогтоогдсон бөгөөд шинжилгээний дээжийг ШШҮХ-рүү явуулж, мөрдөн шалгах ажиллагааг тус тус явуулж байна. Улсын хэмжээнд явагдсан "Анзаар" нэгдсэн арга хэмжээ болон аймгийн хэмжээнд "Мансуурал" хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж 4101 хүнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар ашиглах, хэрэглэхээс урьдчилан сэргийлэх мэдээлэл өгч, цахим орчинд 83 мэдээлэл сэрэмжлүүлгийг байршуулж 47061 иргэнд сэрэмжлүүлэг хүргэж ажилласан. Урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулснаар тайлант хугацаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн гаралт өсөөгүй.	
131.	ТЖҮЧ 7.1.3	“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хэрэгжилтийн хувь 70.8	Хэрэгжилтийн хувь 80.0	98.1	Орон нутгийн төсөв	ХЭЗХ	Хууль сурталчлах, иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх зөвлөгөө мэдээллээр хангах чиг үүрэг бүхий 8 эрх зүйн хөтчийг ажиллуулж, цалин, нийгмийн даатгалын шимтгэлд зориулж орон нутгийн төсөвт 68.1 сая төгрөгийг батлуулж, гэрээ байгуулан Хууль, эрх зүйн хэлтсээс удирдлага, арга зүй, зохион байгуулалтаар ханган ажлын үр дүнг тооцож ажиллаж байна. Бүх нийтэд эрх зүйн боловсрол олгох үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн төсөвт 30.0 сая төгрөг батлуулж, "Аймгийн Нутгийн удирдлагын ордон"-ны нэг цонхны үйлчилгээний байр, Захиргааны IV-р байрны нэг цонхны үйлчилгээний байр, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын байр болон иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах, мөн хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх зорилгоор ажиллуулж буй 7035-3511 утсаар дамжуулан 332 иргэнд, биечлэн 1003 иргэнд тус тус хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээллийг өгч ажилласан. Мөн шүүхэд нэхэмжлэл гаргах, хариу тайлбар гаргах, төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл гомдол, хүсэлт гаргах асуудлаар хандаж ирсэн бичиг үсгийн чадваргүй эсхүл харааны бэрхшээлтэй болон өндөр настай 35 иргэдэд туслалцаа үзүүлж ажилласан. Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг "Номин" телевизтэй хамтран 2023 онд "Хуулийн цаг" 30 удаагийн нэвтрүүлэг, Эрх зүйн хөтөч нар тайлант хугацаанд 11 сэдвээр 20 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор нийт 1088 хүн хамрагдаж, 66 төрлийн зурагт хуудас, гарын авлага, постер, номын эх бэлтгэн иргэдэд тарааж, богино хэмжээний видео 10 бэлтгэж телевиз болон цахим хэлбэрээр иргэдэд сурталчилж нийт давхардсан тоогоор 111890 хүний цахим орчинд хандалт үзүүлсэн байна. Хэрэгжилт 90.0 хувьтай байна.	100
132.	ТЖҮЧ 7.1.2 ЗДҮАХ 8.3.7	Архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээг сайжруулах, албадан эмчилгээнд хамруулах, архидан согтуурахтай тэмцэх, хяналт тавих, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх	Согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлсэн байна.	Албадан эмчилгээнд хамруулсан тоо 19 хүн	Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчлийн тоо буурсан байна.	6.0	Орон нутгийн төсөв	ХЭЗХ	Орон гэргүй, тэнэмэл байдлаар амьдардаг, архи согтууруулах ундаа байнга хэтрүүлэн хэрэглэж, гудамж талбай, ахуйн хүрээнд байнга архидан согтуурч зөрчил үйлддэг иргэдийн судалгааг хэсгийн байцаагч нараар гаргуулан авч нийгэмшүүлэх байранд орон гэргүй тэнэмэл 30 иргэнийг байршуулж, гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй иргэдэд хяналт тавин ажилласан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийгэмшүүлэх үйлчилгээнд хамрагдсан иргэд 11 иргэнээр буюу 26.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Архины хамааралтай, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ухуулга,	100

									яриа сургалт сурталчилгааг 3 удаа зохион байгуулан, нийт 44 иргэн хамрагдсан. Орхон аймагт архины албадан эмчилгээнд иргэдийг хамруулахад 6.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгуулж, архи соргуурруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэдэг, тэнэмэл амьдралаар амьдардаг 75 иргэнийг бүртгэл судалгаанд авч, архи соргуурруулах ундааны хор уршгийн талаар яриа таниулга хийн, албадан эмчилгээнд явуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн "Уярлын бичээс", "Аминчхан яриа" ТББ-уудтай хамтран Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч, хяналтад байдаг 15 иргэнийг "Зан үйлд нөлөөлөх" сургалтад 2 удаа хамруулан ажилласан. Аймгийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Сэтгэц, наркологийн төвтэй хамтран сайн дурын эмчилгээнд 10 иргэнийг хамруулсан. "Ариунсаруулбат" НҮТББ-тай хамтран 20 иргэнийг сайн дурын эмчилгээнд хамруулах ажлыг үргэлжлүүлэн явуулж байна. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 204 бүртгэгдэж, өмнөх оноос 7.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	
133.	ТЖҮЧ 7.1.5, 7.1.6 ЗДҮАХ 8.6.1	Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, албадын дунд “Аврагч-2023” ЕБС-иудад “Өсвөрийн аврагч-2023”, тэмцээн зохион байгуулах	“Аврагч-2023” ЕБС-иудад “Өсвөрийн аврагч-2023”, тэмцээн зохион байгуулах	ЕБС-уудын ахлах ангийн сурагчид, гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, албад оролцсон.	ЕБС-ийн сурагчид, гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, албадыг чадавхжуулах	13.0	Орон нутгийн төсөв	ОБГ	Орхон аймгийн Засаг даргын 2023 оны А/624 дүгээр захирамжаар Аж ахуй нэгж байгууллагууд Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын анхны тусламжийн нөхөрлөлүүдийн дунд "Аврагч-2023" тэмцээнийг 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах аврах 68 дугаар ангийн сургалтын талбайд Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын газар, Улаан Загалмайн хороо хамтран зохион байгуулсан. Тэмцээнд нийт 11 анхны тусламжийн нөхөрлөлийн 165 ажилтан, албан хаагчид хамрагдсан.Онцгой байдлын ерөнхий газар, аймгийн Засаг даргын А/307 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээн АЗДТГ, Онцгой байдлын газар, Улаан Загалмайн хороо, Боловсрол шинжлэх ухааны газар хамтран ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, аврах, өөртөө болон бусдад анхны тусламж үзүүлэхэд сургаж дадлагажуулах, тэдний тэсвэр хатуужил, авхаалж самбааг сорих, хүнлэг энэрэнгүй иргэн болгон төлөвшүүлэх зорилготой Өсвөрийн аврагч-2023 тэмцээнийг 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан. Тэмцээнд Ерөнхий боловсролын, төр, хувийн хэвшлийн сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулж 9 сургуулийн 11 бүлэг 77 сурагч 11 багш хамрагдсан.	100
134.	ТЖҮЧ 7.1.6 ЗДҮАХ 8.6.1	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах	Төлөвлөгөө 94%	95-аас доошгүй хангах	18.0	Орон нутгийн төсөв	ОБГ	Ойн тухай хуулийн 17, 18, 26 дугаар зүйлүүдэд заасны дагуу 2023 онд ой, хээрийн түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын төлөвлөгөөг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны 12/08 дугаар тогтоолоор 4 хэсэг 21 заалт бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус тогтоолыг үндэслэн 2023 онд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах тухай аймгийн Засаг даргын 2023 оны А/148 дугаар захирамж, Баян-Өндөр сумын Засаг даргын 2023 оны А/58, Жаргалант сумын Засаг даргын 2023 оны А/52 дугаар захирамжуудаар суманд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, эргүүл шалгалт хийх аж ахуйн нэгж, байгууллагын хуваарийг гарган хэрэгжилтийг	100

									ханган ажиллаж байна. Ойн тухай хуулийн 17, 18, 26 дугаар зүйлүүдэд заасны дагуу 2023 онд ой, хээрийн түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын төлөвлөгөөг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны 12/08 дугаар тогтоолоор 4 хэсэг 21 заалт бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус тогтоолыг үндэслэн 2023 онд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах тухай аймгийн Засаг даргын 2023 оны А/148 дугаар захирамж, Баян-Өндөр сумын Засаг даргын 2023 оны А/58, Жаргалант сумын Засаг даргын 2023 оны А/52 дугаар захирамжуудаар суманд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, эргүүл шалгалт хийх аж ахуйн нэгж, байгууллагын хуваарийг гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
Зорилт 7.2. Хууль сахиулах, батлан хамгаалах салбарын материаллаг баазыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.										
135.	ЗДҮАХ 8.3.5	Архивын баримтыг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх	Цахимжуулах ажлыг эрчимжүүлэх	Цахимжуул алтын хувь 35	Цахимжуул алтын хувь нэмэгдсэн байна.	18.3	Орон нутгийн төсөв	ХЭЗХ	“Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн төсөвт 18.3 сая төгрөгийг тусган батлуулж 2 архивч операторчийг нэмж ажиллуулснаар нийт 4 гэрээт ажилтан архивын баримтыг цахимжуулах ажлыг гүйцэтгэж байна. Тайлант хугацаанд 13 хөмрөгийн 26 дансны 1100 хадгаламжийн нэгжийн 86560 хуудас баримтыг нягтлан шалгаж, скайнардаж, цахим хувь үүсгэсэн. Үүнээс 13 хөмрөгийн 26 дансны 711 хадгаламжийн нэгжийн 70973 хуудасны 133758 хүний нэр, 20640 байгууллагын нэр, 26507 газар зүйн нэр, 62280 заалтыг архивын AMS болон E-DOC программд шивж цахим холболт хийн мэдээллийн сан үүсгэн лавлагаанд ашигласнаар иргэдэд чирэгдэлгүй түргэн шуурхай үйлчилж байна. E-DOCUMENT программд малын А дансыг нягтлан шалгаж, цахим холболтыг хийж, малын А данс бүрэн цахимжсан. Ингэснээр нийт баримтын 40 хувийг цахим хэлбэрт оруулаад байна.	100
136.	ЗДҮАХ 8.3.5	Төрийн архивын баримтын хадгалалт, хамгаалалт, ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах, шаардлагатай техник, хэрэгслээр хангах	Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Шаардлагатай тоног төхөөрөмжийн тоо	Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан байна.	251.7	Орон нутгийн төсөв	ХЭЗХ	Төрийн архивын хадгаламжийн сангийн өрөөний багтаамжийг нэмэгдүүлэх зорилгоор Засаг даргын тамгын газрын шинээр баригдсан өргөтгөлийн барилгад 69 м.кв хадгаламжийн сангийн 1 өрөөг шинээр тохижуулан 220.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2500х900х560 хэмжээ бүхий 13 ширхэг ухаалаг нягтруулсан шүүгээ, галын дохиолол гал унтраах техник хэрэгслээр хангаж сан хөмрөгийн өрөөний багтаамжийг нэмэгдүүлсэн. Мөн 4 ширхэг иж бүрэн компьютероор хангаж, баримтыг цахимжуулах болон лавлагаа мэдээллээр үйлчлэх ажлыг шуурхай явуулах нөхцөлийг бүрдүүлсэн.	100
137.	ТЖҮЧ 7.2	Хуулийн байгууллагуудын хүний нөөц, техник, тоног төхөөрөмжийг сайжруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх	Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг жил бүрийн төсөвт тусгасан.	Тухайн жил шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	829.3	Орон нутгийн төсөв	ХЭЗХ	Прокурорын газарт тоног төхөөрөмж худалдан авахад 50.0 сая, УБХ-т киоск машин худалдаж авахад 28.0 сая, Архивын тасагт байнга хадгалах баримтыг сэргээн засварлахад 5.0 сая төгрөг, МШУТ-д автовишка худалдан авахад 90.0 сая төгрөг, ШШГГ-ын үйлдвэрлэлийн хэсэгт оёдлын машин худалдан авахад 90 сая төгрөг зэрэг нийт 829.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэж байна. Мөн хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах, хуульд заасан	100

									үйлчилгээ үзүүлэхэд 35.6 сая төгрөгийг зарцуулан ажиллахаар төсөв батлуулсан. ШШГГ-т орон нутгийн төсвийн 5.2 сая төгрөгийн санхүүжилтээр эмнэлгийн багаж хэрэгсэл худалдан авч өвчтөн хоригдол, хоригдогч, баривчлагдсан этгээдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ, өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн амбулаторийн үзлэгт давхардсан тоогоор 1134, урьдчилан сэргийлэх үзлэгт 915 хоригдогч, хоригдол, баривчлагдсан этгээдийг хамруулсан. Мөн аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 18.0 сая төгрөг шийдвэрлүүлж зорчих эрх хязгаарлах ял шийтгүүлсэн ялтнуудад техникийн хяналт тогтоох, сургалтад шаардагдах 2 ширхэг ухаалаг дэлгэц худалдан авсан. Шүүх шинжилгээний хэлтсээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Уртын гол багт шинээр ашиглалтад орж буй орон сууцнаас 2 өрөө байрыг тус хэлтэст хуваарилж, сэлгэнээр томилогдон ажиллаж буй алба хаагчдыг байрлуулан нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн. Мөн тус хэлтсийн "Малын тамганы цахим сан бүрдүүлэх" ажлын хүрээнд цахим систем хийхэд 4.9 сая төгрөгийг орон нутгийн төсвийн тодотголоор батлуулж, "Малын тамганы цахим бүртгэл" SUREG.MN систем нэвтрүүлж, аймгийн адууны тамганы санг бүрдүүлэн ажиллаж байна ЦГ-т Олон нийтийн цагдаагийн ажилтны тоог 40 орон тоогоор батлуулж, цалингийн хэмжээг нэмэгдүүлэн, цалин, НДШ-д шаардагдах 459.0 сая төгрөгийг зарцуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна УБХ-т иргэний болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, гэрээт ажилтан ажиллуулахад дэмжлэг үзүүлж 25.2 сая төгрөгийг батлуулан цалин, НДШ-ийг төлж байна.	
138.	ТЖҮЧ 7.2.3	Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, өмгөөлөгчдийн орон тоог нэмэгдүүлж байгаатай холбогдуулж шаардлагатай ажлын байр, ажиллах нөхцөлөөр хангах	Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, шаардлагатай ажлын байр, ажиллах нөхцөлөөр хангах	.-	Үйлчилгээ сайжирсан байна.	5.0	Орон нутгийн төсөв	ХЭЗХ	Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг тогтворжуулах, төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвөөс 5.0 сая төгрөг батлуулж, төвийн үйл ажиллагаанд байнгын дэмжлэг үзүүлж, иргэдэд үйлчлэх нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллаж байна. 2023 онд төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох 43 хэргийг хүлээн авч 33 хэргийг шүүхээр болон шүүхийн өмнөх шатанд шийдвэрлүүлж хууль зүйн туслалцаа үзүүлсэн байна. Мөн 103 иргэнд хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан байна.	100
Зорилт 7.3. Мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хангаж, цахим халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.										
139.	ТЖҮЧ .7 .3.2 ЗДҮАХ 8.3.1	Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагааг сайжруулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангаж, сүлжээний аюулгүй байдлыг хангах	Шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангаж, сүлжээний аюулгүй байдлыг хангасан байна.	-	Төвийн үйл ажиллагаа сайжирч, аюулгүй байдал хангах	784.0	Орон нутгийн төсөв	ХЭЗХ,	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 90 сая төгрөгийн үнэ бүхий камерын засвар үйлчилгээ хийхэд шаардлагатай тусгай зориулалтын автовишкатай автомашиныг худалдан авч Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн үндсэн хөрөнгөд бүртгэж авсан. Автовишкатай болсноор давхардсан тоогоор нийт 100 орчим камерын шон дээр 250 гаруй камерыг, дагалдах хэрэгслийн хамт бүрэн шинэчилж засварласан. Мөн гэр хорооло́лд агаарын баганаар татагдсан кабелийн гэмтлийг засварлан 3км шилэн кабель татаж, унжсан аюултай байдал бий болсон 7 цэгт шилэн кабелийг дээш нь татах сойх	100

									ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн. Баян-Өндөр сумын багуудын Засаг дарга, ажлын алба, хэсгийн байцаагч, иргэдийн төлөөлөл нартай уулзалт зохион байгуулж гэмт хэрэг ихээр гардаг хар цэгийн судалгаа дээр үндэслэн камер суурилуулах байршил, цэгийг 26 багаар нарийвчлан гаргаж, 2023 онд аймаг, сумын хөрөнгө оруулалтаар Уурхайчин багт 17, Цагаанчулуут багт 12, Эрдэнэ багт 36, Булаг багт 35, Хүрэнбулаг багт 26, Зэст багт 7 ширхэг, нийт 133 ширхэг камерыг шинээр нэмж суурилуулан хүлээн авсан. Аймгийн хэмжээнд 26 багт нийт 649 камер бүртгэлтэй байгаагаас нэг чиглэлийн 524 ширхэг, PTZ хөдөлгөөнт 78 ширхэг, хэт ягаан туяаны 2ширхэг, ANPR дугаар таних зориулалттай 2 ширхэг камер тус тус ажиллаж байна. Камерын хяналтын нэгдсэн төвд 577 иргэн, 40 албан хаагчийн хүсэлтээр 617 удаагийн камерын бичлэг шүүж иргэд, аж ахуйн нэгжид учирсан 352.1 сая төгрөгийн хохирлоос 238.7 сая төгрөгийн эд зүйлийг олж тогтоон хохирлыг барагдуулж ажилласан. Дэвшилтэт технологид боловсруулсан өгөгдлийг ашиглан хяналтын камеруудыг үр ашигтай, эдийн засгийн үр өгөөжтэй ашиглаж хиймэл оюун ухаанд суурилсан системийг нэвтрүүлэх туршилтыг амжилттай хийсэн. Уг систем нь энгийн камераар авто машины дугаар илрүүлэх, хүний биометрик мэдээлэл, царай төрхөөр олж илрүүлэх боломжтой.	
140.	ТЖҮЧ .8 .1.2 ЗДҮАХ 8.3.1	Хотын камержуулалтыг нэмэгдүүлж, Шуурхай удирдлагын төвтэй холбох	Камержуулалтыг нэмэгдүүлж, төвтэй холбох	524 /камерийн тоо/	Камержуулалтыг нэмэгдүүлсэн байна.	729.0	Орон нутгийн төсөв	ХЭЗХ,	Аймгийн хэмжээнд бүх багийг бүрэн камержуулах, тоног төхөөрөмжөөр хангах засвар үйлчилгээг найдвартай хангах үүднээс жил бүр орон нутгийн төсөвт техник тоног төхөөрөмж худалдан авах хөрөнгийг тусган камержуулах ажлыг хийж гүйцэтгэж байна. 2023 онд аймаг, сумын 729.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 133 ширхэг камерыг шинээр суурилуулахаар гүйцэтгэгч компаниудтай гэрээ байгуулан ажилласнаар Уурхайчин багт 17 ширхэг, Цагаанчулуут багт 12 ширхэг, Эрдэнэ багт 36 ширхэг, Булаг багт 35 ширхэг, Хүрэнбулаг багт 26 ширхэг, Зэст багт 7 ширхэг камерыг тус тус суурилуулан ашиглалтад бүрэн оруулсан. Одоогийн байдлаар 26 багт нийт 649 камер бүртгэлтэй байгаагаас нэг чиглэлийн 524 ширхэг, PTZ хөдөлгөөнт 78 ширхэг, хэт ягаан туяаны 2ширхэг, ANPR дугаар таних зориулалттай 2 ширхэг камер тус тус ажиллаж байна 2023 онд Камерын хяналтын нэгдсэн төвд 577 иргэн, 40 албан хаагчийн хүсэлтээр 617 удаагийн камерын бичлэг шүүж иргэд, аж ахуйн нэгжид учирсан 352.1 сая төгрөгийн хохирлоос 238.7 сая төгрөгийн эд зүйлийг олж тогтоон хохирлыг барагдуулж ажилласан байна.	100
НАЙМ. ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-ЭРДЭНЭТ ХОТ **Зорилт 8.1.** Хот төлөвлөлтийн хүрээнд шинэ суурьшлын бүсийг бий болгох, байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилга, байгууламжийг нэмэгдүүлэн, хотын төвлөрлийг задалж, ухаалаг технологийн шинэчлэл хийнэ.									
141.	ТЖҮЧ 8.1.1 ЗДҮАХ 5.1.2	Эрдэнэт хотын гудамж, талбайн нэр, эд хөрөнгийн хаягжуулалтын зургийг боловсруулж батлуулах, иргэд, олон нийтэд сурталчилж, зохион байгуулах	Батлуулж иргэд, олон нийтэд сурталчилж, зохион байгуулах	-	Гэр хорооллын багуудын 70% хаягжуулсан байна. 22 багт	5.0 51.0	Орон нутгийн төсөв ОНХС	ХБТХОХ ГХБХБГ	Хаягжуулалтын тухай хуулийн дагуу Орхон аймгийн хаягжуулалтын зураг боловсруулах ажлын хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгээд байна. Үүнд: - Баян-Өндөр сумын ИТХ-ын 2020 оны 06 дугаар 40 дүгээр тогтоолоор батлагдсан гэр хорооллын 14 багийн 930 гудамжны нэр, Жаргалант сумын ИТХ-ын 2022 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан 3 багийн 73 гудамжны нэр, 23038 нэгж талбарын	90

					сурталчилна.				мэдээллийн санд бүртгэж оруулсан. Үүнээс 2023 онд 2630 нэгж талбарт хаягийн мэдээлэл олгогдсон. - Зайлшгүй нэр өгөх шаардлагатай 57 гудамж /хотын доторх 35 гудамж, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын эзэмшил газар доторх 22 гудамж/ -нд нэр өгөх ажлыг 2023 оны 10-р сард Аймгийн Газар зүйн нэрийн салбар зөвлөл, Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах комиссоор хэлэлцүүлэн сумын ИТХ-ын ээлжит 15 дугаар хурлаар Аврагчдын гудамж, Эрдэнэт үйлдвэр орчмын хэсгийн гудамж талбайг нэршлийг баталсан. Аймгийн хэмжээнд Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй, хаяг олгогдоогүй нийт 23038 нэгж талбарын мэдээллийн санд бүртгэж оруулсан. Үүнээс 2023 онд 2630 нэгж талбарт хаягийн мэдээлэл олгогдсон. Хаягжилтыг батлагдсан стандартын дагуу Шанд багт гэр хорооллын гудамжны хаягийн тэмдэг 24ш, хашааны дугаарын тэмдэг 610ш, Дэнж багт гэр хорооллын гудамжны хаягийн тэмдэг 56ш, хашааны дугаарын тэмдэг 1200, Рашаант багт гэр хорооллын гудамжны хаягийн тэмдэг 43, хашааны дугаарын тэмдэг 1000 хийхэд Баян-Өндөр сум 51.0 сая баталсан. Тус ажлыг Межин хишиг ХХК шалгарсан ажил явагдаж байна.	
142.	ТЖҮЧ 8.1.2 ЗДҮАХ 5.1.6	Гэр хорооллын багуудад “Миний гудамж-Бидний гэр” төслийн төвлөрсөн шугам барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Төвлөрсөн шугам барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Холбогдох нөхцөл бүрдсэн өрхийн тоо 431	Холбогдох нөхцөл бүрдсэн өрхийн тоо 640-д хүрнэ.	9,000.0	Орон нутгийн төсөв	ХЗА ХБТХОХ	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 9 тэрбум төгрөгөөр гэр хорооллын дараах 7 багт инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэн. Үүнд: Булаг багт дулаан хэрэглээний халуун хүйтэн усны 0.94 км, цэвэр усны 0.94 км, бохирын 0.5 км, Рашаант багт дулаан, хэрэглээний халуун хүйтэн усны 1.63 км, цэвэр усны 1.63 км, Наран багт дулаан, хэрэглээний халуун хүйтэн усны 1.14 км, цэвэр усны 1.1 км, бохирын 0.52 км, Цагаанчулуут багт бохир усны 0.76 км, Баянцагаан багт дулаан, хэрэглээний халуун, хүйтэн усны 0.98 км, Дэнж багт дулаан, хэрэглээний халуун хүйтэн усны 0.88 км, цэвэр усны 0.88 км, бохир усны 0.26 км, Говил багт дулаан, хэрэглээний халуун хүйтэн усны 2.22 км, нийт 5.78 км төвлөрсөн инженерийн шугам сүлжээний ажил хийгдлээ. Төслийн үр дүнд 1245 өрх төвлөрсөн шугамд холбогдох боломж бүрдэж, 253 айл өрх бүрэн холбогдсон.	100
143.	ТЖҮЧ 8.1.2 ЗДҮАХ 5.1.6	Орон сууцны хорооллын багуудад “Миний орц-Бидний байшин” төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх	“Миний орц-Бидний байшин” төслийг хэрэгжүүлэх	Төслийг боловсруулсан.	Төслийг хэрэгжүүлж эхэлнэ.	379.5	Орон нутгийн төсөв	ХЗА ХБТХОХ	"Миний орц-Бидний байшин" төслийн хүрээнд 14 орцны засварын ажилд орон нутгийн төсвөөс 379.5 сая төгрөг зарцуулсан. Үүнд: Дэнж багийн 3 байрны 6 орцны засварын ажлыг Алист констракшн ХХК, Баянцагаан багийн Вокзалын 3, 4 дүгээр байрны 8 орцны засварын ажлыг Өвөлжөөн булаг ХХК тус тус гүйцэтгэж ашиглалтад өглөө.	100
144.	ТЖҮЧ 8.1.6 ЗДҮАХ 5.6	9-р цэг хүртэл Ду700мм-ийн 3.5 км дулааны төв шугамыг шинээр барих	Төв шугамыг шинээр барих	-	Шугам шинэчлэгдсэн байна.	910.0	Улсын төсөв	“ЭДЦС” ТӨХК	2022 онд Улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар ЭДЦС ТӨХК-иас 9 дүгээр цэг хүртэлх Ду700мм-ийн 3.5 км дулааны төв шугамыг шинээр барих ажлын гүйцэтгэгчээр "Эрин гүрэн" ХХК шалгарч, ажлыг хийж гүйцэтгэж байна. Одоогийн байдлаар тус ажил 65 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.	70
145.	ТЖҮЧ 8.1.6 ЗДҮАХ 5.6	Хотын гэр хорооллын цахилгааны эх үүсвэрийн найдвартай ажиллагааг хангах	Цахилгааны эх үүсвэрийн найдвартай ажиллагаа хангагдсан байна	-	Найдвартай ажиллагаа хангагдсан байна.	251.2	Орон нутгийн төсөв	“ЭБЦТС” ТӨХК	2023 онд Орхон аймгийн өсөн нэмэгдэж байгаа цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах зорилгоор Эрдэнэ багт 35кв-ын ЦДАШ-ыг барих ажлыг ЭБЦТС ТӨХК өөрийн хөрөнгө оруулалтаар ажил 60 хувийн гүйцэтгэлтэйгээр ажиллаж байна. Эрдэнэ багт 35/6 кВ-ын дэд станц шилжүүлэн барих ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах тендер зарлагдаад байна. Орхон аймагт 2021 оноос Дэлхийн банкны 6.98 сая долларын /19.5тэрбум/ санхүүжилтээр он дамжин	70

									хийгдэж байгаа Баян-Өндөр сумын гэр хорооллын 16 багийн гудамж хоорондын 0.4кВ-ын цахилгааны модон тулгууруудыг төмөр бетонон шонгоор солих ажлыг "Ричвелл инженеринг" ХХК гүйцэтгэж байна. Одоогоор 0.4кВ-ын Цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлын гүйцэтгэл 92.1 хувь, хуучин орон сууцны цахилгаан хангамж 85.9 хувь, гэр хорооллын тоолууржуулалт 62.8 хувь орон сууцны тоолууржуулалт 80.3 хувь, 6кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлын гүйцэтгэл 39.8 хувийн гүйцэтгэлтэйгээр төлөвлөгөөний дагуу ажил хийгдэж байна.	
146.	ТЖҮЧ 8.1.3 ЗДҮАХ 4.1.3	Эрчим хүчний хэмнэлттэй нар, салхины эрчим хүчийг дулааны эх үүсвэр болгон ашиглах технологи нэвтрүүлэх	Халаах хэрэгсэл нэвтрүүлсэн байна.	-	100 өрхөд халаах хэрэгсэл нэвтрүүлсэн байна.	150.0	Орон нутгийн төсөв	ХЗА ХБТХОХ	Гэр хорооллын дахин төлөвлөлт, шинэ суурьшлын бүсийг бий болгох, байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилга байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Баян-Өндөр сумын 2 байршилд хийгдэх /Эрдэнэ багийн 6 га талбайд 60 айл, Уурхайчин багийн Сархиа уулын энгэрт 48га талбайд 300 айл/-ын амины орон сууцны төслийг бүх нийтэд танилцуулж, "Ногоон амины орон сууц"-ны нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж, барилга орон сууц, ногоон технологийн шийдлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 40 гаруй аж ахуйн нэгж оролцож, иргэдийг мэдээллээр хангаж ажиллалаа. Агаар бохирдуулагч суурин эх үүсвэрийн тоог бууруулах хүрээнд 2022 онд НҮБ-ын Хүүхдийн сан, БОАЖЯ, Аймгийн Засаг даргын хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд 49 өрхөд, 2023 онд орон нутгийн хөрөнгөөр 150.0 сая төгрөгөөр гэр хорооллын 60 өрхөд тус тус монгол гэрийн дулаалга, цахилгаан халаалтын багц/ЧИП/-ыг олгож гэр хорооллын яндангийн тоог бууруулсан. Баян-Өндөр сумын хэмжээнд 275 өрх халаалтаа цахилгаанаар шийдвэрлэсэн	70
147.	ТЖҮЧ 8.1.2 ЗДҮАХ 5.1.6	Орон сууц болон гэр хорооллын гудамжны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх	Гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх	9700 ш гэрэлтүүлэг	500 ш гэрэлтүүлэг	1,700.0	Орон нутгийн төсөв	ХЗА ХБТХОХ	2023 онд "Эрдэнэт Ус ДТС" ОНӨХК -тай хамтран хотын гэрэлтүүлгийн асалтын байдалд газар дээр нь 11 удаагийн үзлэг хийж тухай бүрд засварлуулах арга хэмжээ авч ажилласан. 2023 онд орон нутгийн төсвийн 1.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 14 байршилд 568 ширхэг гэрэлтүүлэг шинээр хийгдэхээр төлөвлөсөн. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай хэрэгжсэн. Орхон аймгийн нийт гэрэлтүүлэг 2023 оны 12 дугаар сарын байдлаар нийт 8785 шонгийн 10722 гэрэлтэй. Үүнээс орон сууцны хорооллын 973 гэрэлтүүлэг, гэр хорооллын 5952 гэрэлтүүлэг, Авто зам дагуух 3797 гэрэлтүүлэгтэй байна.	100
Зорилт 8.2. Найдвартай, аюулгүй, хямд, хүртээмжтэй, ухаалаг нийтийн тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ.										
148.	ТЖҮЧ 8.2.2 ЗДҮАХ 5.10.1	Нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулж, нөхөн олговрыг нэмэгдүүлэх	Нөхөн олговрыг нэмэгдүүлэх	-	Нөхөн олговор олгогдож, хяналт сайжирсан байна.	1224.07	Орон нутгийн төсөв	Авто тээврийн төв	Аймгийн хэмжээнд шинээр бий болсон суурьшлын бүс болон асфальтбетон хучилттай авто зам ашиглалтад орсонтой холбогдуулан 2021-2022 онд "Төгөл-Вокзал" чиглэлийг шинээр баталж хэрэгжүүлсэн. 2023 онд аймгийн Засаг даргын А/597 тоот захирамжаар "Даниста-Урд Хабитат-Дэнж-Уртын гол" чиглэлийг шинээр баталж тус чиглэлд стандарт шаардлага хангасан аж ахуй нэгж байгууллагыг сонгон шалгаруулах нээлттэй төслийг зарлаад байна. Одоогийн байдлаар 7 чиглэлд 25 дунд оврын автобус нийтийн тээврийн үйлчилгээг үзүүлж байна. Нийтийн тээврийн хэрэгслээр хууль тогтоомжоор заасан үнэ төлбөргүй зорчих иргэдийн нөхөн олговрыг 400.0 сая төгрөгөөр нэмэгдүүлснээр 1.6 тэрбум төгрөг болсон байна. "Тод од ХХК" 28078 машин цаг ажиллаж 499469.5 мянган төгрөг, "ББ-ОД" ХХК 36708 машин цаг ажиллаж 651704.8 мянган төгрөг, "Авто мастер төв" ХХК 72,900	100

									мянган төгрөг нийт 64786 машин цаг ажиллаж 1224.0 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна.	
149.	ТЖҮЧ 8.2.5 ЗДҮАХ 5.10.1	Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай тээврийн хэрэгслийг нэвтрүүлж, парк шинэчлэлтийг үргэлжлүүлэх	Парк шинэчлэлтийг үргэлжлүүлэх	Автобусны парк шинэчлэлт 0 хувь	Автобусны парк шинэчлэлт 50 хувь	1,500.0	Орон нутгийн төсөв	Авто тээврийн төв	2021 онд хувийн хэвшлийн байгууллагууд өөрийн хөрөнгө оруулалтаар 4 ширхэг автобус, 2022 онд нийтийн тээврийн парк шинэчлэлтэд зориулж орон нутгийн төсөвт 2.2 тэрбум төгрөгийг зарцуулж "Хьюндай моторс Монгол" ХХК БНСУ-д үйлдвэрлэгдсэн шинэ 12 ширхэг дунд оврын автобусыг хүлээлгэн өгч нийтийн тээврийн үйлчилгээнд явуулж байна. 2023 онд байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай тээврийн хэрэгслийг нийтийн тээврийн парк шинэчлэлтэд нэвтрүүлэх ажлын хүрээнд орон нутгийн төсвөөс 1.5 тэрбум төгрөгөөр 5 ширхэг дунд оврын автобус худалдан авахаар худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.	90
150.	ТЖҮЧ 8.3.2 ЗДҮАХ 5.10.2	Зорчигч тээврийн үйлчилгээний нэгдсэн “Авто буудал” байгуулах, тоног төхөөрөмжөөр хангах	“Авто буудал” байгуулах, тохижуулах	-	Барилгын ажил эхэлсэн байна.	3,900.0	Орон нутгийн төсөв	ГХБХБГ	2022 онд Шинжүү ХХК нь орон нутагт зорчигч тээврийн үйлчилгээний нэгдсэн "Авто буудал"-ын барилгын ажлыг эхлүүлсэн.2023 онд улсын төсвийн 3.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Авто буудал"-ын барилгын ажлыг 90 хувийн гүйцэтгэлтэйгээр гүйцэтгэж байна.	100
Зорилт 8.3. Хотын хэсэгчилсэн болон ерөнхий төлөвлөгөөг төлөвлөж, зам харилцаа, инженерийн дэд бүтэц байгуулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлж, хотын соёлыг төлөвшүүлнэ.										
151.	ТЖҮЧ 8.3.1 ЗДҮАХ 5.2	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, зургийн даалгаварт санал өгөх, орон нутгийн ажлын хэсгийг байгуулж, сурталчлах ажлыг үе шаттай зохион байгуулах	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулсан байна.	Ажлын даалгавар, шинэ, дахин төлөвлөх суурьшлын бүсүүдийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулсан.	Эрдэнэ, Зэст баг, Уурхайчин орон сууцны хорооллын баруун талд амины орон сууц 10 га-д зураг төсөл боловсруулагдана	-	-	ХЗА, ХБТХОХ	"Гэр хорооллын газрын дахин төлөвлөн барилгажуулах" ажлын хүрээнд Их залуу багийн нутаг дэвсгэрт 40.8га, Цагаанчулуут багийн нутаг дэвсгэрт 11.9 га газар, Хүрэнбулаг багийн нутаг дэвсгэр Уурхайчин-1 хотхоны баруун талд баригдах амины болон цөөн давхар барилгын орон сууцны хотхон хорооллын 10 га газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг хийгдэж байна. Мөн Эрдэнэ багт 2.5 га талбайд дахин төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулан сонгон шалгаруулалт зарласан. Оюут багийн Сархиа уулын энгэрт 4 га талбайд 300 айлын амины орон сууцны төслийг хэрэгжүүлэхээр суурь судалгааны ажил хийгдэж байна.	90
152.	ТЖҮЧ 8.3.1 ЗДҮАХ 5.2	Хот байгуулалт, газрын харилцааны цахим мэдээллийн санг сурталчлах ажлыг зохион байгуулах	Цахим мэдээллийн санд орсон үйлчилгээг нэмэгдүүлнэ.	Газрын харилцааны цахим мэдээллийн санд орсон үйлчилгээ 27%	Цахим мэдээллийн санд орсон үйлчилгээ 30%	-	-	ГХБХБГ	Газрын цахим систем www.egazar.gov.mn-г сурталчлах "НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ"-ийг Баян-Өндөр сумын 16 багт, Жаргалант сумын 3 багт зохион байгуулж ажиллалаа. Өдөрлөгийн үеэр egazar цахим системийн танилцуулга 500 ширхэг гарын авлагыг хэвлэж олон нийтэд тараасан. Мөн төрийн байгууллагуудын нэгдсэн Нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож хот байгуулалтын Urban.gov.mn цахим сайтыг сурталчлан ажилласан. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд Инженерийн шугам сүлжээний мэдээллийг бүртгэх ажлын хүрээнд 2023 оны 07 дугаар сарын 26, 27, 28-нд "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, "Эрдэнэт Ус" ДТС ОНӨХК, "Эрдэнэт дулааны цахилгаан станц" ТӨХК, "Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн 13 инженерүүдэд сургалт орж, зөвлөгөө, мэдээлэл өгсөн.Газрыг харилцааны цахим шилжилтийн хүрээнд төрийн үйлчилгээг иргэд олон нийтэд түргэн шуурхай хүргэх зорилгоор Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн 46.0 сая төгрөгийн 2 ширхэг цахим үйлчилгээний киоск төхөөрөмж, буюу egazar цахим системийн өөртөө үйлчлэх ухаалаг /киоск/ төхөөрөмжийг худалдан авч байгууллага дээрээ байрлуулан ажиллуулж байна. Тус киоск нэвтэрснээр иргэд, аж	100

									ахуйн нэгж, байгууллагууд газар эзэмших ашиглах эрхийн гэрчилгээ, кадастрын зураг, газрын төлөв хянан баталгааны дүгнэлт, газрын барьцаа, төлбөрийн мэдээлэл зэрэг 18 төрлийн үйлчилгээг хурдан хугацаанд авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Байгууллагын цахим хуудас болон олон нийтийн цахим сүлжээгээр 2023 оны аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалт, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний мэдээлэл, түүнтэй холбоотой хууль эрх зүйн мэдээлэл, шилэн данс, хүний нөөц, төсөв санхүүгийн ил тод байдал, цахим үйлчилгээ болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 137 мэдээ, мэдээллийг сурталчилж 36546 хандалтыг авсан байна.	
153.	ТЖҮЧ 8.3.3 ЗДҮАХ 5.2	Шинээр хэрэгжүүлэх “Эрдэнэт хотын дэд бүтцийн төслүүд”-ийн хүрээнд орон сууцны дулаан алдагдлыг бууруулах төсөл, Гэр хорооллын ИШС-г өргөтгөх төсөл, Орлогод нийцсэн орон сууц төслийн ТЭЗҮ боловсруулах	ТЭЗҮ судалгааны ажил эхлүүлэх	Судалгаа хийх ажлын удирдамж боловсруул агдсан.	ТЭЗҮ судалгааны ажил эхэлсэн байна.	-	-	ХБТХОХ	Эрдэнэт хотын дэд бүтцийн төслүүдийн ТЭЗҮ судалгааг Sweco (Дани ба Швед), BDO (Румын), Мон-Энержи (Монгол) ба Монконсалт (Монгол)-ын хамтарсан Зөвлөхийн баг хийж байна. Зөвлөхүүд аймаг, ЭУДТС, банк болон бусад оролцогчидтой хамтран ажиллаж судалгааны үр дүнг Банканд хүлээлгэн өгсөн. Банкны экспертүүд салбар тус бүрээр судалгааны дүнд анализ хийх, хяналт шинжилгээ хийж ажил явагдаж байна. Эрдэнэт хотын дэд бүтцийн шинэ төслүүдийн хүрээнд хийгдсэн ТЭЗҮ судалгааны урьдчилсан дүнгийн талаар 2023 оны 04 дүгээр сард ЕСБХБ-ны зөвлөхүүд Орхон аймагт ажиллаж холбогдох газруудтай уулзалт хийсэн. Судалгааны дүнг эцсийн байдлаар гаргахын тулд талууд төсөл тус бүрээр хамтарсан цахим уулзалт хийгээд байна.	100
154.	ТЖҮЧ 8.3.3 ЗДҮАХ 5.2	Орон сууцны хорооллуудын ИШС-г үе шаттайгаар шинэчлэх	ИШС-г үе шаттайгаар шинэчлэх	123.7км	40%	910.0 1326.9	Улсын төсөв Орон нутгийн төсөв	ХЗА ХББЗА	2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хотын нийт орон сууцууд болон ААНБ-ыг төвлөрсөн дулаан хангамжаар хангадаг 3.5 км төв дулааны шугамыг ф720 мм-ын шугамаар өргөтгөн барихаар улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн дүнтэй ажлын гүйцэтгэл 65 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. 2023 онд Баянцагаан багт цагаан байрны айл өрхүүдийн шугам сүлжээг шинэчлэх ажилд 30.0 сая төгрөг, Говил баг Эрх бүжинхэн цэцэрлэгийн дотор халаах хэрэгслийг шинэчлэх ажилд 79.9 сая төгрөг, 186-р ангийн гадна ИШС-г шинэчлэх ажилд 253.0 сая төгрөг, нийт 442.9 сая төгрөг батлагдсан. Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр Бүрэнбүст багийн цэвэр усны шугамын ажилд 691.1 сая төгрөг, Уурхайчин багийн цэвэр усны шугамын ажилд 833.5 сая төгрөг, Хүрэнбулаг багийн УДДТ №4-2-ын гадна 5 хос 1км шугам шинэчлэх ажилд 1.0 тэрбум төгрөг тус тус батлагдсан ба одоогоор тендер сонгон шалгаруулалтын ажил явагдаж байна. Мөн аваарын байдалтай байсан ДГТ-3-р байрны подвалын ИШС-г шинэчлэх ажилд 79.9 сая төгрөг, Уурхайчин багт хот дахин төлөвлөлтийн барилгажуулах төслийн цэвэр усны шугам шилжүүлэх ажилд 243.6 сая төгрөг, Уртын гол багт баригдсан 260 айлын орон сууцны УДДТ-д нэмэлт тоноглол суурилуулах ажилд 36.7 сая төгрөг, Эко хорооллын гадна шугам сүлжээний шинэчлэлт, засварын ажилд 543.8 сая төгрөг нийт 904.0 сая төгрөгийг болзошгүй аваарын зардлаас шийдвэрлэн хийж гүйцэтгэлээ	90
155.	ТЖҮЧ 8.3.3 ЗДҮАХ 5.2	Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд дулааны шугам сүлжээнд горимын тооцоог тогтмол хийх	Горимын тооцоог тогтмол хийх	-	100%	95.0	Орон нутгийн төсөв	“ЭДЦС” “ЭУДТС” ОНӨХК	2021 оны орон нутгийн 95.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хотын хэмжээнд байгаа дулааны шугам сүлжээнд горимын тооцоог хийх зөвлөхөөр ШУТИС-ын судалгааны баг шалгарч ажлыг гүйцэтгэн горим тооцоог боловсруулан хүлээлгэн өгсөн. Мөн хангагч байгууллага "ЭДЦС"ТӨХК, "ЭУДТС"ОНӨХК хотын	100

									шугам сүлжээнд жил бүр үзлэг шалгалт, горим тохируулга хийж, тухай бүр хэрэглэгчдийн ачаллын тооцоог хийж ажиллаж байна.	
156.	ТЖҮЧ 8.3.3 ЗДҮАХ 5.2	Хотын шугам сүлжээнд эрсдэлийн үнэлгээг хийж цаашид авах шаардлагатай ажлын төлөвлөгөөг гаргах	Төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлсэн байна	-	50%	-	-	“ЭДЦС” ТӨХК, “ЭУДТС” ОНӨХК	Эрдэнэт хотын 2023-2024 онд дэд бүтцийн чиглэлээр хэрэгжүүлэх "Өвөлжилтийн бэлтгэл ажил"-г хангах ажлын төлөвлөгөө Нийт гүйцэтгэл 93.9 хувьтай хэрэгжиж байна. Хотын дулаан хангамжийн горимын тооцоог 2021 онд хийж гүйцэтгэн инженерийн хангамжийн байгууллагууд мөрлөг болгон ашиглаж байна. 2023-2024 оны өвөл хотын дулаан хангамжийг батлагдсан горимын дагуу халаалтыг өгөх ажлыг "ЭУДТС" ОНӨХК, "ЭДЦС" ТӨХК хамтран хэрэгжүүлж байна.	90
157.	ТЖҮЧ 8.3.7 ЗДҮАХ 5.2	Олон нийтэд хог хаягдлын талаар боловсрол олгох, үүрэг хариуцлага оролцоог нэмэгдүүлэх, сургалт зохион байгуулах	Иргэдийн оролцоо нэмэгдсэн байна.	Иргэдийн оролцоог 10%-иар нэмэгдүүлсэн.	Иргэдийн оролцоог 10%-иар нэмэгдүүлэх	-	-	ХЗА	Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд 2023 онд "Иргэн иргэндээ-хөрш хөршдөө" нөлөөлье хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөн Баян-Өндөр сумын 1050 хөршийн холбооны ахлагч нарыг чадавхжуулах ээлжит сургалтыг 2023 оны 02 дугаар сард зохион байгуулаа. Тус сургалт, үйл ажиллагаагаар Сургалтын ЛАБ-ын сургагч багш хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр хөршийн холбоодын ахлагч нарыг мэргэшүүлэх, чиглүүлэх ажлыг зохион байгуулсан. Үүнд: - Орон нутгийн хөгжлийн бодлогуудад иргэдийн саналыг тусгах үйл ажиллагааг хөршийн ахлагч нараар дамжуулж хүртээмжтэй болгох - Хог хаягдлын талаар иргэдийн дадал, хандлага өөрчлөх - Иргэдтэй ажиллахад шаардлагатай ур чадварт суралцуулах - Хөршийн ахлагч нар хамтран санаачилж, ажил хэрэгжүүлэхэд нь дэмжих - Хөршийн ахлагч нарыг иргэд, олон нийтэд таниулах зэрэг ажлуудыг зохион байгуулаад байна.	100
158.	ТЖҮЧ 8.3.4	Гэр хороолол болон орон сууцны хатуу хучилттай авто замын сүлжээ болон уулзваруудыг өргөтгөх	Хатуу хучилттай авто замын сүлжээ болон уулзваруудыг өргөтгөсөн байна.	103 км хатуу хучилттай зам өргөтгөсөн.	Авто замын сүлжээ нэмэгдсэн байна.	5,604.6	Орон нутгийн төсөв	ХБТХОХ	Хатуу хучилттай авто замыг нэмэгдүүлэх, өргөтгөл шинэчлэлтийн ажлын хүрээнд: 2021 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 7.2 км авто зам, 2022 онд 2.1 км авто замыг бүрэн ашиглалтад оруулсан байна. 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Яргуйт багийн авто замыг А1002 авто замтай холбох 299м, 5-17 дугаар байрны авто зогсоолыг 5-18 дугаар байрны авто зогсоолтой хүзүүвч хийх 35.5м, Эко хорооллыг 7-р хорооллын авто замтай холбох 20м, 7-р хорооллын дотор замтай холбох үлдэгдэл замыг хийх орц, гарц 95.6м, Рашаант баг 15, 16, 17, 19, 20-р гудамжинд орц гарц хийх 50м, Их залуу баг, 15-р сургуулийн авто зогсоолоос 23-р цэцэрлэгийн хажуугийн авто замтай холбох 131.4м ажил, Оюут баг, "Ачит" худалдааны төвөөс 2-40А байрны урдуур А1001 замтай холбох 547м авто зам, Баянбулаг, Булаг багийн нутаг дэвсгэрт ус түгээх 2-р цэг хүртэлх 700м хатуу хучилттай гэрэлтүүлэг, явган хүний зам бүхий иж бүрэн нийт 1.9 км авто замыг дуусгаж ашиглалтад оруулаад байна. Танил зах орчмын авто замын сүлжээг холбох хатуу хучилттай 2.29м зам, Захиргааны 4 дүгээр байрны /0.395 км/ уулзварын өргөтгөлийн ажлууд тус тус хийгдэж байна. 2023 онд Баянцагаан багт 1680 м, Говил багт 475м, Дэнж багт 1000 м, Эрдэнэ багт 1690 м, Даваат баг Ундаргын 3-8-р гудамжинд 1560 м, Яргуйт багт 2710м, Наран багт 2410 м, Рашаант багт 2690 м, Булаг баг 350м, Их залуу багт 9955м, ББ парк хотхоныг асфальтан замаар төв замтай холбоход 550м, Шанд багт 2660 м, Цагаанчулуут багт сайжруулсан шороон зам засварлах 1250 м, Хөшөөт, Айргийн хөндий, Арцат, Согоотын	100

									даваны зам засварлах 1.1 км нийт 30 км сайжруулсан шороон замыг хийж гүйцэтгэсэн байна. Мөн Даваат багийн Зураа хэсэгт 1, Шанд багийн 20 дугаар гудамжны баруун үзүүр, 35, 36 дугаар гудамжны дунд 1ш, Эрдэнэ багийн 2, 25 дугаар гудамжны үзүүрт 1 ширхэг нийт 3 ширхэг авто машины гүүрэн гарцыг ашиглалтад оруулсан.	
159.	ТЖҮЧ 8.3.4 ЗДҮАХ 5.10.3	Авто замын нөхөөс, гарц, тэмдэг, тэмдэглэгээг үе шаттайгаар хийх	Нөхөөс, гарц, тэмдэг, тэмдэглэгээг үе шаттай хийх	Хот доторх авто замын нөхөөс, тэмдэг, тэмдэглэгээг үе шаттайгаар хийж эхлүүлсэн.	3000 м.кв талбайд нөхөөс, тэмдэг, тэмдэглэгээ хийгдсэн байна.	2,850.0	Орон нутгийн төсөв	ХБТХОХ	Аймгийн хэмжээнд 2021 онд 38 байршилд 3.2 км авто замд 4796м урт хэвтээ тэмдэглэгээ, 105 байршилд шинээр босоо тэмдэг, 217 босоо тэмдгийг сэргээн засварлаж 5073 м2 талбайд авто замын нөхөөсний ажил, 2022 онд 7200 тэмдэглэгээ сэргээх, 50 ширхэг тэмдэг шинээр суулгаж, 5089.7 м.кв талбайд авто замын нөхөөсний ажил тус тус хийж гүйцэтгэсэн байна. 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4 дүгээр хороллын 18 дугаар байрны арын замыг тусгаарлах 160 м тусгаарлах хашаа, Эрдэнэ багт авто зам дагуу 144 м туузан хашлага, авто замын сангийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр "Орхон АЗЗА" ТӨХК нь Оюут багт 54.42м2, Зэст багт 40.91м2, Уртбулаг багт 63.5м2, Уурхайчин багт 312.67м2, Чандмань багт 110.98м2, Дэнж багт 1026.5м2, Шанд багт 116,82, Их залуу багт 226,2м2, Жаргалант суманд 314м2, Барилгачдын талбайн авто зогсоолд хэсэгчилсэн нөхөөсийг 3808м2, БОЭТ-ийн хашаан дотор 2112 м2 талбайд, Үйлчилгээний төвийн урд хэсгийн авто зогсоолын 1851м2 талбайн нөхөөс, Баян-Өндөр сумын гэр хороолол болон орон сууцны хороллын 6475 м2 талбайд, нийт 16512м2 талбайд халуун асфальтбетоноор авто замын нөхөөсийг тус тус хийж гүйцэтгэсэн байна. Мөн сургууль цэцэрлэг орчмын явган хүний гарц, сургууль орчмын бүсийн тэмдэг, гэр хороолол, төв зам дагуу нийт 125 ширхэг босоо тэмдгийг 33.8 сая төгрөгөөр, Барилгачдын талбайн уулзвараас 5-р хороллын уулзвар хүртэлх 17724 м газарт авто замын хэвтээ тэмдэглэгээ, сургууль цэцэрлэг орчмын 103 байршилд 22703 м явган хүний гарцын тэмдэглэгээг тус тус 256.5сая төгрөгөөр хийж бүрэн дуусан. 2023 онд нийт 16512 м2 талбайд халуун асфальтбетоноор 1.28 тэрбум төгрөгөөр, 40427м хэвтээ тэмдэглэгээ, 125ш авто замын босоо тэмдэг, тэмдэглэгээ, туузан хашлагыг 1.57 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.	100
160.	ТЖҮЧ 8.3.3 ЗДҮАХ 5.6	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж, ашиглалтын дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх	Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна.	Эрдэнэт хотын бохир усны 3-р төв шугамын шинэчлэлтийн ажил эхэлсэн.	Эрдэнэт хотын бохир усны 3-р төв шугамтай болсон байна.	4,100.0	Улсын төсөв	ХБТХОХ	Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй ариутгах татуургын 3-р коллекторын төв шугамын ажлыг Комфорт Импекс ХХК гүйцэтгэн 2022 онд 10.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. 2023 онд 4.1 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр бадлагдан хэрэгжиж Ф200-Ф600мм-ийн гол шугам 3.6км, салбар шугам 2.55км, 1500мм-ийн 73ш худаг шугамын угсралт, дулаалга, нягтруулалт зэрэг үе шатны ажлууд хийгдэж 65 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.	70
161.	ТЖҮЧ 8.3.4 ЗДҮАХ 5.10.3	Хот доторх авто зам, авто зогсоол явган хүний зам болон дугуйн зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдрах орчныг сайжруулах	Иргэдийн амьдрах орчныг сайжруулсан байна.	103 км хатуу хучилттай авто зам	Авто замын зогсоол 8000 м^2, явган, дугуйн зам 20 км нэмэгдэх зураг төсөл боловсруулах,	6,210.0	Орон нутгийн төсөв	ХБТХОХ	2021 онд 8 байршилд 4209 м2, 2022 онд 10 байршилд 7250 м2 авто зогсоолыг ашиглалтад оруулсан байна. 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар авто зогсоолыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Найрамдал өндөрлөг, Их шүтээн цогцолборын 3025 м2 авто зогсоол, Ундаргын 3-р гудамж, 17-р сургуулийн ард тал Соёлын төвийн дэргэд 1395 м2 авто зогсоол, 4-25 дугаар байрны 320 м2 авто зогсоол өргөтгөх, 11-р хороолол "Тамирын 3 чулуу" байрны зүүн талын автомашины 417.5 м2 зогсоол, Орон сууцны 1-р хороллын 25-р байрны гадна 323 м2 зогсоолыг өргөтгөх, 4-р хороллын 8 дугаар байрны урд талд	100

									417.5 м2 талбай бүхий 6 байршилд нийт 5898 м2 авто зогсоолыг шинээр барьж ашиглалтад оруулаад байна.MNS 5682:2006 "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам", техникийн шаардлага, стандартын хүрээнд Ерөнхий архитекторын баталсан зургийн дагуу орон нутгийн төсвийн 2.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2-1 а,б, 2-11 а,б, дугуй дэлгүүрийн зүүн талаар явган хүний зам, Баянцагаан, Рашаант, Даваат, Булаг багт жишиг гудамж тохижуулж байгуулах, Дэнж багт 49-р байрны гадна талбайн тохижилт бүхий хөл бөмбөгийн талбай байгуулах, Наран багийн гудамжны тохижилт, Хүүхдийн ордны гадна талбай, Бүрэнбүст багт гадна талбай, Захиргааны 2 дугаар байрны арын талбай, Хүрэнбулаг багийн гадна талбайн тохижилт, Оюут багийн 2 дугаар байрны ард явган хүний зам, байрнууд дунд дугуйн зогсоол, аймгийн төвийн хэсэгт дугуйн зам хийх зэрэг ажлуудыг тус тус нийт 14 багийн 16 байршилд төлөвлөн хийж гүйцэтгэсэн.Хотын хэмжээнд нийтийн эзэмшлийн явган зам 145350 м2 талбайд хүрээд байна.	
162.	ТЖҮЧ 8.3.5 ЗДҮАХ 5.6	Хот, суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх.	Үерийн далан суваг, ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлсэн байна.	Барилгажилтын төсөл, хот суурин газрын дахин хөгжүүлэх төсөл боловсруулагдсан	Ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	163.9	Орон нутгийн төсөв	ХЗА ГХБХБГ	2023 оны байдлаар аймгийн хэмжээнд 72.8 км шороон үерийн суваг байгаагаас инженерийн хийцлэлтэй 10.2 км, далд 11,0 км, 51.6 км нь байгалийн гуу жалга болон авто замын ус зайлуулах хаялага байна. 2023 онд аймгийн болзошгүй аваарын зардлаар Их залуу багийн Баруун задгай 18, 19 дүгээр гудамжинд 165м суваг, Даваат багийн Зураагийн 1, 2 дугаар гудамжинд 153м суваг шинээр хийхэд орон нутгийн төсвөөс 163.9 сая төгрөгийг зарцуулан ашиглалтад оруулаа.	100
163.	ТЖҮЧ 8.3.5 ЗДҮАХ 5.6	Барилга байгууламжийн ашиглалтын төлөв байдалд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, паспортжуулах ажлыг үе шаттай зохион байгуулах	Паспортжуулсан барилгын тоо нэмэгдсэн байна.	-	Сургууль цэцэрлэгийн 4 барилга паспортжуулсан байна.	40.0	Орон нутгийн төсөв	ХБТХОХ	2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр Барилга байгууламжийн ашиглалтын төлөв байдалд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, паспортжуулалт гэрчилгээжүүлэх ажлын даалгаврыг боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулж худалдах, худалдан авах ажиллагаа хийгдэж байна. Энэхүү ажлын даалгаварт Жаргалант сумын сургууль, цэцэрлэгийн барилгыг гэрчилгээжүүлэхээр тусгагдсан. Мөн орон сууцны 11, төрөл бүрийн зориулалтай олон нийтийн 9, сургууль цэцэрлэгийн барилга 2, инженерийн шугам сүлжээ 5 нийт 27 барилга ашиглалтад орж паспортжуулсан.	70
Зорилт 8.4. Аялал жуулчлалын маркетинг болон менежментийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, бүтээгдэхүүн үйлчилгээний соёл, чанар, стандартыг сайжруулж, жуулчдад зориулсан мэдээллийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, байгаль орчинд ээлтэй, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.										
164.	ТЖҮЧ 8.4.1 ЗДҮАХ 6.2	Стандарт ханган үйл ажиллагаа явуулж буй газруудыг зэрэглэлд хамруулах ажлыг зохион байгуулах	Зэрэглэлтэй зочид буудлын тоог нэмэгдүүлнэ.	Зэрэглэлтэй зочид буудал -3, жуулчны бааз-1	Зэрэглэлтэй зочид буудлыг 1-ээр нэмэгдэнэ.	-	-	ХБТХОХ	Аймгийн хэмжээнд 532 ор бүхий 25 зочид буудал, 10 дэн буудал үйл ажиллагаа явуулж байгаагаас 3 одны зэрэглэлтэй 2 зочид буудал, 1 одны зэрэглэлтэй 1 зочид буудал, 2 цэцгийн зэрэглэлтэй 1 амралтын бааз үйл ажиллагаа явуулж байна. Шинээр Соррег зочид буудал ашиглалтад орж зэрэглэлийн стандартыг хангаж байгаа боловч 2024 онд хүсэлтээ өгөх боломж бүрдээд байна. Зэрэглэл авахаар бэлтгэж буй зочид буудлуудын үйл ажиллагааг орон нутгийн ажлын хэсэг шалгаж стандартын хэрэгжилтийг үнэлж бүрэн хангасан байх зөвлөмжийг өгсөн.	70
165.	ТЖҮЧ 8.4.4 ЗДҮАХ 6.1	Аялал жуулчлалын үйлчилгээний стандарт, удирдлагын ур чадварыг сайжруулах сургалт зохион байгуулах	Сургалт зохион байгуулагдсан байна.	Мэргэжилтэй ажиллагсад 250	Мэргэжилтэй ажиллагсад 400	-	-	БОАЖГ	БОАЖСайдын 2023 оны 02 дугаар албан даалгаврын хүрээнд Орхон, Булган аймгийн нутаг дэвсгэрт болон хил залгаа нутгаар байрлах амралт, сувиллын газруудын нүхэн жорлон, хог хаягдлын менежментийг сайжруулах зөвлөгөөнийг Таны өөрчлөлт-Бидний ирээдүй уриан дор Булган аймгийн БОАЖГ-тай хамтран зохион	100

									байгууллаа. Зөвлөгөөнд 80 орчим иргэн ААНБ оролцож, ариун цэврийн байгууламжийг шинэчлэх, шинэлэг техник технологийг нэвтрүүлэх чиглэлээр ШУТИС-ийн усны судалгааны төвийн захирал доктор Д.Баасандорж, Монголын тогтвортой хөгжлийн гүүр ТББ-ын тэргүүн Д.Өлзийбилэг, Алтай-эколос компани болон Хаан, Төрийн банкуудын төлөөлөл оролцож Ногоон зээлийн санхүүжилтийн талаар мэдээлэл өглөө. "Зочлох үйлчилгээний салбарын ажилтнуудыг чадавхжуулах" сургалтыг МУИС-ийн "Аялал жуулчлалын хөтөлбөр"-ийн багш нартай хамтран салбарын ажил үйлчилгээний чанарыг сайжруулах, стандартыг мөрдүүлэх, байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, зочлох үйлчилгээний салбарын ажилчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, үйлчилгээний соёл, найрсаг харилцаа хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн сургалтыг зохион байгуулж нийт 73 хүнийг мэргэшүүлэх сургалтад хамрууллаа.	
166.	ТЖҮЧ 8.4.4 ЗДҮАХ 6.3	Эрдэнэт хот руу тусгай хөтөлбөр бүхий галт тэрэгний аяллын брэнд бий болгох.	Галт тэрэгний аяллын брэнд бий болгож, хэрэгжүүлэх	2 удаа аялал	5 удаа	-	-	БОАЖГ	Хил орчмын аялал жуулчлалын К-3 визний зөвшөөрөл бүхий жуулчдад зориулсан 72 цагийн аяллын маршрутыг гарган БОАЖЯаманд хүргүүллээ. Мөн Баян-Өндөр хайрхан /1.4га/ болон Эрдэнэт хаалга /3.4га/ орчимд аялал жуулчлалын бүс болгох, шинэ маршрут бий болгох ажлын хүрээнд ерөнхий төлөвлөлтийн зургийг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүллээ. Бүх ард түмний өвлийн спортын наадам, Хамтдаа Эрдэнэтэд хөгжье Эдийн засгийн форум, Зэс фестиваль зэрэг арга хэмжээнүүдэд ирсэн зочид төлөөлөгчдийг нэгдсэн зохион байгуулалттай зочид буудалд байрлуулах, хооллох, худалдаа үйлчилгээний төвүүдээр үйлчлүүлэх боломжийг бүрдүүлж, Эрдэнэт хотыг танилцуулах "City tour" аяллыг 5 төрлийн маршрутаар зохион байгуулж ажилласан.	30
167.	ТЖҮЧ 8.4.4 ЗДҮАХ 6.4	Аялал жуулчлалын эвент арга хэмжээ, адал явдалт аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлыг мэргэжлийн холбоо, клубүүдтэй хамтран зохион байгуулах.	Аялал жуулчлалын эвент арга хэмжээ зохион байгуулсан байна.	-	2 удаа	48.4	Орон нутгийн төсөв	ХБТХОХ БОАЖГ	Монголын бүх ард түмний өвлийн спортын 16 дугаар наадам, Монголын хүүхдийн спортын 7 дугаар наадам Нөхөрлөл-Тэмүүлэл-Амжилт уриан дор зохион байгуулагдсан ба 12 аймаг нийслэлийн 7 дүүргийн 722 тамирчдыг оролцуулсан тэмцээнд оролцогчдыг нэгдсэн зохион байгуулалттай зочид буудлуудад байрлуулж, нэгдсэн хоол ундаагаар үйлчлэх, Эрдэнэт хотыг танилцуулах "City tour" аялал, 3 цэгт худалдаа үйлчилгээ, Эрдэнэтийн гар урлал бэлэг дурсгалын бүтээгдэхүүн худалдаалах цэгүүдийг тус тус ажиллуулж бүх нийтэд хүргэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн худалдаа үйлчилгээний байгууллагуудыг уртасгасан цагаар ажиллуулах шийдвэрийг гаргуулан аймгийн ахуйн үйлчилгээний газрууд, зочид буудал, ресторан зоогийн газрууд, хүргэлтийн үйлчилгээний мэдээллээр ханган тамирчид байрласан нийт 20 орчим цэгт хүргэлтийн үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгууллаа. Казак түмний үндэсний баяр болох Наурызын баярыг тохиолдуулан тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор 03 дугаар сарын 18-ны өдөр Засаг даргын 2023 оны А/142 тоот захирамжийн дагуу Бүргэдийн баяр-2023 эвент арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд 12 бүргэдчин Баян-Өлгий аймгаас хүрэлцэн ирж Орхон аймагт анх удаа хамтарсан арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд 8000 орчим хүн оролцож, орон нутгийн бизнес эрхлэгчид орлого олох боломжийг бүрдүүлэн ажилласан. Мөн Зэс фестиваль эвент арга	100

									хэмжээг аймгийн томоохон 5 үйлдвэр, 16 аж ахуйн нэгж байгууллагатай хамтран зохион байгуулж 10.0-12.0 мянган хүн үзэж сонирхон, 23 сая төгрөгийн орлого төвлөрсөн.	
Зорилго 8.5 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ.										
168.	ТЖҮЧ 8.5.1. ЗДҮАХ 4.2.	Хүн амын хаврын хэрэгцээнд нөөцийн мах бэлтгэн борлуулах, хяналт тавьж ажиллах.	Нөөцийн мах бэлтгэн борлуулах, хяналт тавьж ажиллах.	2022 150тн борлуулж, 33 цэг, 1 үйлдвэрт хяналт хийсэн.	300тн борлуулах, явцын хяналт 14 хоногт 1 удаа, өдөр тутмын хяналтыг 7 хоногт 3 удаа хийнэ.	-	-	ХБТХОХ, ХХААГ,	2023 оны хаврын махны нөөц бэлтгэхэд 500.0 сая төгрөг батлагдсан. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу нөөцийн мах бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер зарласан боловч хүчингүй болж, дахин тендер зарлах нь нөөцийн мах бэлтгэгдэн худалдаанд гарах цаг хугацааны хувьд боломжгүй, мах борлуулах хугацаа хоцорч үр дүнгүй ажил болох болсон тул орон нутгийн төсвөөс хөрөнгө зарцуулан нөөцийн мах бэлтгэж худалдаанд гаргаагүй. Орон нутгийн төсвөөс нөөцийн мах бэлтгэн худалдаанд гаргаагүй ч “Өвлийн идэш” арга хэмжээгээр иргэд 63.5 тонн малын мах худалдан авснаар өвлийн идшээ хямд нөөцлөх боломж бүрдсэн. Мөн аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 3 махны үйлдвэр өөрсдийн нэрийн дэлгүүрээр 150 тн мах зах зээлд нийлүүлснээр 2023 онд хаврын улиралд аймгийн хэмжээнд махны хомсдол үүсээгүй.	30
169.	ТЖҮЧ 8.5.1. ЗДҮАХ 4.2.	“Өвлийн идэш-2023” мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний өргөтгөсөн худалдаа зохион байгуулах	“Өвлийн идэш-2023” өргөтгөсөн худалдаа зохион байгуулсан байна.	1 удаа	1 удаа	4.6	Орон нутгийн төсөв	ХБТХОХ ХХААГ	"Өвлийн идэш" арга хэмжээг 2023 оны 12 дугаар сард Наадмын талбайд 3 хоног зохион байгуулж Орхон, Архангай, Булган, Хөвсгөл, Завхан, Увс аймгийн 35 малчин, махны бөөний худалдаа эрхлэгчид оролцож, 63.5 тонн малын мах борлуулагдсан нь иргэд өвлийн идшээ хямд нөөцлөх боломж бүрдсэн.	100
170.	ТЖҮЧ 8.5 ЗДҮАХ 4.2, 7.3.	ХАА-н салбарын үйл ажиллагааг тогтмол сурталчлах, иргэдэд мэдээлэл хүргэх цахим хуудас (веб сайт) ажиллуулах	Цахим хуудас ажиллуулж, мэдээллээр хангасан байна.	-	Цахим хуудас хийснээр иргэдэд хүрэх мэдээллийн хүртээмж сайжрах.	-	-	ХХААГ	2024 онд байгууллагын төсөвт цахим хуудас "Веб сайт" хийлгэхэд шаардлагатай 15.0 сая төгрөгийг тусгуулахаар санал өгсөн. Одоогийн байдлаар "Орхон аймаг. Хүнс, хөдөө аж ахуйн газар" page хуудсаар дамжуулан мэдээллийг олон нийтэд хүргэж байна.	90
171.	ТЖҮЧ 8.5. ЗДҮАХ 7.3.3	ХАА-н салбарын өвөлжилт, хаваржилтын ажлыг зохион байгуулах, аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх	Өвөлжилтийн бэлтгэл хангах	Бэлтгэл 90-ээс дээш хувь хангагдсан. 25тн өвс, 77,5 тн тэжээл бэлтгэсэн.	Бэлтгэл 95%	175.0	Орон нутгийн төсөв	ХХААГ	2022 онд аймгийн аюулгүйн нөөцөд 100 тн өвс, 37.5 тн тэжээл, сумдын аюулгүйн нөөцөд 118 тн өвс, 35.9 тн тэжээл, нийт 218 тн өвс, 73.4 тн тэжээл бэлтгэж аймаг, сумын аюулгүйн нөөцийг 100 хувь бэлтгэсэн. Аймгийн хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын 32 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 15/02 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ жил аймгийн аюулгүйн нөөцөд өвс 200 тн, тэжээл 86.1тн-ыг бүрдүүлэхээр төлөвлөж, аймаг, сумдын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг 100 хувь бүрдүүллээ. Аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бэлдэхэд орон нутгийн төсвөөс 75.0 сая төгрөг, Баян-Өндөр, Жаргалант сумдын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бэлдэхэд орон нутгийн төсвөөс тус бүр 50.0 сая төгрөг зарцуулсан.	100
172.	ТЖҮЧ 8.5.3.	Үржлийн хээлтэгч, цөм сүргийн хээлтэгч малд үзлэг, ангилалт хийх,	Үзлэг, ангилалт, бүртгэлжүүлэ	37,0 мянган толгой малд үзлэг,	Нийт малын 60-аас доошгүй	9.5	Орон нутгийн төсөв	ХХААГ	Орон нутагт үржүүлж байгаа үүлдэр, омог, хэвшлийн малын ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор адуун сүргийг хурдны чиглэлээр, үхэр сүргийг Сэлэнгэ, Алатау, Семменталь, Хар тарлан үүлдрээр,	100

	ЗДҮАХ 7.3.3	төвийн бүсийн үхэр сүргийг ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх	лт хийсэн байна.	баталгаажуулалт хийж, 2,0 мянган толгой малыг нэгдсэн санд бүртгэлжүүлсэн.	хувьд үзлэг, бүртгэлжүүлэлт хийнэ.				хонин сүргийг Монгол, Баяд, Барга хуцаар, ямаан сүрэгт Өлгийн улаан, Эрчмийн хар ухна зэргийг үндсэн сайжруулагчаар ашиглаж байна. 2022 онд аймгийн хэмжээнд 37000 толгой малд үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт хийсэн бөгөөд 668 толгой хээлтүүлэгч, 36332 толгой хээлтэгчийг хамруулсан. Нийт 5.6 мянган толгой малыг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. 2023 оны эхэнд бог малын 848 толгой хээлтүүлэгч тоологдсоноос 85.4 хувь буюу 724 толгой хээлтүүлэгчийг 4 суурьт ялган төвлөрүүлсэн. Аймгийн хэмжээнд 37.5 мянган толгой малд үзлэг ангилалт, 2.0 мянган толгой үхэрт ялган тэмдэглэгээ хийсэн. Нийт богийн 848 толгой хээлтүүлэгчид буюу хээлтүүлэгчийг 100 хувь, нийт богийн 58.9 мянган толгой хээлтэгчийн 36.8 мянган толгой буюу 62.4 хувийг хамруулан малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. Энэхүү ажилд орон нутгийн төсвөөс 9.5 сая төгрөг зарцуулсан.	
173.	ТЖҮЧ 8.5. ЗДҮАХ 7.3.3	Бэлчээрийн талбайд үлийн цагаан оготны тандалт судалгаа хийх, бэлчээрт ашиглагдаж буй худгийг сэргээн засварлах, шинээр гаргах	Бэлчээрийн усан хангамжийг сайжруулж, тандалт судалгаа хийх	4000га-д тандалт хийсэн. Шинээр 1 худаг гаргасан.	Тандалт судалгааг 5000 га-д хийх, 1 худаг шинээр, 2 худаг засварлах	290.9	Орон нутгийн төсөв	ХХААГ	Манай аймаг нийт 39.3 мянган га бэлчээрийн талбайтай ба үлийн цагаан оготны тандалт судалгааг 4000 га газарт хийж гүйцэтгэхэд үлийн цагаан оготны тархалт илрээгүй. Энэ онд 290.9 сая төгрөгөөр 5 худаг шинээр гаргаснаар 63 өрхийн 17.8 мянган толгой мал усаар хангагдаж бэлчээрийн усан хангамж 86.1 хувьтай байна.	100
174.	ТЖҮЧ 8.5.1. ЗДҮАХ 4.2, 7.2.3.	“Намрын ногоон өдрүүд-2023”, “Цагаан сар-2023” хүнс үйлдвэрлэгчдийн төрөлжсөн үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	Төрөлжсөн үзэсгэлэн худалдааг зохион байгуулна.	-	1 удаагийн арга хэмжээг зохион байгуулна.	6.0	Орон нутгийн төсөв	ХБТХОХ ХХААГ	Ногоочдын борлуулалтыг дэмжих зорилгоор Улаанбаатар хотод зохион байгуулсан "Үндэсний үйлдвэрлэл-Намрын ногоон өдрүүд-2023" үзэсгэлэн арга хэмжээнд Жаргалант сумын 3 тариаланчийг дэмжин оролцуулсан. "Цагаан сар-2023" хүнс үйлдвэрлэгчдийн төрөлжсөн үзэсгэлэн худалдааг 2 дугаар сард 3 хоног Худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран зохион байгуулсан.	100
175.	ТЖҮЧ 8.5.2. ЗДҮАХ 7.3.1.	Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Хөтөлбөрийг үргэлжлүүлнэ	Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэгч 500 өрх дэмжлэгт хамрагдсан байна.	500 өрх хамруулна	40.0	Орон нутгийн төсөв	ХХААГ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан "Өрхийн тариалалтыг дэмжих" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж жил бүр шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвт тусган ажиллаж байна. 2023 онд орон нутгийн төсөвт 40.0 сая төгрөг тусгаснаар хөтөлбөрт хамрагдсан Баян-Өндөр сумын 26 багийн 500 өрхөд 5 төрлийн үрийн багц олгож, төмс, хүнсний ногоо тариалах гарын авлагаар ханган, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 80 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр олгосон 13 төрлийн 2.6 тн үрийг 235 өрх, аж ахуйн нэгжид олгосноор нийт 735 өрх, аж ахуйн нэгж 8 га талбайд төмс, 140 га талбайд хүнсний ногоо тариалсан. Улсын төсвийн хөрөнгөөр "Үйлдвэрлэгч баг" төслийн хүрээнд 90 ширхэг, "Шинэ хөдөө-Орхон" төслийн хүрээнд 10 ширхэг, нийт 100 ширхэг хүлэмжийг иргэн, аж ахуйн нэгжид олгосноор хүлэмжийн талбай 1.2 га талбайгаар нэмэгдсэн. Энэ онд 5.1 га талбайд хүлэмжийн тариалалт хийж, 305 тн ургац хураан авснаар өмнөх оноос 55 тн-р нэмэгдсэн. Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран зохион байгуулсан "Хөдөө аж	100

									ахуйн технологи"-ийн сургалтад 45 өрхийн тариаланчийг хамруулсан. Тус хөтөлбөрийн хэрэгжилт 98.0 хувьтай хэрэгжиж байна.	
176.	ТЖҮЧ 8.5.2. ЗДҮАХ 7.3.1.	Газар тариалангийн ажлыг технологийн хугацаанд чанартай зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах	Газар тариалангийн ажлыг технологийн хугацаанд чанартай зохион байгуулна.	Үр тариа 4779 га, тэжээл 284 га, тосны ургамал 197 га, төмс 273 га, хүнсний ногоо 503 га, жимс 1,3 га, нийт 6037,3 га-д тариалсан	Технологий н хугацаанд чанартай гүйцэтгэж, мэргэжил арга зүйгээр хангах	-	-	ХХААГ	Аймгийн хэмжээнд 5364 га талбайд тариалалт хийхээр төлөвлөснөөс 12 аж ахуйн нэгж, 563 өрх нийт 5584 га талбайд тариалалт хийж, үүнээс үр тариа 3904 га, малын тэжээлийн ургамал 287, тосны ургамал 821 га, төмс 146 га, хүнсний ногоо 426 га-д тариалж, уринш боловсруулалт 3600 га талбайд хийж гүйцэтгэсэн. Ургац хураалтын ажлыг 5612 га талбайд хийж гүйцэтгэхээс 5612 га талбайд хийж хураалтын ажил 100 хувь хийж гүйцэтгэсэн. Үр тариа 3904 га талбайгаас 10892 тн буюу га-аас 28 цн ургац үүнээс улаан буудай 3805 га талбайгаас 10752 тн буюу 28 цн ургац, төмс 145 га талбайгаас 1628 тн буюу га-аас 112 цн ургац, хүнсний ногоо 455.2 га талбайгаас 9520 тн буюу га-аас 209 цн, тэжээлийн ургамал 287 га талбайгаас 1122 тн буюу га-аас 39 цн, тосны ургамал 821 га талбайгаас 300 тн буюу га-аас 3.7 цн ургац тус тус хураан авсан. Ургацын мэдээгээр тооцоход аймгийн хүн амын хэрэгцээт үр тариа 100 хувь, төмс 43.3 хувь, хүнсний ногоо 100 хувь орон нутгийн үйлдвэрлэлээр хангаж байна. Энэ намрын ургац хураалтад комбайн 15, хадагч /жатка/ 4, будаа цэвэрлэгч 8, үр сортлогч 5, будаа ачигч 7, төмсний комбайн 1, төмс, хүнсний ногоо ухагч 8, баталгаажуулсан электрон авто машины жин 3, механикжсан үтрэм 1, 11.0 мянган мкв талбай бүхий энгийн 5 үтрэм, 3700 тонн багтаамжтай 7 агуулах, 6548 тонн багтаамжтай 161 зоорь ажиллахаар бэлэн байдлыг ханган ажилласан. Улаан буудай борлуулалт: Гурилын үйлдвэр, Хөдөө аж ахуйн корпораци ТӨХК-д хүнсний буудай 8100 тонн, Улсын үрийн нөөц, Хөдөө аж ахуйн корпораци ТӨХК-д үрийн буудай 804 тонн, өөрийн үрийн нөөцөд 1042 тонн, малын тэжээлд 465 тонн тус тус нийлүүлсэн.	100
177.	ТЖҮЧ 8.5.2. ЗДҮАХ 7.3	Газар тариалангийн мэдээг нэгдсэн цахим бүртгэлд оруулах, мөнгөн урамшууллын материалыг цахимаар бүрдүүлэх, олгох, plant.mofa.gov.mn сайт руу мэдээллийг бүртгэх арга зүйн сургалт зохион байгуулах	Сургалт зохион байгуулсан байна.	1 удаагийн сургалтаар 154 тариаланчд ад мэдлэг олгосон.	1 удаа сургалт хийж, ном гарын авлагаар хангах	-	-	ХХААГ	Тариалангийн үйлдвэрлэлийн plant.mofa.gov.mn цахим системд аймгийн хэмжээнд 468 нэгж талбарын 5239 га тариалангийн талбай, 308 иргэн, 28 аж ахуйн нэгж, байгууллага бүртгүүлсэн. 2023 оны урамшууллын хүсэлтийг тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 563 иргэн, 12 аж ахуйн нэгж, байгууллагын тариалалтын мэдээллийг төрөл тус бүрээр нь аймгийн Статистикийн мэдээтэй тулган баталгаажуулах ажил хийгдсэн. 2022 оны ургац хураалтын цахимаар илгээгдсэн 175 удаагийн урамшууллын хүсэлтийн хариуд 900.0 сая төгрөгийн урамшууллыг 7 аж ахуйн нэгж, байгууллага, 135 иргэн авсан байна. Аймгийн малчид тариаланчдын зөвлөгөөнийг 2023 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр Жаргалант суманд зохион байгуулсан. ХХААХҮЯ-ны холбогдох албан тушаалтнууд зөвлөгөөнд оролцсон 180 хүнд plant.mofa.gov.mn сайт руу мэдээллийг бүртгэх талаар мэдээлэл өгч арга зүйгээр хангасан.	90
178.	ТЖҮЧ 8.5.4. ЗДҮАХ 7.3.3.	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг чадавхжуулах сургалтад хамруулах, туршлага судлах, шилмэл малын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжинэ.	-	2-оос доошгүй сургалт хийж, туршлага судалж,	5.8	Орон нутгий н төсөв	ХХААГ	2023 онд аймгийн хэмжээнд 168 иргэн эрчимжсэн мал аж ахуй эрхэлж өмнөх оноос 27.0 хувиар өссөн байна. Үүнд: 30 иргэн мах, сүүний чиглэлийн 370 толгой үхэр, 11 иргэн махны чиглэлийн 414 толгой үхэр, 2 иргэн 269 толгой махны чиглэлийн нарийн ноост хонь, 12 иргэн 590 толгой гахай, 78 иргэн 3195 толгой шувуу, 15 иргэн 329 бүл зөгий, 4 иргэн 96 толгой туулайг тус тус өсгөн	100

					үзэсгэлэн гаргасан байна.				үржүүлж байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, аймгийн Засаг даргатай 2023 онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсан бод, бог малын зохиомол хэлтүүлгийн техникч бэлтгэх сургалтад 4 иргэн хамрагдаж ур чадвараа дээшлүүлсэн. "Махны үхрийн аж ахуй эрхлэгчдийн зөвлөгөөн"-д махны үхрийн аж ахуй эрхэлдэг, эрхлэх сонирхолтой 9 иргэн, аж ахуйн нэгж, "Төв түмний сүүн соёл -2023" арга хэмжээнд сүүний үхрийн аж ахуй эрхэлдэг 5 иргэн, мах-ноосны чиглэлийн Суффолк үүлдрийн хонины аж ахуйтай танилцах аялалд 9 иргэн, нийт 23 иргэн, аж ахуйн нэгжийг тус тус хамруулан туршлага судлуулсан. Энэхүү ажилд орон нутгийн төсвөөс 5.8 сая төгрөгийг зарцуулсан. "Хөгжлийн шийдэл" ТББ-тай хамтран "Сүүний технологи, эрүүл ахуйн зохистой дадал" сэдэвт сургалтыг зохион байгуулж эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 15 иргэн, аж ахуйн нэгж оролцуулан мэдээллээр хангасан.	
179.	ТЖҮЧ 8.5.5. ЗДҮАХ 4.4.	Мал, амьтны халдварт, гоц халдварт, шимэгчтэх, бруцеллёз, лейкоз, адууны халдварт цус багадалт, ям өвчнүүд болон архаг халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх	Мал, амьтны өвчинтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2022 онд 112,2 мянган толгой мал, 900 толгой мал хэлтүүлэгчийг хамруулсан.	2023 онд 116,2 мянган толгой мал хамруулна.	15.8 100.3	Улсын төсөв Орон нутгийн төсөв	МЭГ	2023 онд мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 109.1 мянган толгой малыг 10 төрлийн вакцинд хамруулахаар төлөвлөж 111.9 мянган толгой мал, амьтныг хамруулсан. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад Мал эмнэлгийн ерөнхий газрын "Бог малын өвчинтэй тэмцэх стратеги"- төлөвлөгөөний дагуу 317 өрхийн 65.8 мянган толгой ямаа, 14.8 мянган толгой ишиг, 21.8 мянган толгой хурга, нийт 102.4 мянган толгой бог мал хамруулж 98.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна. Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хавар, намрын дархлаажуулалтад нийт 50.0 мянган толгой мал, амьтан хамруулж гүйцэтгэл 92 хувьтай хэрэгжсэн. Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 192.0 мянган толгой мал хамруулахаас боловсруулалтад 56.5 мянга, туулгалтад 62.6 мянга, угаалгад 78.5 мянга, нийт 197.6 мянган толгой мал сүргийг хамруулж гүйцэтгэл 100 хувь хэрэгжсэн. 2023 онд бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 24.0 мянган толгой бог мал хамруулахаар төлөвлөж 23.9 мянган толгой бог малын төл хамруулж гүйцэтгэл 99.7 хувь хэрэгжсэн. Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор мал, амьтны зоонозын өвчинтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд "Бруцеллёзын хэлтүүлэгчийн тандалт-2023" шинжилгээ хийж гүйцэтгэх тандалт шинжилгээнд 176 өрхийн нийт 1194 хэлтүүлэгч мал хамруулахад 3.0 хувь нь эерэг урвал үзүүлсэн тул 7 хэлтүүлэгчийг хэрэгцээлүүлж, бусад хэлтүүлэгч малыг эрүүлжүүлэх арга хэмжээ авсан. Адууны нийлүүлгийн өвчний үүсгэгчийг илрүүлэх шинжилгээг 215 адууны цусны сорьцод хийж гүйцэтгэхэд 2.8 хувь нь халдварлалттай байна. ХХААХҮ-ийн сайдын 2012 оны А/54 дүгээр тушаалаар үхрийн сүрьеэ, лейкоз өвчнөөс эрүүлжүүлэх чиглэлээр аймгийн 6 фермерийн 200 үхрээс дээж цуглуулж Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторид хүргүүлээд байна. Адууны ям болон үхрийн сүрьеэ өвчний эрүүл бүс статус авахаар нийт 4400 малд харшил сорилын шинжилгээ хийж эрүүл бүсийг баталгаажуулсан.	100

180.	ТЖҮЧ 8.5.5. ТЖҮЧ 4.1.1. ЗДҮАХ 4.4.	Мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүнд антибиотек, пестицитийн үлдэгдлийг тодорхойлох, малын эмийн зохистой хэрэглээг хангах	Малын эмийн зохистой хэрэглээг хангах	7 төрлийн эмийн болон бусад үлдэгдэл, шинжилгээг элиза болон туузан сорилын урвалаар хийж гүйцэтгэсэн.	7 төрлийн эмийн болон бусад үлдэгдэл, шинжилгээг элиза болон туузан сорилын урвалаар хийж гүйцэтгэсэн.	4.2	Улсын төсөв	МЭГ	2022 онд 755 дээжид мал эмнэлгийн магадлан шинжилгээ, эмийн үлдэгдэл илрүүлэх шинжилгээ хийхэд нийт 7 дээж эерэг урвал үзүүлсэн тул устгасан. 2023 онд малын гаралтай хүнсний бүтээгдэхүүний 155 сорьцод 7 нэр төрлийн эмийн үлдэгдлийн шинжилгээ хийж гүйцэтгэхэд эмийн үлдэгдэл илрээгүй. 2021-2023 онд давхардсан тоогоор 19900 дээжид эмийн үлдэгдлийн болон мал эмнэлгийн лабораторийн магадлан шинжилгээ хийсэн байна.	100
181.	ТЖҮЧ 8.5.5. ЗДҮАХ 4.4.	Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургалтад хамруулах	Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах ажлыг зохион байгуулсан байна.	2022 онд ариутгал халдваргүй тлыг 527,7 мянган мкв талбайд хийсэн.	2023 онд 530,0 мянган мкв талбайд хийнэ	14.3	Орон нутгийн төсөв	МЭГ	2021-2022 онд нийт 587 толгой мал, амьтны сэг зэмийг цуглуулан зөөвөрлөж, хогийн төвлөрсөн цэгт зориулалтын нүхэнд булж устган, 576.8 мянган мкв талбайд ариутгал халдваргүйтгэлийг хийсэн. 2023 онд нийгмийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр аймгийн хэмжээнд нийт 2458 мал, амьтны сэг зэмийг устган 565.0 мянган м.кв талбайд ариутгал, халдваргүйтгэл хийсэн. Тус ажилд орон нутгийн төсвөөс 14.3 сая төгрөг зарцуулсан. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдаа эрхлэгч хуулийн этгээд, аж ахуйн нэгж, иргэдэд зориулсан сургалт мэдээллийг Эрүүл мэндийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран зохион байгуулж малаас хүнд дамжин халдварладаг "Зооноз" өвчин, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар мэдлэг олгосон. Тус сургалтад мах боловсруулах үйлдвэр, хүнсний зах, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн худалдаалах тусгай зөвшөөрөлтэй дэлгүүр, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч зэрэг нийт 35 хүн хамрагдсан.	100
НЭГТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ									**90.9**	